

## УНШИГЧ ЗАХИАЛАГЧДЫН АНХААРАЛД

Тус сэтгүүлийн 8—9 дүгээр сарын дугаарууд мөдхөн уншигч таны гарт саадгүй очих гэж байна. Харин хэвлэх үйлдвэрийн зардал болон цаасны үнийн өсөлтөөс шалтгаалан «Төрийн мэдээлэл» сэтгүүл IV улиралаас эхлэн үнээ ялимгүй нэмж нэг дугаарын үнэ 500 төгрөг (улиралаар бүгд 1500 төгрөг) болсныг анхааралдаа авахыг хүсье. «Ардын эрх», «Засгийн газрын мэдээ» зэрэг бусад сонин хэвлэл 1995 оны III улиралд дээрх шалтгааны улмаас захиалгын үнээ нэмсэн боловч «Төрийн мэдээлэл» сэтгүүл үнийн өөрчлөлт оруулаагүй юм.

Таны найдвартай туслагч, хууль зүйн үнэнч зөвлөгч «Төрийн мэдээлэл» сэтгүүлээ өргөнөөр захиалан уншигчгаана уу

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

ХУУЛЬ, ТОГТООЛ, ЗАРЛИГ, ШИЙДВЭР,  
ХУУЛИЙН ТАЙЛБАР

*Монгол Улсын Их Хурлын Тамгын газар*

№

1995 оны 7 сар

№ 7/38/

## ГАРЧИГ

### I. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1.	Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай	793
2.	Төрийн нууцны тухай	799
3.	Хувь хүний нууцны тухай	810
4.	Байгууллагын нууцны тухай	812
5.	Төрийн тусгай хамгаалалтын тухай	815
6.	Захиргааны хариуцлагын тухай хуульд зарим нэмэлт оруулах тухай	828
7.	Конвенцид ээгдэн орох тухай	829

### 2. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

8.	Төрийн нууцны тухай Монгол Улсын хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай №22	830
9.	Төрийн тусгай хамгаалалтын тухай Монгол Улсын хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай №23	830

## УНШИГЧ ЗАХИАЛАГЧДЫН АНХААРАЛД

Тус сэтгүүлийн 8—9 дүгээр сарын дугаарууд мөдхөн уншигч таны гарт саадгүй очих гэж байна. Харин хэвлэх үйлдвэрийн зардал болон цаасны үнийн өсөлтөөс шалтгаалан «Төрийн мэдээлэл» сэтгүүл IV улиралаас эхлэн үнээ ялимгүй нэмж нэг дугаарын үнэ 500 төгрөг (улиралаар бүгд 1500 төгрөг) болсныг анхааралдаа авахыг хүсье. «Ардын эрх», «Засгийн газрын мэдээ» зэрэг бусад сонин хэвлэл 1995 оны III улиралд дээрх шалтгааны улмаас захиалгын үнээ нэмсэн боловч «Төрийн мэдээлэл» сэтгүүл үнийн өөрчлөлт оруулаагүй юм.

Таны найдвартай туслагч, хууль зүйн үнэнч зөвлөгч «Төрийн мэдээлэл» сэтгүүлээ өргөнөөр захиалан уншигчана уу

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

ХУУЛЬ, ТОГТООЛ, ЗАРЛИГ, ШИЙДВЭР,  
ХУУЛИЙН ТАЙЛВАР

*Монгол Улсын Их Хурлын Тамгын газар*

№

1995 оны 7 сар

№ 7/38/

## ГАРЧИГ

### I. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1.	Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдамг шийдвэрлэх тухай	793
2.	Төрийн нууцны тухай	799
3.	Хувь хүний нууцны тухай	810
4.	Байгууллагын нууцны тухай	812
5.	Төрийн тусгай хамгаалалтын тухай	815
6.	Захиргааны хариуцлагын тухай хуульд зарим нэмэлт оруулах тухай	828
7.	Конвенцид нэгдэн орох тухай	829

### 2. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

8.	Төрийн нууцны тухай Монгол Улсын хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай №22	830
9.	Төрийн тусгай хамгаалалтын тухай Монгол Улсын хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай №23	830

- |     |  |     |
|-----|--|-----|
| 10. | Олон улсын конвенцид нэгдэн орсонтой холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай №24 | 831 |
| 11. | Улсын тусгай хамгаалалттай газрын ангилалыг шинэчлэн тогтоох тухай №26                           | 832 |
| 12. | Н.Өдзийхутагийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай №27  | 845 |
| 13. | Санжбэгзийн Төмөр-Очирыг Шинжлэх ухаан, боловсролын сайдвар томилох тухай №28                    | 845 |

### 3. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- |     |  |     |
|-----|--|-----|
| 14. | Мехико Фужимотог "Найрамдал" медалиар шагнах тухай №59                   | 846 |
| 15. | Намсрайн Төмөртогоод Монгол Улсын Хөдөлмөрийн баатар цол олгох тухай №62 | 846 |
| 16. | Ринчингийн Батнасанд Монгол Улсын гавьяат нисгэгч цол олгох тухай №63    | 847 |
| 17. | Иргэний агаарын тээврийн зарим ажилтныг одон, медалиар шагнах тухай №64  | 847 |
| 18. | Цэргийн нисэх хүчний зарим хүнийг одон, медалиар шагнах тухай №65        | 855 |

### 4. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

- |     |  |     |
|-----|--|-----|
| 19. | Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн нэг дэх хэсгийн зарим заалт Үндсэн хууль зөрчсөн тухай №01 | 857 |
|-----|--|-----|

### 5. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- |     |   |     |
|-----|---|-----|
| 20. | Журам батлах тухай №31                              | 861 |
| 21. | Шагналын тухай №33                                  | 868 |
| 22. | Барилгын талаар авах зарим арга хэмжээний тухай №35 | 870 |

- |     |  |     |
|-----|--|-----|
| 23. | Хорих байгууллагуудын талвар авах зарим арга хэмжээний тухай №37 | 872 |
| 24. | Төсөл шалгаруулах журам батлах тухай №38                         | 875 |

## 6. МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

- |     |   |     |
|-----|---|-----|
| 25. | Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн анхан шатны шүүхийн үйл ажиллагааг зохицуулсан зарим зүйл, хэсгийг тайлбарлах тухай №80 | 881 |
|-----|---|-----|

---

### СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ:

Брөнхий эрхлэгч	Н. Ринчиндорж
Нарийн бичгийн дарга	Сан.Жаргалсайхан
Гяшүүд	Т. Баасансүрэн Ч. Бавуу Б. Гаибат Б. Янжинлхам
Техник редактор	Т.Сарантуяа
Уншиж хянасан	Сан.Жаргалсайхан Б. Янжинлхам

Үйлдвэрт шилжүүлсэн 1995 оны 7-р сарын 3-нд. Өрөлтөд 1995 оны 7-р сарын 4-нд. Хэвлэлтэд 1995 оны 8-р сарын 12-нд. Хэвлэлийн хуудас 6,25. Хэвлэсэн тоо 4300.

Манай хаяг: Улаанбаатар-12, Төрийн ордон  
Утас: 322838

Засгийн газрын хэвлэх үйлдвэр

Засгийн газрын хэвлэх үйлдвэр

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 4 дүгээр  
сарын 17-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ИРГЭДЭЭС ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ГАРГАСАН ӨРГӨДӨЛ ГОМДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

##### Нийтлэг зүйл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хууль нь иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж өргөдөл, гомдол гаргах, түүнийг байгууллага, албан тушаалтнаас шийдвэрлэх үйл ажиллагааг зохицуулна.

2 дугаар зүйл Өргөдөл гомдлын тухай  
хууль тогтоомж

Өргөдөл гомдлын тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

1. Энэ хууль нь Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хариуцлагын тухай хуулиар шийдвэрлээд зохих өргөдөл, гомдолд хамаарахгүй.

2. Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасан асуудлаар гаргасан өргөдөл, гомдлыг уг хуульд заасан журмаар шийдвэрлэнэ.

3. Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, тэдгээрийн албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэхэд энэ хуулийн 13 дугаар зүйлийн 2 дахь заалт, 16 дугаар зүйлд заасан хугацааг баримтална.

4 дүгээр зүйл. Өргөдөл, гомдол

1. Улс нийгмийн ач холбогдолтой болон энэ зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас бусад асуудлаар төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан хүсэлтийг өргөдөл гэнэ. Өргөдөл нь хүсэлт, санал, мэдэгдэл, мэдээлэл, шаардлагын зэрэг шинжтэй байж болно.



2. Төрийн байгууллага албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаагаар иргэдийн хуулиар хамгаалагдсан эрх, эрх чөлөө, ашиг сонирхол зөрчигдсэн гэж үзэж сэргээлгэхээр гаргасан хүсэлтийг гомдол гэнэ.

5 дугаар зүйл. Өргөдөл, гомдол гаргах  
эрх

1. Монгол Улсын иргэн дангаар буюу хамтарч төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргах эрхтэй.

2. Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бод тус улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн өргөдөл, гомдол гаргах талаар Монгол Улсын иргэний адил эрх эдэлнэ.

6 дугаар зүйл. Өргөдөл, гомдол гаргагчийн  
эрх

Өргөдөл, гомдол гаргагч дараахь эрх эдэлнэ:

1/ гаргасан өргөдөл, гомдлынхоо хариуг авах;

2/ өргөдөл, гомдолтойгоо холбогдуулаж тайлбар, нотлох баримт гаргах;

3/ өргөдөл, гомдлоосоо татгалзаж буцаан авах;

4/ өгсөн хариуг зөвшөөрөөгүй тохиолдолд зохих дээд шатны албан тушаалтанд гомдол гаргах.

7 дугаар зүйл. Өргөдөл, гомдлын талаар төрийн  
байгууллага, албан тушаалтны хүлээх  
нийтлэг үүрэг

1. Өргөдөл, гомдлын талаар төрийн байгууллага, албан тушаалтан дараахь нийтлэг үүрэг хүлээнэ:

1/ иргэдээс өргөдөл, гомдол гаргах эрхээ хэрэгжүүлэх нөхцөлийг бүрэн хангах;

2/ харьяаллын дагуу ирсэн өргөдөл, гомдлыг заавал хүлээн авах;

3/ өргөдөл, гомдолд дурдсан асуудал бүрийг эрх хэмжээнийхээ хүрээнд хянан үзэж үндэслэлтэй шийдвэрлэх;

4/ өргөдөл, гомдлыг хугацаанд нь барагдуулах;

5/ өргөдөл, гомдолд дурдсан төр, байгууллага, хувь хүний нууцыг хадгалах;

6/ өргөдөл, гомдолд үндэслэл бүхий хариу өгөх.

2. Тухайн байгууллага, албан тушаалтан өөрийн эрх хэмжээнд хамаарах өргөдөл, гомдлыг үндэслэлгүйгээр өөр байгууллага, албан тушаалтанд шилжүүлж болохгүй.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ

### Өргөдөл, гомдол гаргах

8 дугаар зүйл. Өргөдөл, гомдол гаргах

#### зарчим

1. Өргөдөл, гомдол гаргагч өргөдөл, гомдол гаргах эрхээ хэрэг-жүүдэхдээ Үндсэн хууль, бусад хуулийг зөрчих, бусдын эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хохироох, ялгаварлан гадуурхахыг уриалж болохгүй.

2. Өргөдөл, гомдол үнэн зөв байна.

9 дүгээр зүйл. Өргөдөл, гомдол гаргах

#### хэлбэр

1. Өргөдөл, гомдлыг төрийн албан ёсны хэлээр бичгээр буюу амаар биечлэн гаргана.

2. Төрийн албан ёсны хэлийг мэдэхгүй бол төрөлх хэлээрээ өргөдөл, гомдол гаргаж болно.

3. Амаар биечлэн гаргасан өргөдөл гомдлыг хүлээн авч байгаа этгээд тэмдэглэн авч, өргөдөл, гомдол гаргагчийн гарын үсгийг зуруулна. Гарын үсгээ зурж чадахгүй бол энэ тухай тэмдэглэн;

10 дугаар зүйл. Өргөдөл, гомдолд тавих

#### шаардлага

1. Бичгээр гаргасан өргөдөл, гомдолд оршин суугаа газрын буюу шуудангийн хаягаа бичиж гарын үсгээ зурна. Хүндэтгэн үзэх шалтгаанаар гарын үсгээ зурж чадахгүй бол бусдаар төлөөлүүдэн зурж болно.

2. Өргөдөл, гомдлыг иргэд бичгээр хамтран гаргасан бол түүнд бүгд гарын үсэг зурах буюу эсхүл тэдгээрийн төлөөлөгч гарын үсэг зурж, төлөөлөх эрхээ нотлох баримт бичгийг хавсаргана.

3. Өргөдөл гомдол гаргахад энэ зүйлд зааснаас бусад зүйл шаардахыг хориглоно.

11 дүгээр зүйл. Өргөдөл гомдол гаргах

1. Өргөдлийг түүнд дурдсан асуудлыг шууд эрхлэн шийдвэрлэх эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гаргана.

2. Гомдлыг түүнд холбогдож байгаа байгууллага, албан тушаалтмыг харьяасан дээд шатны байгууллага, албан тушаалтанд гаргана.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

Өргөдөл, гомдлыг хүлээн авах,  
шийдвэрлэх хариу өгөх

12 дугаар зүйл. Өргөдөл, гомдлыг хүлээн  
авах, бүртгэх

1. Төрийн бүх байгууллага өргөдөл, гомдол гаргагчийг хүлээн авч уулзах байр, өргөдөл, гомдол хүлээн авах цагийн хуваарийг тогтоож, нийтэд мэдэгдэнэ. Хол газраас ирсэн иргэнийг хүлээлгэлгүйгээр хүлээн авч уулзана.

2. Уулзах байранд ирж амаар биечлэн гаргасан өргөдөл, гомдлыг түүнийг хүлээн авах үүрэг бүхий ажилтан тэмдэглэн авч, тусгай бүртгэлд бүртгэнэ.

3. Бичгээр ирүүлсэн өргөдөл, гомдлыг тухайн байгууллагын бичиг хэрэг хариуцсан ажилтан хүлээн авч, дарааллын дагуу бүртгэнэ.

4. Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт зваснаар бүртгэсэн өргөдөл, гомдлыг түүнийг шийдвэрлэх албан тушаалтанд өдөрт нь багтсан шилжүүлнэ.

5. Гомдлыг түүнд холбогдож байгаа албан тушаалтанд өөрт нь шилжүүлэхийг хориглоно.

6. Өргөдөл, гомдлыг албан тушаалтан шууд хүлээн авч болно.

7. "Нууц", "гарт нь" гэж хангласан өргөдөл, гомдлыг тухайн албан тушаалтанд шууд өгнө.

8. Өргөдөл, гомдлыг энэ зүйлийн 6, 7 дахь хэсэгт зваснаар хүлээн авсан албан тушаалтан дараахь журмыг биелүүлнэ:

1/ өөрийн эрх хэмжээнд хамаарах өргөдөл, гомдлыг хүлээн авснаас хойш, түүнчлэн албан тушаалтан томилолтоор өөр газар ажиллаж байгаа бол ирснээс хойш 6 цагийн дотор энэ зүйлд звасан бүртгэлд бүртгүүлнэ;

2/ ирсэн өргөдөл, гомдолд албан тушаалтныг өөрийн нь холбогдуулсан, эсхүл өргөдөл, гомдол тухайн албан тушаалтны эрх хэмжээнд хамаарахгүй бол энэ зүйлийн 3 дахь хэсэгт звасан ажилтанд хүлээлгэн өгнө.

13 дугаар зүйл. Өргөдөл, гомдлыг хянан үзэх

Өргөдөл, гомдлыг хүлээн авсан албан тушаалтан дараахь байдлаар хянан үзнэ:

1/ өргөдөл, гомдол нь тухайн байгууллага албан тушаалтны эрх хэмжээнд хамаарах эсэхийг тогтооно;

2/ өөрийн эрх хэмжээнд ханаарахгүй өргөдөл, гомдлыг харьяалах газар нь 3 хоногийн дотор шилжүүлнэ;

3/ өөрийн харьяаланг шийдвэрлэвэл зохих өргөдөл, гомдолд дурдсан асуудал бүрд дун шинжингээ хийж, холбогдох газраас магадлах, судалгаа, тодорхойлолт шаардан авах зэрэг үйл ажиллагаа явуулна;

4/ өргөдөл, гомдол гаргагчаас тодруулах боломжтой баримт сэлтийг шаардан авч болно.

14 дүгээр зүйл. Өргөдөл, гомдлыг хянан үзэхгүй байх, буцаах

1. Дор дурдсан үндэслэл байвал өргөдөл, гомдлыг хянан үзэхгүй байж болно:

1/ өргөдөл, гомдол нь тодорхой нэр хаяггүй;

2/ бага насны хүмүүс буюу шүүхийн шийдвэрээр эрхийн бүрэн чадамжгүйд тооцогдсон этгээд эцэг, эх, асран хамгаалагчаараа төлөөлүүлээгүй бол.

2. Өргөдөл, гомдол нь энэ хуулийн 10 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаагүй бөгөөд үүний улмаас өргөдөл, гомдлыг шийдвэрлэх боломжгүй бол уг шаардлагыг хангахыг мэдэгдэж, түүнийг өргөдөл, гомдол гаргагчид 3 хоногийн дотор буцаана.

15 дугаар зүйл. Өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, харну өгөх

1. Өргөдөлд дурдсан асуудлыг шууд шийдвэрлэх боломжтой бол зохих шийдвэрийг гаргана.

2. Шууд шийдвэрлэх боломжгүй бөгөөд удаан хугацаанд шийдвэрлэгдэх асуудал /орон сууц олгуулах гэх мэт/-ээр гаргасан өргөдөлийг тусгай бүртгэлд бүртгэж, шийдвэрлэлтэд хяналт тавина.

3. Гомдлыг албан тушаалтан өөрийн бүрэн эрхийн хүрээнд шийдвэрлэнэ.

4. Өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн, эсхүл энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан арга хэмжээ авсан тохиолдолд энэ тухай харнууг биечлэн амвар буюу харилцах утсаар, эсхүл бичгийн зэрэг тохиромжтой хэлбэрээр мэдэгдэнэ.

5. Харнууг амвар, харилцах утсаар мэдэгдсэн бол энэ тухай бүртгэлд тэмдэглэнэ.

6. Саналын шинжтэй өргөдөлийг хүлээн авч хэрэгжүүлэх боломжтой эсэхийг судалсны үндсэн дээр зохих арга хэмжээ авах буюу энэ зүйлийн 4, 5 дахь хэсэгт заасан журмаар харну өгнө.

7. Тухайн байгууллага, албан тушаалтын хүрээнд бүрэн шийдвэрлэх боломжгүй санхүүгийн шинжтэй өргөдлийг хэрхэн шийдвэрлэх талаар санал дүгнэлт боловсруулж, зохих журмаар шийдвэрлүүлнэ.

16 дугаар зүйл. Өргөдөл, гомдлыг шийдвэрлэх,  
харну өгөх хугацаа

1. Өргөдөл, гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногт багтаан шийдвэрлэнэ. Шаардлагатай тохиолдолд уг хугацааг тухайн байгууллагын удирдах албан тушаалтан 30 хүртэл хоног-гоор нэмж сунгаж болно. Хугацаа сунгасац тухай өргөдөл, гомдол гаргагчид мэдэгдэнэ.

2. Санхүүгийн шинжтэй өргөдлийн харнууг 30 хоногт багтаан өгнө.

17 дугаар зүйл. Шийдвэрт гомдол гаргах

Өргөдөл, гомдол гаргагч өргөдөл, гомдлын талаархи шийдвэрийг зөвшөөрөхгүй тохиолдолд гомдол гаргах эрхтэй. Хуульд өөрөөр заагаагүй бол гомдлыг зохих дээд шатны нь байгууллага, албан тушаалтанд гаргана.

18 дугаар зүйл. Өргөдөл, гомдлын талаархи  
шийдвэрийг биелүүлэх

1. Өргөдлийг шийдвэрлэсэн шийдвэрийн биелэлтийг түүнийг шийдвэрлэсэн буюу эрх бүхий бусад албан тушаалтан харууцна.

2. Гомдолд дурдсан зөрчигдсөн эрхийг сэргээлгэх талаар гаргасан шийдвэрийг холбогдох этгээд биелүүлэх үүрэгтэй.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

### Бусад зүйл.

19 дүгээр зүйл. Өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх  
үйл ажиллагаанд хяналт тавих

1. Төрийн байгууллага, албан тушаалтанд ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхэд тухайн байгууллагын эрх баригч болон эрх бүхий албан тушаалтан хяналт тавина.

2. Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагад өргөдөл, гомдол шийдвэрлэх үйл ажиллагааг зохион байгуулж удирдах үүргийг Засгийн газрын Хэрэг эрхлэх гатар хүлээнэ.

20 дугаар зүйл. Өргөдөл, гомдолд судалгаа  
дүгнэлт хийх

Төрийн байгууллагууд өргөдөл, гомдлын агуулгад судалгаа,  
дүгнэлт хийж, түүний мөрөөр авах арга хэмжээг зохион байгуулж  
хэрэгжүүлнэ.

21 дүгээр зүйл. Хууль тогтоомж зөрчигчдөд  
хүлээлгэх хариуцлага

1. Энэ хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2, 4, 6 дахь  
залалт, 2 дахь хэсэг, 12 дугаар зүйлийн 2, 5 дахь хэсэгт заасныг  
зөрчсөн бол хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэлийг эрх  
бүхий албан тушаалтан 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь  
залалт, 16 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 18 дугаар зүйлийн 2 дахь  
хэсгийн залалтыг зөрчиж, өргөдөл, гомдол гаргагчийн эрх, хууль  
ёсны ашиг сонирхлыг хохироосон бол 1000-15000 төгрөгөөр торгох  
шийтгэлийг шүүгч тус тус ногдуулна.

2. Энэ хуулийн 8 дугаар зүйлийн залалтыг зөрчиж, бусдыг  
доромжилсон, гүтгэсэн, бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн  
нэр хүндийг гутаасан этгээдэд Иргэний хууль, Эрүүгийн хуульд  
заасан хариуцлага хүлээлгэнэ.

Дарга

Н. БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 4 дүгээр  
сарын 18-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ТӨРИЙН НУУЦЫН ТУХАЙ

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

##### Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь төрийн нууцыг тогтоох, хамгаалах,  
ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Төрийн нууцын тухай хууль тогтоомж

Төрийн нууцын тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, энэ  
хууль, хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл. Төрийн нууцын тухай ойлголт

1. "Төрийн нууц" гэж Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу төрийн нууцад хямааруулсан, тус улсын гадаад бодлого, эдийн засаг, шинжлэх ухаан, техник-технологь, батлан хамгаалах, татнуул, сорох татнуул, гүйцэтгэх ажилтай холбостой бөгөөд задруулбал Монгол Улсын аюулгүй байдалд хор хохирол учруулахуйц мэдээллийг томьёолод, дүрс зураг, дохио тэмдэг, техник-технологийн шийдэл болон үйл ажиллагааны хэлбэрээр өөртөө агуулж байгаа мэдээ, баримт бичиг, биет зүйлийг хэлнэ.

2. Монгол Улсын аюулгүй байдлыг хангах үүднээс зарим барилга, байгууламж /цаашид "объект" гэх/, төрийн эрх бүхий байгууллагаас хэрэгжүүлж байгаа тодорхой үйл ажиллагааг төрийн нууцад хямааруулж болно.

4 дүгээр зүйл. Төрийн нууцыг тогтоох зарчим

Төрийн нууцыг тогтоохдоо хууль тогтоомжид нийцсэн, няг үеэ олсон байх зарчим баримтална.

5 дугаар зүйл. Төрийн нууцад хямааруулах зүйлийн хүрээ

1. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын хүрээнд:

1/ Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон мэдээ, баримт бичиг, бусад зүйлийн нууцалбал зохих хэсэг;

2/ Монгол Улсын гадаад бодлого, бэлр суурьтай холбоотой онц чухал мэдээлэл, түүнчлэн Монгол Улсаас гадаад орнуудтай байгуулсан нууцалбал зохих гэрээ, хэлэлцээр, тэдгээрийн төсөл.

2. Батлан хамгаалах хүрээнд:

1/ батлан хамгаалах бодлого, үзэл баримтлал, цэргийн нөмлөл, тэдгээртэй холбогдох баримт бичгийн нууцалбал зохих хэсэг;

2/ стратеги, оперативын төлөвлөгөө, түүний бислэлтийн мэдээ, цэргийн стратеги, оператай, дайчилгааны дэлгэм байгуулалт, операци, байлдааныг бэлтгэх, хэрэгжүүлэх байлдааны удирдлагын баримт бичиг, эзэсэгт тэмцэл явуулах ярга, байлдааны болон дайчилгааны бэлэн байдал, дайчилгааны нөөц, түүний ашиглалтын тухай мэдээлэл;

3/ цэргийн зэвсэг техникийг шинээр бий болгох, худалдан авах, боловсронгуй болгоход чиглэсэн эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажил, энэ зорилгоор хэрэгжүүлж байгаа хөтөлбөр, тэдгээрийн бислэлт, үр дүн;

4/ нууц зэвсэг, түүнчлэн техник хэрэгслийн нэр, төрөл, техникийн өгөгдөхүүн, байлдаанд ашиглах боломж;

5/ улсыг батлан хамгаалахад онцгой ач холбогдол бүхий объектуудын байрлал, зориулалт, бэлэн байдлын зэрэглэл, хамгаалалт, тэдгээр объектын зураг төсөл, дигалдах баримт бичиг, зардлын төсөв, объект барьж байгуулахаар олгосон газар нутаг, холбогдох бусад мэдээлэл;

6/ зэвсэгт хүчин, бусад цэргийн анги, салбарын зориулалт, зэвсэг техникийн хангалт, нууцалсан болон тусгай томилгоот байрлал, жинхэнэ нэр, зэвсэглэл, бие бүрэлдэхүүний тоо;

7/ Монгол Улсын иам, тусгай газар аймаг, нийслэлийн дайчилгааны дэвжгээр, жилийн тооцоот хэрэгцээний захиалга, төлөвлөгөө;

8/ иргэний хамгаалалтын нийтийн дайчилгааны арга хэмжээг хэрэгжүүлэх болон онцгой нөхцөл байдлын үед хүн амын аюулгүй байдлыг хангах төлөвлөгөө, хангаалтын объектуудын байрлал, зориулалт, энэ үед дэд бүтцийг ашиглахтай холбогдсон мэдээлэл;

9/ улсын хилийн хамгаалалт, шалган нэвтрүүлэх албаны зохион байгуулалт, арга ажиллагаа, тэдгээрт холбогдох мэдээлэл.

3. Эдийн засаг, шинжлэх ухаан, техник-технологийн хүрээнд:

1/ Монгол Улсын аюулгүй байдал, эдийн засаг, батлан хамгаалахад онцгой ач холбогдол бүхий эрдэм шинжилгээ, судалгааны бүтээл, туршилт, нээлт, зураг төсөл, үндэсний болон дэвшилтэт технологи;

2/ цэргийн зориулалттай бүтээгдэхүүн үйлдвэрлэх болон дайчилгааны хүчин чадал, улсын материаллаг нөөцийн бсдит хэмжээ, байрлал;

3/ батлан хамгаалах болон эдийн засгийн аюулгүй байдлыг хангахад ач холбогдол бүхий стратегийн түүхий эд, материалын нөөц, олборлолт, нийлүүлэлтийн хэмжээ;

4/ төрийн нууцыг хамгаалах арга хэрэгсэл, энэ талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, тэдгээрийн тухай мэдээлэл.

4. Тагнуул, сорох тагнуул, гүйцэтгэх ажлын хүрээнд:

1/ тагнуул, сорох тагнуулын үйл ажиллагаа, гүйцэтгэх ажлын арга хэлбэр, хүч хэрэгсэл, мэдээллийн эх сурвалж, орон тоо, зохион байгуулалт, баримт бичиг, архив, мэдээллийн сан, санхүүжилтийн тухай мэдээлэл;

2/ төрийн холбооны нууцлал бүхий систем, түүнд холбогдох баримт бичиг, төрийн шифр, түүнийг ашиглах арга, ажиллагаа;



3/ цагдаа, тагнуул, хорих байгууллагын галт зэвсэг, тусгай хэрэгслийн хангалт, нөөц, нийтийн эмх замбараагүй байдлын үед тагнуул, цагдаагийн байгууллага, дотоодын цэргийн ажиллах төлөвлөгөө, улсын онц чухал объектын хамгаалалтын хүч хэрэгслийн тухай мэдээлэл, дайны болон дайн бүхий байдлын үед хорих байгууллагын ажиллах төлөвлөгөө, түүнд холбогдох бусад баримт бичиг;

4/ Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах зорилгоор төрийн эрх бүхий байгууллагаас хэрэгжүүлж буй үйл ажиллагаа.

5. Цаазаар авах илгэ гүйцэтгэх журам, энэ зүйлийн 2 дахь хэсгийн 4, 5; 3 дахь хэсгийн 2, 3; 4 дэх хэсгийн 1-тэй холбоотойгоор төрийн нууцад хамааруулах шаардлагатай объектууд.

6 дугаар зүйл. Төрийн нууцын жагсаалт

1. Төрийн нууцын жагсаалтыг хуулиар батална.

2. Хууль гаргахгүйгээр аливаа мэдээ, баримт бичиг, биет зүйлийг төрийн нууцад хамааруулахыг хориглоно.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ

### Төрийн нууцыг тогтоох, нууцлах

7 дугаар зүйл. Төрийн нууцыг тогтоох

Төрийн нууцыг тогтоох үйл ажиллагаа нь мэдээ, баримт бичиг, биет зүйлийг төрийн нууцын жагсаалтад хамааруулах шийдвэр гаргах, боловсруулах, нууцлах ажиллагаанаас тус тус бүрдэнэ.

8 дугаар зүйл. Төрийн нууцыг боловсруулах

1. Байгууллага, албан тушаалтан нь төрийн нууцад хамаарах мэдээ, баримт бичиг боловсруулах, биет зүйлийг хийх, үйлдвэрлэх, объект барьж байгуулах, тодорхой үйл ажиллагааг хэрэгжүүлэх /цаашид "төрийн нууцыг боловсруулах" гэх/-дээ энэ хуулийн 13 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2-ын "б"-д заасан журмыг баримтална.

2. Байгууллага, албан тушаалтнаас төрийн нууцыг боловсруулахад өгч буй санал, дүгнэлт нь тухайн зүйлийг төрийн нууцад хамааруулахад хүргэж буй мэдээллийг агуулсан байвал тэдгээрийг нууцын зэрэглэлтэнд адилтган тооцож хамгаалалтад авна.

3. Төрийн нууцад хамаарах зүйлийн тухай асуудлыг энэ хуулийн 13 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2-ын "б"-д заасан журмыг баримтлан хаалттай хэлэлцэнэ.

9 дүгээр зүйл. Төрийн нууцад хамааруулах шийдвэр гаргах

1. Мэдээ, баримт бичиг, биет зүйлийг төрийн нууцын жагсаалтад хамааруулах санааг байгууллага, албан тушаалтан, иргэдээс Тагнуулын төв газарт гаргана.

2. Тагнуулын төв газар тухайн санааг судлан боловсруулж Засгийн газарт 2 долоо хоногийн дотор оруулна.

3. Засгийн газар төрийн нууцад хамааруулах тухай асуудлыг нарийвчлан судалж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд танилцуулан 30 хоногийн дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

4. Төрийн нууцын жагсаалтад мэдээ, баримт бичиг, биет зүйлийг хамааруулах тухай шийдвэр гаргахдаа нууцын зэрэглэлээс нь хамааран тэдгээрийн жинхэнэ нэрийг төлөөлүүлсэн нэр, шифр, дугаар хэрэглэж болно.

10 дугаар зүйл. Төрийн нууцыг нууцлах

1. Мэдээ, баримт бичиг, биет зүйлийг нууцлах арга хэмжээг тэдгээрийг төрийн нууцад хамааруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн хөлбөгдох байгууллага, албан тушаалтан авч хэрэгжүүлнэ.

2. Мэдээ, баримт бичгийг нууцлахдаа төрийн нууцын зэрэглэлийг тодорхойлсон тэмдэг дарж, төлөөлүүлсэн нэр, шифр, дугаарыг тавина.

3. Биет зүйлийг нууцлахдаа нууцын тэмдэг, төлөөлүүлсэн нэр, шифр, дугаарыг тухайн зүйлийн сав, баглаа боодол, дагалдах баримт бичигт дарж тэмдэглэнэ.

4. Объект тодорхой үйл ажиллагааг нууцлахдаа тэдгээрийг халхлах арга хэмжээг Монгол Улсын Ерөнхийлөгчийн баталсан журмын дагуу хэрэгжүүлнэ.

11 дүгээр зүйл. Төрийн нууцын зэрэглэл

1. Төрийн нууцыг задруулснаас Монгол Улсын ашиг сонирхол, аюулгүй байдалд учирч болох хор уршгийн хэмжээнээс хамааран төрийн нууцын зэрэглэлийг тогтооно.

2. Төрийн нууц нь дараахь зэрэглэлтэй байна:

1/ онц чухал-маш нууц;

2/ маш нууц;

3/ нууц.

3. Мэдээ, баримт бичиг, биет зүйлийг төрийн нууцад хамааруулахаар Тагнуулын төв газарт санаа оруулсан өдрөөс эхлэн

шаардлагатай бол тэдгээрийг "ойц чухал-маш нууц" зэрэглэлтэйд тооцож хамгаалалтад авна.

4. Төрийн нууцын зэрэглэлийг тодорхойлсон тэмдгийг төрийн нууцад үл хамаарах мэдээ, баримт бичиг, бусад зүйлд хэрэглэхийг хориглоно.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

### Төрийн нууцыг хамгаалах, хариуцах

12 дугаар зүйл. Төрийн нууцыг хамгаалах

1. Төрийн нууц нь төрийн хамгаалалтад байна.

2. "Төрийн нууцыг хамгаалах" гэж төрийн бүх шатны байгууллага, албан тушаалтнаас төрийн нууцыг задруулахгүй байх зорилгоор өөрийн бүрэн эрхийн хэмжээнд авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, арга хэрэгслийн цогцолборыг ойлгоно.

3. "Төрийн нууцыг хариуцах" гэж эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас төрийн нууцыг хамгаалах, хадгалах, ашиглах үйл ажиллагааг хамааруулан ойлгоно.

4. Төрийн нууцыг хариуцдаг, эсхүл төрийн нууцтай албан үүргийн дагуу танилцсан албан тушаалтан, иргэн төрийн нууцыг задруулах, хувийн зорилгоор ашиглахыг хориглоно.

5. Төрийн нууцыг олж авах зорилгоор хайх, бусдад тараахыг хориглоно.

13 дугаар зүйл. Төрийн нууцыг хамгаалах талаар

Улсын Их Хурал, Ерөнхийлөгч,

Засгийн газрын бүрэн эрх

1. Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар төрийн нууцыг хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ Улсын Их Хурал:

а/ төрийн нууцыг хамгаалах үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоох;

б/ Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Засгийн газрын саналыг үндэслэн төрийн нууцын зэрэглэлийг баталж, төрийн нууцын хугацааг тогтоох, сунгах болон төрийн нууцыг ил болгох асуудлыг шийдвэрлэх;

в/ нууцын тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих,

2/ Монгол Улсын Ерөнхийлөгч нь Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тэргүүний хувьд:

а/ төрийн нууцны хамгаалалтын талаар Засгийн газрын мэдээллийг сонсох, чиглэл өгөх, төрийн нууцыг хамгаалах талаар холбогдох байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаатай танилцах;

б/ төрийн нууцыг боловсруулах, хадгалах, хамгаалах, ашиглах, объект, тодорхой үйл ажиллагааг халхлах, төрийн нууцтай танилцах, төрийн нууцыг шилжүүлэх, татан авах, хяалттай хуралдаан хийх журмыг батлах.

3/ Монгол Улсын Засгийн газар:

а/ төрийн нууцыг хамгаалах ажлыг чиглүүлэн удирдаж, төрийн нууцны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах;

б/ төрийн нууцны хадгалалт, хамгаалалтад хяналт тавих, шалгах.

2. Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар нь төрийн нууцыг хамгаалах талаар хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

14 дүгээр зүйл. Төрийн нууцыг харуцаж буй  
байгууллагын бүрэн эрх

1. Төрийн нууцыг харуцаж байгаа төрийн бүх шатны байгууллага дарвах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ;

1/ салбарынхаа хэмжээнд хадгалагдаж байгаа болон бусад байгууллагын харуцаж буй өөрийн салбарт хамаарах төрийн нууцны ашиглалт, хамгаалалтад хяналт тавих;

2/ мэдээ, баримт бичиг, биет зүйлийг төрийн нууцад хамааруулах, зэрэглэл тогтоолгох, түүнчлэн төрийн нууцыг ил болгох асуудлаар Тагнуулын төн газарт санхалаа оруулах;

3/ төрийн нууцыг шилжүүлэх, татан авах тухай санхалаа Тагнуулын төн газарт оруулах;

4/ төрийн нууцыг тухайн байгууллага харуцаж буй эсэх талаар хөндлөнгийн этгээдэд тайлбар өгөхөөс татгалзах;

5/ эрх хэмжээнийхээ хүрээнд төрийн нууцыг хамгаалахтай холбогдсон бусад бүрэн эрхийг хэрэгжүүлэх.

2. Нутгийн өөрөө удирдах байгууллага, бүх шатны Засаг дарга нь төрийн нууцыг хамгаалах ажлыг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, шаардлагатай тохиолдолд асуудамг зохих журмаар холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.

3. Байгууллага нь өөрт хадгалагдаж байгаа төрийн нууцыг харуцаж, түүнийг хамгаалах арга хэмжээг хууль тогтоомж,

Монгол Улсын Ерөнхийлөгчийн баталсан журамд нийцүүлэн зохион байгуулана.

15 дугаар зүйл. Тагнуулын төв газрын  
бүрэн эрх

1. Тагнуулын төв газар нь төрийн нууцыг хадгалах, хамгаалах, ашиглах ажлыг улсын хэмжээнд зохицуулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах үүргийг хүлээж, дарвахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ төрийн нууц задрахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;

2/ төрийн нууцыг хариуцаж байгаа байгууллага, албан тушаалтан төрийн нууцыг хэрхэн ашиглаж, хамгаалж байгаад хяналт тавих, шалгах;

3/ төрийн нууцыг хамгаалах тухай хууль тогтоомж, Ерөнхийлөгч, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх талаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах, төрийн нууцыг хадгалах, хамгаалах ашиглах ажлыг боловсронгуй болгох саналаа Засгийн газарт оруулах;

4/ мэдээ, баримт бичиг, биет зүйлийг төрийн нууцад хамааруулах, төрийн нууцыг татан авах, шилжүүлэх, нл болгох, нууцын зэрэглэлийг тогтоох, төрийн нууцын хугацааг сунгах асуудлаар саналаа боловсруулж Засгийн газарт оруулах;

5/ төрийн нууцад хамаарах мэдээ, баримт бичгийг дамжуулах төрийн холбоо, шуудан, шифр, тоон мэдээллийн харилцааны сүлжээгээр үйлчлэх;

6/ төрийн нууцад хамаарах мэдээ, баримт бичиг, биет зүйлийг үгүй болгосон, төрийн нууцыг задруулсан тохиолдолд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах;

7/ хууль тогтоомжоор олгогдсон бусад бүрэн эрх.

2. Төрийн холбоо, шуудан, шифр, тоон мэдээллийн харилцааны дүрмийг Засгийн газар батална.

16 дугаар зүйл. Төрийн нууцыг хариуцуулах

1. Төрийн нууцыг хариуцах нууцын ажилтныг уул ажилд авахын өмнө тагнуулын байгууллага шалгаж зөвшөөрөл олгоно.

2. Тагнуулын байгууллагын зөвшөөрөлгүйгээр төрийн нууцыг хариуцуулахыг хориглоно.

17 дугаар зүйл. Нууцны ажилтны эрх зүйн байдлын зарим онцлог

Нууцны ажилтан нь дараахь эрх зүйн байдлын онцлогтой байна:

1/ гадаадад хувийн хэргээр зөрчих тохиолдолд зохих байгууллагын зөвшөөрөл авах;

2/ гадаадын иргэн, байгууллагатай албан бус харилцаа тогтоосон бол энэ тухай байгууллагадаа мэдэгдэх;

3/ хариуцаж байгаа төрийн нууцны зэрэглэл, ажилласан хугацаанаас хамааран тухайн байгууллагад тогтоосон журмын дагуу цалингийн нэмэгдэл авах.

18 дугаар зүйл. Төрийн нууцыг хариуцуулахыг зогсоох

1. Нууцны ажилтан хүлээсэн үүргээ зөрчсөн тохиолдолд захиргааны шийдвэрээр төрийн нууц хариуцуулахыг зогсоож, холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

2. Төрийн нууц хариуцуулахыг зогсоосон нь төрийн нууцыг задруулахгүй байх талаар уул этгээдийн урьд хүлээсэн үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Төрийн нууцтай танилцах, түүнийг шилжүүлэх, татан авах

19 дүгээр зүйл. Төрийн нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтан

1. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд нь танилцуулахыг хуулиар хориглосноос бусад төрийн нууцтай зэрэглэл харгалзахгүйгээр танилцана.

2. Улсын Их Хурлын болон Засгийн газрын гишүүн, тэдгээртэй адилтгах бусад албан тушаалтан нь албан үүргийн шаардлагаар танилцвал зохих төрийн нууцтай энэ хуулийн 13 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2-ын "б"-д заасан журмын дагуу танилцана.

3. Төрийн нууцтай холбогдсон асуудлыг хянан шалгах зорилгоор Улсын Их Хурлаас байгуулсан комиссын гишүүн, эсхүл мөнхүү зорилгоор Улсын Их Хурлаас тусгайлан эрх олгогдсон хүн тухайн шалгах асуудлын хүрээнд хамаарах төрийн нууцтай зэрэглэл харгалзахгүйгээр танилцана.

4. Төрийн нууцыг хариуцаж байгаа төрийн төв, орон нутгийн болон бусад байгууллагын төрийн нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтын жагсаалтыг тагнуулын байгууллагын саналыг үндэслэн тухайн байгууллагын дарга батална.

20 дугаар зүйл. Төрийн нууцыг шилжүүлэх,  
татан авах

1. Төрийн нууцыг дараахь үндэслэлээр шилжүүлж болно:

1/ Монгол улсын аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан төрийн нууцыг бусад байгууллагатай хамтран ашиглаж тодорхой зорилго биелүүлэх;

2/ энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан үндэслэлээр.

2. Төрийн нууцыг дараахь тохиолдолд төрийн төв байгууллага нь татан авна:

1/ төрийн нууцыг хамгаалах үүргээ зохих ёсоор биелүүлээгүйгээс төрийн нууц задрах бодит нөхцөл байдал бий болсон;

2/ тухайн байгууллага татан буугдсан буюу өөрчлөн байгуулагдсаны улмаас төрийн нууцыг хариуцах үүрэггүй болсон;

3/ нөхцөл байдал өөрчлөгдсөний улмаас төрийн нууцыг тухайн байгууллага өөрийн хүчээр хамгаалах боломжгүй болсон.

## ТАВДУГААР БҮЛЭГ

### Бусад зүйл.

21 дүгээр зүйл. Төрийн нууцыг ил болгох

1. "Төрийн нууцыг ил болгох" гэж төрийн нууцыг Улсын Их Хурлын шийдвэрээр төрийн хамгаалалтаас гаргахыг хэлнэ.

2. Төрийн нууцыг дараахь үндэслэлээр ил болгоно:

1/ нөхцөл байдал өөрчлөгдсөний улмаас нууцлах шаардлагагүй болсон;

2/ нууцлах хугацаа дуусгавар болсон;

3/ хуульд заасан бусад үндэслэл.

3. Төрийн нууцыг ил болгох асуудлыг Үндэсний аюулгүй байдлын төвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

4. Монгол Улсын аюулгүй байдлын эрх ашгийн үүднээс төрийн нууцыг харалтай ил болгох шаардлага гарсан онцгой тохиолдолд Тагнуулын төв газрын даргын саналыг үндэслэн Монгол Улсын Ерөнхийлөгч уул асуудлыг шийдвэрлэнэ.

22 дугаар зүйл. Төрийн бус байгууллага, хувь хүний  
нууцыг төрийн нууцад хамааруулах

Монгол Улсын аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор шаард-  
лагатай тохиолдолд төрийн бус байгууллага, хувь хүний нууцыг  
энэ хуульд заасан журмын дагуу төрийн нууцад хамааруулж  
болно. Ийнхүү хамааруулснаас учирч болох эд хөрөнгийн хохир-  
лыг өмчлөгчтэй байгуулсан гэрээг үндэслэн төрөөс нөхөн олгоно.

23 дугаар зүйл. Төрийн нууц хамгаалах үйл  
ажиллагааг санхүүжүүлэх

Төрийн нууц хамгаалах үйл ажиллагааг улсын төсвөөс санхүү-  
жүүлнэ.

24 дүгээр зүйл. Хууль зөрчигчдөд хүлээлгэх  
хариуцлага

Энэ хуулийн дор дурдсан зүйл, заалтыг зөрчсөн этгээдэд  
шүүгч дараахь захиргааны шийтгэл ногдуулна:

- 1/6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг зөрчсөн бол 500-2500  
төгрөгөөр торгох;

2/9 дүгээр зүйл, 10 дугаар зүйлийн 2, 3, 11 дүгээр зүйлийн 3,  
4 дэх хэсгийн заалтыг зөрчсөн бол 1000-5000 төгрөгөөр торгох;

3/10 дугаар зүйлийн 1, 16 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 17  
дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2 дахь заалтыг зөрчсөн бол  
5000-10000 төгрөгөөр торгох;

4/ төрийн нууцыг хувийн зорилгоор ашигласан бол 20000-50000  
төгрөгөөр торгох.

25 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийг 1995 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн  
дагаж мөрдөнө.



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 4 дүгээр  
сарын 21-ний өдөр

Улаанбаатар  
хот

### ХУВЬ ХҮНИЙ НУУЦЫН ТУХАЙ

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

##### Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь хувь хүний нууцыг тогтоох, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Хувь хүний нууцын тухай  
ойлголт

"Хувь хүний нууц" гэж Монгол Улсын болон гадаадны иргэн, харьяалаагүй хүн Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн нууцалсан бөгөөд задруулбал тухайн хүний хууль ёсны ашиг сонирхол, нэр төр, адал хүндэд илтэд хохирол учруулж болзошгүй мэдээ, баримт бичиг, биет зүйлийг хэлнэ.

3 дугаар зүйл. Хувь хүний нууцын тухай хууль тогтоомж  
Хувь хүний нууцын тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, энэ хууль, хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

#### ХОЁРДУГААР БҮЛЭГ

##### Хувь хүний нууцын төрөл, хувь хүний нууцыг хамгаалах

4 дүгээр зүйл. Хувь хүний нууцын төрөл

1. Хувь хүний нууц нь дараахь төрөлтэй байна:

1/ захидал харилцааны нууц;

2/ эрүүд мэндийн нууц;

3/ хөрөнгийн нууц;

4/ гэр бүлийн нууц;

5/ хуудлаар тогтоосон бусад нууц.

2. Захидал харилцаа, эрүүд мэнд, хөрөнгө, гэр бүлийн нууц гэдгийг энэ хуульд дараахь утгаар ойлгоно:

1/ захидал харилцааны нууцад захидал, цахилгаан, илгээмж, өргөдөл зэрэг шуудан холбооны хэрэгслээр бусад хүн, байгууллагатай солилцож буй мэдээ, баримт бичиг, биет зүйлийг;

2/ эрүүл мэндийн нууцад тухайн хувь хүний бие эрхтний гажиг, нийтэд аюултай онцлог зарим халдварт өвчнөөс бусад өвчнөөр өвчилсөн тухай мэдээллийг;

3/ хөрөнгийн нууцад зөвхөн эд хөрөнгө, оюун, өмч, эрхийн эзэн, эсхүл түүний итгэмжлэгдсэн хүмүүс мэдэх, түүнчлэн эрх бүхий байгууллага албан тушаалтны албан үүргийнхээ дагуу олж мэдсэн мэдээ, баримт бичиг, тоо, гэрээ хэлцэл, биет зүйлийг;

4/ гэр бүлийн нууцад бусдад задруулбал тухайн хувь хүн, түүний гэр бүлийн гишүүдийн нэр төр, алдар хүнд, ашиг сонирхолд харшлах мэдээллийг.

3. Хувь хүний өөрийн архив, хадгаламж, тэмдэглэл, битүүмжлэл болон тэдгээрт хамаарах дүрс, дуу бичлэгийг нууцалж болно.

5 дугаар зүйл. Хувь хүний нууцыг хамгаалах

1. Хувь хүн нууцаа өөрөө хамгаална.

2. Шаардлагатай тохиолдолд хувь хүний нууцыг хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу төр, байгууллага хамгаалалтдаа авч болно.

3. Хуулиар тусгайлан эрх олгогдсон төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан зөвхөн хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу хувь хүний нууцтай танилцана.

4. Хувь хүний нууцыг хуулийн дагуу болон итгэмжлэлээр олж мэдсэн этгээд бусдад задруулахыг хориглоно.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

### Бусад зүйл.

6 дугаар зүйл. Хувь хүний нууцыг ил болгох

Монгол Улсын батлан хамгаалах болон үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхол, иргэдийн эрүүл мэнд, хууль ёсны эрх ашигт хохирол учруулахгүйн үүднээс зайлшгүй шаардлагатай онцгой тохиолдолд төрийн холбогдох эрх бүхий байгууллага /албан тушаалтан/-ын шийдвэрээр хувь хүний эрүүл мэндийн болон бусад нууцыг хуульд заасан хүрээнд ил болгож болно.

7 дугаар зүйл. Шүүхэд гомдол гаргах

Энэ хуулийн 5 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан этгээд өөрийнх нь нууцыг бусдад задруулсан гэж үзвэл хувь хүн энэ тухай гомдлоо шүүхэд гаргах эрхтэй.

8 дугаар зүйл. Хууль зөрчигчдөд хүлээлгэх  
хариуцлага

Энэ хуулийн 5 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн заалтыг зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч 20000-50000 төгрөгөөр торгох захиргааны шийтгэл ногдуулна.

9 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийг 1995 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Монгол Улсын Их Хурлын дарга

Н. БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 5 дугаар  
сарын 16-ны өдөр

Улаанбаатар  
хот

### БАЙГУУЛЛАГЫН НУУЦЫН ТУХАЙ

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

##### Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь байгууллагын нууцыг тогтоох, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Байгууллагын нууцын тухай  
хууль тогтоомж

Байгууллагын нууцын тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, энэ хууль, хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл. Байгууллага, байгууллагын нууцын  
тухай ойлголт

1. Байгууллага, байгууллагын нууц гэдгийг дараахь утгаар ойлгоно:

1/ "байгууллага" гэж тодорхой чиг үүрэг, бүрэн эрх бүхий хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн хуулийн этгээдийг хэлнэ;

2/ "байгууллагын нууц" гэж хүний эрх, нэр төр, алдар хүнд, тухайн байгууллагын хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор холбогдох хуулиар нууц гэж тогтоосон мэдээ, баримт бичиг, биет зүйлийг хэлнэ.

2. Байгууллагын албан үйл ажиллагааны онцлогтой холбоотой, эсхүл шударга өрсөлдөөнд зах зээл, давуу талаа хамгаалах зорилгоор байгууллага өөрөө нууцалж хамгаалалтдаа авсан, эздруулбал хууль ёсны ашиг сонирхолд нь хор уршиг учруулж болох нууц мэдээ, технологийн шийдэл, төсөл, судалгаа-шинжилгээний баримт бичиг, шаардлагатай техник, тоног төхөөрөмжийг байгууллагын нууцад хамааруулж болно.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ

### Байгууллагын нууцыг тогтоох, хамгаалах

4 дүгээр зүйл. Байгууллагын нууцыг тогтоох

1. Энэ хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2-т хамаарах нууцыг Улсын Их Хурал хуулиар тогтоон баталгаажуулна.

2. Энэ хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт хамаарах нууцыг байгууллага өөрөө тогтооно.

3. Байгууллагын нууц нь эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрх, чиг үүргээ хэрэгжүүлэхэд саад учруулахаар байж болохгүй.

5 дугаар зүйл. Байгууллагын нууцыг хамгаалах

1. Байгууллагын нууц нь тухайн байгууллагын хамгаалалтад байна. Байгууллага нь нууцаа хамгаалах журмыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн өөрөө тогтоож мөрдөнө.

2. Байгууллагын нууцыг хариуцаж байгаа, эсхүл түүнтэй албан үүрэг, мөргөжлийн үйл ажиллагааны дагуу танилцсан, олж мэдсэн этгээд уул нууцыг чанд хадгалах үүрэгтэй.

3. Байгууллага нь эрхэлж буй үйл ажиллагааныхаа дагуу олж мэдсэн хувь хүний нууцыг байгууллагын нууцны нэг адил хамгаална.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

### Бусад зүйл.

6 дугаар зүйл. Нууцлахыг хориглох мэдээллийн хүрээ

Байгууллага дор дурдсан мэдээллийг нууцалж болохгүй:

1/ тухайн байгууллагын явуулж буй үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж буй техник, технологийн хүн амын эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх буюу үзүүлд байгаа нөлөөллийг илтгэн харуулах мэдээлэл;

2/ тухайн байгууллагын мэдэлд байгаа бөгөөд хадгалалт, хамгаалалтын горим нь зөрчигдсөн тохиолдолд хүн амын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд аюул учруулж болзошгүй бүх төрлийн хорт, цэцраг идэвхт бодисын хор хөнөөлийг тодорхойлсон мэдээлэл;

3/ гэмт хэргийн тухай болон нийтэд мэдээлэхээр хуульд заасан бусад мэдээлэл.

7 дугаар зүйл. Байгууллагын нууцтай танилцах

1. Хуулиар тусгайлан эрх олгогдсон байгууллага, тэдгээрийн ажилтан нь хянан шалгах бүрэн эрх, чиг үүргийнхээ дагуу байгууллагын нууцтай танилцана.

2. Байгууллагын нууцтай албан үүргийнхээ дагуу танилцсан, эсхүл олж мэдсэн этгээд уул нууцыг зөвхөн хууль тогтоомжид заасан үндэслэл, журамд нийцүүлэн ашиглах бөгөөд бусдад задруулахыг хориглоно.

3. Эрх бүхий байгууллага албан тушаалтан бүрэн эрхийнхээ дагуу хэрэгжүүлж байгаа хяналт шалгалтын явцад хууль тогтоомж зөрчиж нууцалсан байгууллагын нууцыг ил болгох эрхтэй бөгөөд тухайн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдалтай холбогдолтой байгууллагын нууцад хамаарах зарим тодорхой мэдээллийг бусдын хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулахгүй тохиолдолд нийтэд мэдээлж болно.

8 дугаар зүйл. Шүүхэд гомдол гаргах

Хуулиар тогтоосон нууцыг нь аливаа этгээд бусдад задруулсан гэж үзвэл байгууллага энэ тухай гомдлоо шүүхэд гаргах эрхтэй.

9 дүгээр зүйл. Хариуцлага

Байгууллагын нууцыг хариуцдаг, эсхүл түүнтэй танилцсан этгээд уул нууцыг задруулсан бол хөдөлмөрийн гэрээ, тухайн байгууллагын дотоод журамд заасны дагуу хариуцлага хүлээх

бөгөөд хуулиар тогтоосон байгууллагын нууцыг задруулсан нь эрүүгийн хариуцлага хүдээлгэхээргүй бол шүүгч 20000-50000 төгрөгөөр торгох захиргааны шийтгэл ногдуулна.

10 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийг 1995 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Монгол Улсын Их Хурлын дарга

Н. БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 4 дүгээр

сарын 27-ны өдөр

### ТӨРИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТЫН ТУХАЙ

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

##### Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь төрийн тусгай хамгаалалт, түүний хамрах хүрээ, хамгаалалтыг хэрэгжүүлэх байгууллагын эрх зүйн үндсийг тодорхойлж, төрийн тусгай хамгаалалтын үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль тогтоомж

Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, Улсын аюулгүй байдлыг хангах тухай хууль, энэ хууль тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл. Төрийн тусгай хамгаалалт

Төрийн тусгай хамгаалалт нь аюулгүй байдлыг нь хангах зорилгоор хуулиар төрийн тусгай хамгаалалтад авахаар тогтоосон төрийн байгууллага, тэдгээрийн зарим үйл ажиллагаа, албан тушаалтан, иргэний амь бие, ордон, өргөө, зориулалтын орон сууц, тээврийн хэрэгсэл, бусад зүйлийг хамгаалахад чиглэсэн мэргэжлийн болон бусад байгууллага, албан тушаалтны харилцан уялдаатай цогцолбор үйл ажиллагаа мөн.

**4 дүгээр зүйл. Төрийн тусгай хамгаалалтын зарчим**

Төрийн тусгай хамгаалалт нь хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, нууцыг чанд хадгалах, иж бүрэн байх зарчимд үндэслэнэ.

**5 дугаар зүйл. Хуулийн нэр томьёоны тодорхойлолт**

1. Энэ хуульд хэрэглэсэн нэр томьёог дараахь утгаар ойлгоно:

1/ "хамгаалагч" гэж Монгол Улсын хууль, олон улсын гэрээний дагуу төрийн тусгай хамгаалалтад авахаар тогтоосон албан тушаалтан, иргэнийг;

2/ "шадар хамгаалалт" гэж хамгаалуулагчийг биечлэн дагаж хамгаалахыг;

3/ "гадуур хамгаалалт" гэж хамгаалуулагчийг үзвэр, үйлчилгээ, олон нийтийн болон бусад арга хэмжээнд оролцох, нийслэл хот, орон нутагт явах үед тэдний аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор тодорхой орчин, нутаг дэвсгэрт төрийн тусгай хамгаалалтын хүч хэрэгслээр ил хэлбэрээр зохиож байгаа хамгаалалтыг;

4/ "далд хамгаалалт" гэж хамгаалуулагчийн аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор тэдний ажиллаж, амьдарч, байрлаж байгаа орчин, явах зам, чиглэлийн дагуу далд хэлбэрээр зохиож байгаа хамгаалалтыг;

5/ "цувааны хамгаалалт" гэж хамгаалуулагчийг автотээврийн хэрэгслээр зорчих үед гадны халдлага, болзошгүй ослоос хамгаалах зорилгоор төрийн тусгай хамгаалалтын хүч хэрэгслээр автоцувааны дотор зохиож байгаа хамгаалалтыг;

6/ "төрийн тусгай хамгаалалтын бүс" гэж гадуур хамгаалалт зохиож байгаа болон төрийн тусгай хамгаалалтад авсан барилга, бусад зүйлд хамаарах тодорхой орчин, нутаг дэвсгэрийг тус тус хэлнэ.

**ХОЁРДУГААР БҮЛЭГ**

**Төрийн тусгай хамгаалалтын хамрах хүрээ, зэрэглэл**

**6 дугаар зүйл. Төрийн тусгай хамгаалалтад байх албан тушаалтан, иргэн**

1. Дараахь албан тушаалтан, иргэн төрийн тусгай хамгаалалтад байна:

1/ Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд;

2/ Улсын Их Хурлын даргын үүрэг гүйцэтгэгч, Ерөнхий сайдын үүргийг олон гүйцэтгэгч;

3/ Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдын алба хашиж байсан иргэнийг хуульд заасан, эсхүл Улсын Их Хурлаас тогтоосон хугацаанд;

4/ Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчийг сонгуулийн компани эхэлсэн өдрөөс сонгуулийн албан ёсны дүн гарах хүртэлх хугацаанд;

5/ Монгол Улсад айлчилж байгаа гадаад орны төр, засгийн газрын тэргүүн, өөрийн хамгаалалттай ирсэн дээд, өндөр хэмжээний зочин.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасан хамгаалуулагчийн албан үүрэгтэй нь холбогдуулан түүний эхнэр /нөхөр/, насанд хүрээгүй хүүхдийн амь биед гадны аюул учирч болзошгүй тохиолдолд тухайн нөхцөл байдал арилах хүртэл тэднийг төрийн тусгай хамгаалалтад түр хугацаагаар авч болно.

3. Монгол Улсын аюулгүй байдлын эрх ашгийн үүднээс энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт зааснаас бусад албан тушаалтан, иргэнийг төрийн тусгай хамгаалалтад хамааруулах асуудлыг Улсын Их Хурал шийдвэрлэнэ.

4. Төрийн тусгай хамгаалалтад байгаа албан тушаалтан, иргэн нь энэ хууль түүнтэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам, зааврыг хүндэтгэн биелүүлнэ.

7 дугаар зүйл. Төрийн тусгай хамгаалалтад байх хурал, чуулган, бусад арга хэмжээ

1. Улсын Их Хурлын чуулганы болон Засгийн газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдаан, олон улсын дээд хэмжээний уулзалт, хэлэлцээ, хурал, зөвлөлгөөн төрийн тусгай хамгаалалтад байна.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хурал, чуулган бусад арга хэмжээ явагдаж байгаа танхим, түүний орчинд эрх бүхий байгууллагаас тогтоосон дэг журам зөрчихийг хориглоно.

8 дугаар зүйл. Төрийн тусгай хамгаалалтад байх барилга, тээврийн хэрэгсэл, бусад зүйл.

1. Төрийн тусгай хамгаалалтад дараахь барилга, тээврийн хэрэгсэл байна:

1/ Монгол Улсын Төрийн ордон, Ерөнхийлөгчийн ордон, өргөө,



Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдын зориулалтын орон сууц, төрийн харш, гадаадын дээд, өндөр хэмжээний зочдын байрлах зочид буудал;

2/ хамгаалуулагчийн хөлөглөж яваа болон зориулалтын тээврийн хэрэгсэл.

2. Төрийн тусгай хамгаалалтад зайлшгүй байх шаардлагатай бусад зүйлийн жагсаалтыг Засгийн газар батална.

3. Төрийн тусгай хамгаалалтын бүс, хамгаалалтад авсан барилга, бусад зүйлд эрх бүхий албан тушаалтан, төрийн хамгаалалтын эрх бүхий албан хаагчаас бусад хүн зөвшөөрөлгүй, эсхүл зэвсэг, тусгай хэрэгсэлтэй нэвтрэн орох, тэдгээрийн орчинд цэрэг, зэвсэг техникийн хүч хуралдуулахыг хориглоно.

9 дүгээр зүйл. Төрийн тусгай хамгаалалтын зэрэглэл

1. Төрийн тусгай хамгаалалт нь хамрах хүрээ, хүч хэрэгсэл, нөхцөл байдлаас шалтгаалан дараахь зэрэглэлтэй байна:

- 1/ нэгдүгээр зэрэглэл;
- 2/ хоёрдугаар зэрэглэл;
- 3/ гуравдугаар зэрэглэл;
- 4/ дөрөвдүгээр зэрэглэл.

2. Төрийн тусгай хамгаалалтад байх албан тушаалтан, иргэн дараахь зэрэглэлд тус тус хамаарна:

1/ нэгдүгээр зэрэглэлийн төрийн тусгай хамгаалалтад Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Монгол улсад айлчилж байгаа гадаад орны төр, засгийн газрын тэргүүн, өөрийн хамгаалалттай ирсэн дээд хэмжээний зочин;

2/ хоёрдугаар зэрэглэлийн төрийн тусгай хамгаалалтад Улсын Их Хурлын даргын үүрэг гүйцэтгэгч, Ерөнхий сайдын үүргийг орлон гүйцэтгэгч, Монгол Улсад айлчилж байгаа гадаад орны өндөр хэмжээний зочин;

3/ гуравдугаар зэрэглэлийн төрийн тусгай хамгаалалтад Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдын алба хашиж байсан иргэн, Монгол Улсын хууль, олон улсын гэрээний дагуу төрийн тусгай хамгаалалтад авах бусад албан тушаалтан, иргэн;

4/ дөрөвдүгээр зэрэглэлийн төрийн тусгай хамгаалалтад энэ хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасан хамгаалуулагчийн эхнэр, /нөхөр/, насанд хүрээгүй хүүхэд хуульд заасан нөхцөл байдлын үед түр хугацаагаар.

3. Хамгаалалтын зэрэглэл тус бүрийн онцлогт тохирсон хүч хэрэгслийн хэмжээ, тэдгээрийг хамгаалалтын тухайн нөхцөл байдалд нийцүүлэн зохицуулах журмыг Засгийн газар батална.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

### Төрийн тусгай хамгаалалтын газар, түүний эрх, үүрэг

10 дугаар зүйл. Төрийн тусгай хамгаалалтын  
газар

1. Төрийн тусгай хамгаалалтын чиг үүргийг Тагнуулын төв газрын даргын Дэргэдэх төрийн тусгай хамгаалалтын газар хэрэгжүүлнэ.

2. Төрийн тусгай хамгаалалтын газрын бүтцийг төрийн тусгай хамгаалалтын иж бүрэн байх зарчимд нийцүүлэн Засгийн газар тогтооно.

3. Төрийн тусгай хамгаалалтын газар нь бэлгэ тэмдэгтэй байна. Бэлгэ тэмдгийн загвар, хэрэглэх журмыг Засгийн газар батална.

4. Төрийн тусгай хамгаалалтын газар нь тогтоосон журмын дагуу үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

5. Төрийн тусгай хамгаалалтын газрын даргыг Монгол Улсын Ерөнхий сайдад танилцуулж, Тагнуулын төв газрын дарга томилно.

6. Төрийн тусгай хамгаалалтын газар улсын төвлөрсөн төсвөөс санхүүжинэ.

11 дүгээр зүйл. Төрийн тусгай хамгаалалтын газрын  
эрх, үүрэг

1. Төрийн тусгай хамгаалалтын газар дараахь эрх эдлэнэ:

1/ төрийн тусгай хамгаалалтад байгаа барилга, бусад зүйл, тэдгээрийн орчинд эмх замбараагүй байдал үүсэх, гэнэтийн осол гарах зэргээр нөхцөл байдал хүндэрсэн үед цагдаа, дотоодын цэрэг, иргэний хамгаалалтын төв, орон нутгийн байгууллагаас туслалцаа авах, харилцаа ажиллах;

2/ төрийн тусгай хамгаалалтын бүс, төрийн тусгай хамгаалалтад авсан барилга, бусад зүйлд нэвтрэн орох журам, дэглэм тогтоох, хяналт тавих;

3/ хамгаалуулагч, төрийн тусгай хамгаалалтад авсан барилга, бусад зүйлийн аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор төр, захиргаа, олон нийтийн байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтнаас

гаргуулж авах;

4/ хамгаалуулагчийн аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор ивэн зорчигч, автотээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг шаардлагатай тохиолдолд түр зогсоох, чиглэлийг өөрчлүүлэх;

5/ энэ хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасан, шаардлагатай тохиолдолд бусад хамгаалуулагчийг орон нутагт нисэх онгоц, галт тэргээр зорчин явах үед аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор уул тээврийн хэрэгслээр тухайн үед зорчих хүмүүс, тэдний ачаа тээшийг шалгахад, түүнчлэн хамгаалуулагчийг гадаадад явах үед хамт явах зорчигчдод Монгол Улсын нутаг дэвсгэрт гаалийн шалгалт хийхэд алба хаагчаа байлцуулах;

6/ хамгаалуулагчид дотоод, гадаадаас ирүүлсэн бэлэг дурсгал, бусад зүйлд тэсэрч дэлбэрэх, хордуулах бодис байгаа эсэхэд мэргэжлийн болон холбогдох байгууллагаар шалгалт, шинжилгээ хийлгэх;

7/ хамгаалуулагчийн хоол хүнсний бүтээгдэхүүн, тээврийн хэрэгсэл, үйлчилгээнд шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор үзлэг, шалгалт хийж, дүнг холбогдох байгууллагад мэдэгдэх;

8/ гадаад орны төрийн хамгаалалтын байгууллагатай хамтран ажиллах, мэдээлэл солилцох.

2. Төрийн тусгай хамгаалалтын газар дараахь үүрэгтэй байна:

1/ Улсын Их Хурлын чуулганы болон Засгийн газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдаан, олон улсын дээд хэмжээний уулзаат, хэлэлцээ, хурал, зөвлөлгөөний аюулгүй байдлыг хамгаалах;

2/ хамгаалуулагчийг шадарлан хамгаалах;

3/ хамгаалуулагчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор гадуур болон далд хамгаалалт зохион байгуулах;

4/ Төрийн ордыг хамгаалах;

5/ төрийн тусгай хамгаалалтын бүс, барилга, бусад зүйлийг харуулын салбарын хамгаалалтад авах;

6/ энэ хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 5-д заасан хамгаалуулагчийг үйлчлэх бүрэлдэхүүн, хүнсний бүтээгдэхүүнээр хангах;

7/ хамгаалуулагчийг зориулалтын автотээврийн хэрэгслээр үйлчлэх;

8/ төрийн тусгай хамгаалалтад байгаа барилга, тээврийн хэрэгсэл, бусад зүйл тэдгээрийн орчинд холбогдох байгууллагуудтай хамтран инженер-техникийн үзлэг, шалгалт хийж аюулгүй байдлыг хангах;

9/ хамгаалуулагчийн аюулгүй байдлыг хангах талвар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний тухай өөрт нь мэдээлж, танилцуулах.

12 дугаар зүйл. Төрийн тусгай хамгаалалтын газрын даргын бүрэн эрх

Төрийн тусгай хамгаалалтын газрын дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ төрийн тусгай хамгаалалтын бодлогыг хэрэгжүүлэх;

2/ байгууллагын дүрэм, журам, зааврыг батлуулж мөрдүүлэх;

3/ хуваарилан олгосон төсөв, хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, гүйцэтгэлд нь хяналт тавих;

4/ Тагнуулын төв газрын даргатай зөвшилцөн боловсон хүчнийг томилох, чөлөөлөх;

5/ төрийн тусгай хамгаалалтад оролцож байгаа бусад байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хамтарсан шийдвэр гаргаж хэрэгжүүлэх;

6/ байгууллагаа төлөөлөн дотоод, гадаадын байгууллагатай харилцан ажиллах.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч,  
түүний эрх зүйн байдлын онцлог

13 дугаар зүйл. Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч

1. Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн тангараг өргөж, хамгаалалтын үүрэг гүйцэтгэж байгаа иргэнийг төрийн тусгай хамгаалалтын алба хаагч гэнэ. Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч нь засаг, захиргааны төлөөлөгч мөн.

2. Төрийн тусгай хамгаалалтын албанд 20 нас хүрсэн, эрүүл мэнд, бие бялдар, ёс зүйн шаардлага хангасан, зохих боловсрол, ажлын туршлагатай, ил шийтгэлгүй, Монгол Улсын иргэнийг ажиллуулна.

14 дүгээр зүйл. Төрийн тусгай хамгаалалтын алба  
хаагчийн тангараг

1. Монгол Улсын иргэн төрийн тусгай хамгаалалтын албанд  
анх орохдоо Төрийн сүлдэнд:

"Монгол Улсын иргэн Би, төрийн тусгай хамгаалалтын үүрэг  
гүйцэтгэхдээ төрөө хүндэтгэн, хууль ёсыг дээдэлж, төрийн нууц-  
цыг чанд хадгалан, хүлээсэн үүрэгтээ үнэнч байж, амь биеэ үл  
хайрлан ажиллахаа батлан тангараглая. Би энэ тангарагаас  
ницвас төрийн хуулийн цээрлэл хүлээнэ." гэж Тангараг өргөнө.

2. Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн тангараг өргөх  
журмыг Монгол Улсын Ерөнхийлөгч батална.

15 дугаар зүйл. Төрийн тусгай хамгаалалтын алба  
хаагчийн эрх, үүрэг

Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч албан үүрэг гүйцэтгэж  
байхдаа дараахь эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

1/ төрийн тусгай хамгаалалттай холбогдсон хүсэлт шаардлагыг  
иргэд, албан тушаалтанд тавих, дэмжлэг туслалцаа авах, төрийн  
тусгай хамгаалалтын бүс, төрийн тусгай хамгаалалтад авсан  
барилга, бусад зүйлд нэвтрэн орох хүмүүсийн үнэмлэх, нэвтрэх  
бичгийг шалгах;

2/ төрийн тусгай хамгаалалтад байгаа барилга бусад зүйл,  
тэдгээрийн орчинд сэжиг бүхий этгээд илэрвэл түүний бие, эд  
зүйл, тээврийн хэрэгсэлд үзлэг хийх, уул этгээдийг 2 цаг хүртэл  
хугацаагаар түр саатуулах, зэвсэг, зэвсгийн чанартай зүйл, тэсэрч  
дэлбэрэх, хордуулах бодис илэрвэл хураан авах, холбогдох бай-  
гууллагад шилжүүлэх;

3/ хамгаалуулагчид бодитой аюул учирсан тохиолдолд шаард-  
лагатай бол хуулиар хориглосноос бусад автотээврийн хэрэгсэл  
болон бусад уналга дайчлах;

4/ төрийн тусгай хамгаалалтын ажлын шаардлагаар байгуул-  
лага, иргэдийн телефон утсаар үнэ төлбөргүй, нийтийн холбооны  
хэрэгсдээр дарвалал харгалзахгүй үйлчлүүлэх, байр орон сууцанд  
ээмшигчийн зөвшөөрлөөр нэвтрэн орох;

5/ албан үүргээ гүйцэтгэж байхдаа зэвсэг, тусгай хэрэгсэл  
биедээ авч явах, тогтоосон журмын дагуу хэрэглэх;

6/ өргөсөн тангарагтаа үнэнч байх;

7/ удирдах байгууллагын шийдвэр, захирах даргын тушаалыг  
биедүүлэх;

8/ хамгаалуулагчийн хувийн нууцыг чанд хадгалах;

9/ хамгаалалтын ажлын мэдлэг, тусгай бэлтгэлээ байнга дээшлүүлж, шударга, санаачилгатай ажиллах.

16 дугаар зүйл. Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн үүргээ биелүүлэх баталгаа

1. Албан үүргээ биелүүлэх үед нь төрийн тусгай хамгаалалтын алба хаагчид учирсан хохирлыг төр хариуцна.

2. Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн ажлыг захирах даргад нь мэдэгдэлгүйгээр шалгах, албан үүргээ гүйцэтгэхэд нь саад учруулах, хуулиар хүлээсэн үүрэгт нь үл хамаарах ажил үүрэг гүйцэтгүүлэхийг хориглоно.

3. Гүйцэтгэж байгаа ажил үүрэгтэй нь холбогдуулан төрийн тусгай хамгаалалтын алба хаагч /гэр бүлийн гишүүн/-ийн амь биед аюул учирч болзошгүй бодитой нөхцөл байдал бий болсон тохиолдолд түүнийг хамгаалалтад авч болно.

4. Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч нь Тагнуулын төв газрын тусгай албаныхтай адилтгах албан тушвалын ангилал, цолны зэрэглэл, дүрэмт хувцас хэрэглэх буюу, эсхүл түүнд зориулсан мөнгөн хангамж эдэлнэ.

5. Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн нийгмийн баталгааг Улсын аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 5, 6, 7, 8, 9, 10, 11 дэх хэсгийн заалтаар зохицуулна.

6. Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн тусгай хамгаалалтын нэмэгдлийг Засгийн газар тогтооно.

17 дугаар зүйл. Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн эрх зүйн байдлын онцлог

1. Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчид дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

1/ удирдах байгууллага, захирах даргын зөвшөөрөлгүйгээр жагсаал, цуглаан зохион байгуулах, албан үүргийн бус шугамар тэдгээрт оролцох, байлцах;

2/ хамгаалуулагчийн тухай өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд арилцлага өгөх, хувийн нууцных нь талаар хэвлэл нийтлэх;

3/ үүрэг гүйцэтгэж байхдаа ажлын байрнаа захирах даргын зөвшөөрөлгүйгээр орхиж явах, бусдад шалжүүлэх;

4/ хамгаалуулагчийн нэр төр, албан тушвалыг ашаглах, улс төрийн зорилгоор эвлэлдэн нэгдэх, улс төрийн үйл ажиллагаа явуулдаг нам, эвсэл, холбооны гишүүний эрх, үүрэгтэй байх;

5/ үүргээ гүйцэтгэж байхдаа энэ хуулийг хэрэгжүүлэхэд чиглэснээс бусад үйл ажиллагаа явуулах.

2. Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийг хамгаалж байган байгууллага, хамгаалуулагчийг тагнан турших үйл ажиллагаанд ашиглахыг хориглоно.

3. Шаардлагатай тохиолдолд төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн амралтын цагийг хязгаарлах буюу илүү цагаар ажиллуулж болно.

## ТАВДУГААР БҮЛЭГ

Төрийн тусгай хамгаалалтын талаар тагнуул,

цагдаа болон бусад байгууллага, албан

тушаалтан, иргэний хүдээх үүрэг

18 дугаар зүйл. Тагнуулын байгууллагын үүрэг

1. Тагнуулын төв байгууллагын дарга нь төрийн тусгай хамгаалалтын байгууллагын ажлыг чиглүүлэн удирдаж боловсон хүчин бэлтгэх, эвсэг, техник, материал хэрэгслээр хангах, санхүү, аж ахуйн талаар бэхжүүлэх бодлого боловсруулан Засгийн газарт уламжилж, энэ талаар гарсан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавина.

2. Тагнуулын байгууллага нь хамгаалуулагч болон төрийн тусгай хамгаалалтын байгууллагыг холбогдох мэдээллээр ханган тусгай зорилгалтын холбоогоор үйлчилж, шаардлагатай бусад туслалцаа үзүүлнэ.

3. Тагнуулын байгууллагын орон нутаг дахь нэгжүүд нь цагдаагийн болон холбогдох байгууллагатай хамтран зохиох төрийн тусгай хамгаалалтыг тус тусын нутаг дэвсгэрт нэгтгэн удирдана.

19 дүгээр зүйл. Цагдаагийн байгууллагын үүрэг

1. Цагдаагийн байгууллага нь энэ хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 5-д заасан, шаардлагатай тохиолдолд бусад хамгаалуулагчийг баар ёслол, олон нийтийн болон бусад арга хэмжээнд оролцох, автотээврийн хэрэгслээр зорчих, орон нутагт байх үед хөтөч машин ажиллуулж, хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган, хэв журмын хамгаалалт зохино.

2. Төрийн тусгай хамгаалалтад авсан барилга, бусад зүйлийг галын аюулаас өнцлөн хамгаалж, шаардлагатай үед тэдгээрийн орчинд гэмт хэрэг, хэв журмын зөрчлөөс урьдчилан сэргийлэх эргүүл ажиллуулна.

3. Нийтийн эмх замбараагүй байдал үүссэн буюу үүсч болзошгүй бодитой нөхцөлд төрийн тусгай хамгаалалтад хүч нэмэгдүүлж хамтран ажиллана.

4. Цагдаагийн байгууллага нь төрийн тусгай хамгаалалтын байгууллагатай харилцан ажиллах журмыг хамтран баталж, төрийн тусгай хамгаалалтад шаардагдах эрүүгийн нөхцөл байдлын мэдээг цаг тухайд нь өгч байна.

20 дугаар зүйл. Бусад байгууллага, албан тушаалтан,  
иргэний үүрэг

1. Төрийн захиргааны төв, орон нутгийн болон олон нийтийн байгууллага, аж ахуйн нэгж, тэдгээрийн албан тушаалтан төрийн тусгай хамгаалалтын байгууллагын хүсэлтээр холбогдох мэдээ, судалгаа гарган өгч, шаардлагатай бусад туслалцаа үзүүлнэ.

2. Гаднаад харилцаа эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Төрийн ёслолын алба нь хамгаалуулагчийн оролцох төрийн ёслол, хүндэтгэлийн болон бусад арга хэмжээний талаар төрийн тусгай хамгаалалтын байгууллагад мэдээлэл өгч, хамгаалалтын талаархи санал зөвлөгөөг нь тусгаж ажиллана.

3. Хамгаалуулагчийг гаднаад оронд айлчлах, дамжин өнгөрөх үед тухайн оронд байгаа Монгол Улсын бүрэн эрхт болон байнгын төлөөлөгчийн газар хамгаалалтын ажилд дэмжлэг, туслалцаа үзүүлнэ.

4. Иргэний агаарын тээврийн байгууллага нь хамгаалуулагчийн хөлөглөн явах агаарын хөлгийн техникийн болон нислэгийн аюулгүй байдлыг хангана.

5. Төмөр замын байгууллага нь хамгаалуулагчийн хөлөглөн явах галт тэрэгний зам, техникийн болон хөдөлгөөний аюулгүй байдлыг хангана.

6. Төр, засгийн үйлчилгээ, аж ахуйг эрхэлж байгаа байгууллага нь нэгдүгээр зэрэглэлийнхээс бусад хамгаалуулагчийг хүнсний бүтээгдэхүүн болон бусад зүйлээр хангаж, үйлчилнэ.

7. Эрүүл мэндийн байгууллага нь хамгаалуулагчийн эрүүл мэндийг онцлон хамгаалж, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан хамгаалуулагчийн хэрэгцээний хүнсний болон бусад зүйлд шаардлагатай тохиолдолд лабораторийн шинжилгээ хийж, төрийн тусгай хамгаалалтын байгууллагад холбогдох мэдээ, судалгааг өгнө.

8. Холбооны байгууллага нь хамгаалуулагчийг найдвартай, шуурхай холбоогоор хангаж, түүний нууцлалыг хамгаалан, шаардлагатай үед олон улсын холбооны тусгай сувгаар савдгүй үйлчилнэ.



9. Монгол Улсын иргэд төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн хүсэлт, хуульд нийцүүлэн тавьсан шаардлагыг биедүүлж, бүхий л бололцоотой дэмжлэг туслалцаа үзүүлнэ.

## ЗУРГАДУГААР БҮЛЭГ

### Бусад зүйл.

21 дүгээр зүйл. Төрийн тусгай хамгаалалтын зэвсэг, тусгай хэрэгсэл

Төрийн тусгай хамгаалалтын байгууллага, алба хаагч төрийн тусгай хамгаалалтын үүрэг гүйцэтгэхдээ дараахь зэвсэг болон тусгай хэрэгсэл, мэх хэрэглэнэ:

- 1/ галт зэвсэг;
- 2/ хүйтэн зэвсэг;
- 3/ нэг бүрийн тусгай хэрэгсэл;
- 4/ автотээврийн хэрэгсэл албадан зогсоох тусгай хэрэгсэл;
- 5/ хамгаалах тусгай хэрэгсэл;
- 6/ зэвсэггүйгээр тулалдах мэх;
- 7/ албаны нохой.

22 дугаар зүйл. Зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэх

1. Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч дараахь тохиолдолд галт зэвсэг хэрэглэх эрхтэй:

1/ хамгаалуулагч төрийн тусгай хамгаалалтад авсан барилга, бусад зүйл, үүргээ гүйцэтгэж байгаа хамгаалалтын алба хаагчид галт зэвсэг хэрэглэн халдсан буюу халдахыг завдсан;

2/ хамгаалуулагч, төрийн тусгай хамгаалалтад авсан барилга, бусад зүйлд нэгцлэн хохирол учруулж болзошгүй байдлаар халдсан буюу халдахаар завдсан этгээдийн үйлдлийг өөр аргаар таслан зогсоох боломжгүй;

3/ хамгаалуулагч, төрийн тусгай хамгаалалтад авсан барилга, бусад зүйлийг барьцаанд авахаар завдсан үйлдлийг таслан зогсоох, барьцаанаас чөлөөлөх.

2. Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч хүйтэн зэвсэг, нэг бүрийн тусгай хэрэгсэл, зэвсэггүйгээр тулалдах мэхийг дараахь тохиолдолд хэрэглэнэ:

- 1/ энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан бүх тохиолдолд;
- 2/ төрийн тусгай хамгаалалтын бүсэд хэв журам зөрчигдсөн;
- 3/ хамгаалуулагчийн явах замыг чөлөөлөх;

4/ хамгаалуулагч, төрийн тусгай хамгаалалтад авсан барилга, бусад зүйлд хүйтэн зэвсэг, зэвсгийн чанартай бусад зүйл хэрэглэн халдсан буюу халдахыг зөвшөөрсөн;

5/ сэжигтэн этгээдийг саатуулах, зохих байгууллагад хүргэх үед эсэргүүцэл үзүүлдсэн.

3. Хамгаалуулагчийн амь бие, төрийн тусгай хамгаалалтад авсан барилга, бусад зүйлд автотээврийн хэрэгсэл ашиглан ноцтой хохирол учруулж болзошгүй бодит аюулыг таслан зогсоох шаардлага тулгарсан тохиолдолд автотээврийн хэрэгслийг албадан зогсоох тусгай хэрэгсэл хэрэглэж болно.

4. Автотээврийн хэрэгслийг албадан зогсоох тусгай хэрэгслийг хэрэглэх боломжгүй тохиолдолд автомашин болон бусад зүйлдээр хаалт тавьж болно.

5. Зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэснээс хүний амь бие, эрүүд мэндэд хохирол учирсан тохиолдолд төрийн тусгай хамгаалалтын алба хаагч нь эмнэлгийн байгууллага, захирах даргадаа, захирах дарга нь прокурорт нэн даруй мэдэгдэнэ.

6. Төрийн тусгай хамгаалалтад хэрэглэх зэвсэг, тусгай хэрэгслийг хэрэглэх зааврыг Тагнуулын төв газрын дарга, Улсын ерөнхий прокурортой хамтран батална.

23 дугаар зүйл. Хариуцлага

Төрийн тусгай хамгаалалтын бүсэд төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн хуульд нийцүүлэн тавьсан шаардлагыг зориуд биелүүлдэггүй, биелүүлэхгүй байхыг уриалсан, эсэргүүцсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол төрийн тусгай хамгаалалтын эрх бүхий ажилтан Захиргааны хариуцлагын тухай хуульд заасан шийтгэл ногдуулна.

24 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийг 1995 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Монгол Улсын Их Хурлын дарга

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 4 дүгээр  
сарын 28-ны өдөр

Улаанбаатар  
хот

Захиргааны хариуцлагын тухай хуульд  
зарим нэмэлт оруулах тухай

1 дүгээр зүйл. Захиргааны хариуцлагын тухай хуульд дор  
турдсан агуулгатай дараахь зүйл, заалт нэмсүгэй:

1/ 7 дугаар зүйлийн 8 дахь заалт:

"8/ төрийн тусгай хамгаалалтын газрын гадуур хамгаалалтын  
алба хаагч, харуулын захирал."

2/ 10 дугаар зүйлийн 7 дахь заалт:

"7/ төрийн тусгай хамгаалалтын газрын гадуур хамгаалалтын  
алба хаагч, харуулын захирал энэ зүйлийн 30<sup>5</sup> дугаар зүйлд  
ивасан зөрчил."

3/ 30<sup>5</sup> дугаар зүйл:

"30<sup>5</sup> дугаар зүйл. Төрийн тусгай хамгаалалтын алба  
хаагчийн хууль ёсны шаардлагыг  
биелүүлэхгүй байх

Төрийн тусгай хамгаалалтын бүсэд төрийн тусгай хамгаалалтын  
алба хаагчийн тавьсан хууль ёсны шаардлагыг зориуд биелүү-  
лээгүй, биелүүлэхгүй байхыг уриалсан, эсэргүүцсэн бол 500-20000  
төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна."

2 дугаар зүйл. Энэ хуулийг төрийн тусгай хамгаалалтын тухай  
хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Монгол Улсын Их Хурлын дарга

Н. БАГАБАНДИ

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

1995 оны 5 дугаар  
сарын 4-ний өдөр

Улаанбаатар  
хот

**КОНВЕНЦИД НЭГДЭН ОРОХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. 1973 оны 3-дугаар сарын 3-ны өдөр Вашингтон хотноо байгуулсан "Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай" конвенцид нэгдэн орсугай.

Монгол Улсын Их Хурлын дарга

**Н. БАГАБАНДИ**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТОГТООЛ**

1995 оны 4 дүгээр  
сарын 18-ны өдөр

Дугаар 22

Улаанбаатар  
хот

**Төрийн нууцны тухай Монгол Улсын  
хуулийг хэрэгжүүлэх зарим арга  
хэмжээний тухай**

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Төрийн нууцны тухай Монгол Улсын хууль батлагдсантай холбогдуулан дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт даалгасугай:

1/ Сайд нарны Зөвлөл, Засгийн газрын урьд гарсан шийдвэрийг энэ оны 6 дугаар сард багтаан Төрийн нууцны тухай Монгол Улсын хуульд нийцүүлэх;

2/ "Төрийн холбоо, шуудан, шифр, тоон мэдээллийн харилцааны дүрэм"-ийг энэ оны эхний хагаст багтаан баталж мөрдүүлэх;

3/ төрийн нууцыг хадгалах, хамгаалах, ашиглах ажлыг улс орны хэмжээнд зохицуулах мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах үүргийг хүлээж байгаатай холбогдуулан Тагнуулын төв газрын бүтэц, орон тоо, төсөвт зохицуулалт хийх асуудлыг энэ оны 6 дугаар сард багтаан шийдвэрлэх.

Дарга

**Н. БАГАБАНДИ**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТОГТООЛ**

1995 оны 4 дүгээр  
сарын 28-ны өдөр

Дугаар 23

Улаанбаатар  
хот

**Төрийн тусгай хамгаалалтын тухай  
Монгол Улсын хуулийг хэрэгжүүлэх  
зарим арга хэмжээний тухай**

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Төрийн тусгай хамгаалалтын тухай Монгол Улсын хууль батлагдсантай холбогдуулан дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт даалгасугай:

1/ төрийн тусгай хамгаалалтын газрын бүтэц, төрийн тусгай хамгаалалтын хүч хэрэгслийг зохицуулах журам, алба хаагчийн тусгай хамгаалалтын нэмэгдлийг энэ оны 6 дугаар сард багтаан тогтоох;

2/ төрийн тусгай хамгаалалтын газрын бэлгэ тэмдэг, түүнийг хэрэглэх журам, төрийн тусгай хамгаалалтад зайлшгүй байх шаардлагатай зүйлийн жагсаалтыг батлах;

3/ төрийн тусгай хамгаалалтын газрыг зохион байгуулалтын хувьд бэхжүүлэх, ажиллах нөхцөл, шаардлагатай орон тоо, төсөн хөрөнгөөр хангах асуудлыг 1995 оны 6 дугаар сард багтаан шийдвэрлэх.

Дарга

Н. БАГАБАНДИ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТОГТООЛ**

1995 оны 5 дугаар  
сарын 4-ний өдөр

Дугаар 24

Улаанбаатар  
хот

**Олон улсын конвенцид нэгдэн орсонтой  
холбогдуулан авч хэрэгжүүлэх зарин  
арга хэмжээний тухай**

Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

Монгол Улс "Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдвалах тухай" 1973 оны 3 дугаар сарын 3-ны өдөр Вашингтон хотноо байгуулсан конвенцид нэгдэн орсонтой холбогдуулан дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт даалгасугай:

1/ зэрлэг амьтан, ургамлын ховордсон зүйлийг улсын хилээр нэвтрүүлэхэд тавих гаалийн хяналт, эдгээр зүйлийг ашиглан худалдаа аж ахуй эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн байгуулж байгаа олон улсын гэрээнд тавих хяналтыг зохион байгуулах;

2/ конвенцийн Есдүгээр зүйлд заасан Удирдан зохицуулах болон Шийжлэх ухваны байгууллагын гүйцэтгэх үүргийг холбогдох байгууллагад хариуцуулах.

Дарга

Н. БАГАБАНДИ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТОГТООЛ**

1995 оны 5 дугаар  
сарын 4-ний өдөр

Дугаар 26

Улаанбаатар  
хот

**Улсын тусгай хамгаалалттай газрын ангил-  
лыг шинэчлэн тогтоох тухай**

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай Монгол Улсын хуулийн 25 дугаар зүйлийн 2-т заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ нь:**

1. Дараахь газар нутгийг дархан цаазтай газарт хамааруулж дор дурдсанаар нэрлэсүгэй:

1/ Говь-Алтай, Баянхонгор, Ховд аймгийн зарим газар нутгийг хамарсан "Говийн их дархан цаазат газар";

2/ Баян-Өлгий аймгийн Дэлүүн, Ховд аймгийн Ховд сумын хилийн зааг орчмын зарим газар нутгийг хамарсан "Хөх сэрхийн нурууны дархан цаазат газар";

3/ Улаанбаатар хотын урд хэсэгт орших "Богдхан уулын дархан цаазат газар";

4/ Говь-Алтай аймгийн Жаргалан, Шарга сумын хилийн зааг орчмын зарим газар нутгийг хамарсан "Хасагт хайрхан уулын дархан цаазат газар";

5/ Хэрлэн, Онон, Туул голуудын эх авсан Хэнтийн нурууны төв хэсгийн газар нутгийг хамарсан "Хэн Хэнтийн дархан цаазат газар";

6/ Дорнод аймгийн Халх гол сумын зүүн хэсгийн зарим газар нутгийг хамарсан "Нөмрөгийн дархан цаазат газар";

7/ Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан, Дорнод аймгийн Матад, Халх гол сумын хилийн зааг орчмын зарим газар нутгийг хамарсан "Дорнод монголын дархан цаазат газар";

8/ Дорнод аймгийн Чулуунхороот, Гурванзагал сумын хилийн зааг орчмын нутаг, Улт голын сав дагуух зарим газар нутгийг хамарсан "Монгол дагуурын дархан цаазат газар";

9/ Завхан аймгийн Алдархаан, Отгон сумын зарим газар нутгийг хамарсан "Отгонтэнгэр уулын дархан цаазат газар".

2. Дараахь газар нутгийг байгалийн цогцолборт газарт хамааруулж дор дурдсанаар нэрлэсүгэй:

1/ Архангай аймгийн Тариат сумын зарим газар нутгийг хамарсан "Хорго-Тэрхийн цагаан нуурын байгалийн цогцолборт газар";

2/ Хөвсгөл нуур, түүний сав газар, Үүр-Уйлганы орчмын зарим газар нутгийг хамарсан "Хөвсгөлийн байгалийн цогцолборт газар".

3. Дараахь газар нутгийг байгалийн ноёд газарт хамааруулж дор дурдсанаар нэрлэсүгэй:

1/ Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг дахь "Нагалхаан уулын байгалийн ноёд газар";

2/ Төв аймгийн Эрдэнэсант, Өвөрхангай аймгийн Бүрд сумын хилийн заагт орших "Батхаан уулын байгалийн ноёд газар";

3/ Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутаг дахь "Дхачинвандад уулын байгалийн ноёд газар";

4/ Хөвд аймгийн Булган сумын нутаг дахь "Булган голын байгалийн ноёд газар".

4. Дараахь газар нутгийг байгалийн дурсгалт газарт хамааруулж дор дурдсанаар нэрлэсүгэй:

1/ Архангай аймгийн Эрдэнэ-Булган сумын нутаг дахь "Булган уулын дурсгалт газар";

2/ Булган аймгийн Хутаг сумын нутаг дахь "Уриан-Тогоо-Тулга уулын дурсгалт газар";

3/ Говь-Алтай аймгийн Алтай, Цогт суманд орших "Ээж хайрхан уулын дурсгалт газар";

4/ Өвөрхангай аймгийн Уинга сумын нутаг дахь "Хүйсийн найман нуурын дурсгалт газар".

5. Энэ тогтоолын 1, 2 дахь хэсэгт заасан дархан цаазат болон байгалийн цогцолборт газар, "Зарим газрыг улсын тусгай хамгаалалтад авахыг зөвшөөрөх тухай" Улсын Их Хурлын 1993 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 83 дугаар тогтоолын 1 хэсгийн 1, 2-г заасан "Увс нуурын ай савын дархан цаазат газар", Горхи-Тэрэлжийн болон "Говь гурван сайханы байгалийн цогцолборт газар"-ын хилийн заагийг тогтоолын 1, 2 дугаар хавсралтаар баталсугай.



6. "Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авахыг зөвшөөрөх тухай" БНМАУ-ын Бага Хурлын 1992 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн 11 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

7. "Зарим газрыг улсын тусгай хамгаалалтад авахыг зөвшөөрөх тухай" Улсын Их Хурлын 1993 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 83 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтаас "Үндэсний" гэсэн үгийг хассугай.

Дарга

Н. БАГАБАНДИ

Монгол Улсын Их Хурлын  
1995 оны 26 дугаар тогтоолын  
1 дүгээр хавсралт

### ДАРХАН ЦААЗАТ ГАЗРЫН ХИЛИЙН ЗААГ

1. Говийн их дархан цаазат газрын хилийн зааг:  
"А" хэсэг

Улсын хилийн 161 дүгээр багана, түүнээс зүүн урагш орших 971,0 тоот, түүнээс зүүн хойш орших Талын хар толгой, 1105,4 тоот, Өргөстийн ус, 1342,0, 1886,0 тоотууд, Шивээт Улаан уул /2162,0/, 1824,0 тоот, Аргалын хар толгой, Балгантайн хар уул /1994,5/, 1905,0 тоот, түүнээс зүүн урагш орших 1427,0 тоот, Чандмань толгой /1784,0/, түүнээс зүүн хойш орших Хавцгайт уул, түүнээс зүүн урагш орших Юмт уул, /2076,0/, 2014,0, 1943,0, 1767,0, 1614,0, 1848,0 тоотууд, Нэвсээн хар уул /1807,0/, Эрдэнэ уул /1638,0/, Дотлуур толгой, Очирхайрхан уул /1846,0/, Гурван худаг, Цахиурт уул /1788,0/, 1661,0, 1529,0 тоотууд, Ооцон хар уул, Дөрвөлжин уул, Бор толгой /1609,0/, Сэрвэн толгой /1545,0/, Тооройт хар толгой /1387,0/, түүнээс урагш орших 1310,0 тоот, Тарганы худаг, түүнээс зүүн тийш орших Тарган уул /1162,0/, Нахиу Хар толгой /957,2/, түүнээс зүүн урагш орших 844,0, 923,0 тоотууд, Хуцны хар уул /1193,4/, 1101,0 тоот, Тавхан хар уул /1204,0/, 1141,1 тоот, Үхэр улаан уул /1376,0/, түүнээс урагш орших Талин-Овоо толгой /1166,0/, 1240,3 тоот, түүнээс зүүн

урагш орших улсын хилийн 204 дүгээр багана, түүнээс баруун тийш улсын хилээр 162 дугаар багана хүрч, түүнээс хойш орших улсын хилийн 161 дүгээр багана.

**"Б" хэсэг**

Гончиг уул /1379,0/, түүнээс хойш орших 1180,0, 1190,0 тоотууд, 1190,0 тоотоос хойш орших Эрэн толгой /1148,0/, Хоолойн хүрэн толгой /1147,0/, түүнээс зүүн хойш орших 1154,0, 1788,0 тоотууд 1788,0 тоотоос зүүн урагш орших Халзан уул, /2105,0/, Чантуу худаг, Хөндлөн уул /1978,0/, Дуут уул /2468,0/, түүнээс баруун урагш орших Улаан ташуу уул, /1913,0/, Авдарт уул /1827,0/, түүнээс урагш орших 2081,0 тоот, түүнээс баруун урагш орших Таван овоонм улаг, 2086,0 тоот, улсын хил дээрх 2357,0 тоот хүрч, баруун тийш улсын хилээр улсын хилийн 105 дугаар багана хүрч, Инхэлээгийн Бондгор уул /1787,0/, түүнээс баруун хойш орших 1641,0, 1563,0 тоотууд, Гончиг уул /1379,0/.

**2. Хөх сэрхийн нурууны дархан цаазат газрын хилийн зааг:**

Баян-Өлгий аймгийн Дэлүүн сумын нутаг дахь Дээд ямаатын хөндлөн /2890,4/, түүнээс хойш орших Хөндлөнгийн даваа, 2989,8 тоот, Мөст нуурын баруун урд эрэгт орших 2944,8 тоот, Баян-Өлгий, Ховд аймгийн хилийн заагийн Цасан даваа /3366,0/, түүнээс зүүн тийш орших Ховд аймгийн Ховд сумын нутаг дахь Хавтгай оройт уул /3776,3/, Түвшин уул түүнээс зүүн урагш орших Нугат уул /3145,6/, Мухар цагдуулт /2961,9/, Түмтийн гол, Улиастайн голын уулзвар, Улиастайн голын баруун эргийг даган Буянт, Улиастайн голын уулзвар хүрч, түүнээс урагш Буянт голыг өгсөн Буянт, Бүргэдтэй голын уулзвар, түүнээс баруун хойш орших Мухар дэвсгэг уул /3134,0/, Тойг уул /3281,0/, Тоорцог уул /3664,4/, Довцог уул /3384,0/, Ямаатын осго уул /3403,0/ түүнээс хойш орших Шар даваа, түүнээс баруун хойш орших Дэлүүний нуруу /3323,5/, Дэлүүн уул /3630,0/, Их замт уул /3510,7/, Дээд ямаатын хөндлөн /2890,4/.

**3. Богдхан уулмын дархан цаазат газрын хилийн зааг:**

Айд уул /1735,2/, түүнээс хойш орших 1624,0, 1338,0 тоотууд, 1338,0 тоотоос зүүн хойш орших Яармаг, Нисэхийн чиглэлээс Нүхэтийн ам руу салсан засмал замын уулзварын баруун урд талын 1 тоот шон, Нүхтийн засмал замыг гатлан засмал замын урд захаар Яармагийн гүүрийн зүүн урд үзүүр, түүнээс зүүн тийш Туул голын урд эргээр Банизүрхийн авто замын гүүрийн баруун урд 21 тоот шон, түүнээс зүүн урагш орших Хүрэл

гогоотын амны доод талмы төмөр замын гүүрийн баруун талмы 3 тоот шон, төмөр замын далангийн баруун талыг даган Төрхурахмы голыг гарч, төмөр замын дунд хоёр гүүрийн баруун гар талмы 6,5 тоот шон, мөн төмөр замын далангийн баруун талыг даган Ширдэгтийн богинмы амны төмөр замын гүүрийн баруун талд орших 6 тоот шон, түүнээс баруун урагш орших 1859,2, 1816,0 тоотууд, 1816,0 тоотоос баруун тийш орших 1843,0, 1813,3, 1810,0 тоотууд, 1810,0 тоотоос баруун хойш орших Номт уул /1793,0/, түүнээс баруун хойш орших 1802,0 тоот, түүнээс баруун урагш орших 7 тоот шон, түүнээс баруун хойш орших Шар хөв уул /1754,0/, Айц уул /1735,2/.

**4. Хасарт хайрхан уулны Дархан цаазат газрын хилийн зааг:**

Данхатын таг уул /3147,9/, түүнээс зүүн хойш орших Ухаа уул, түүнээс баруун хойш орших Майхан уул /3045,5/, түүнээс баруун урагш орших Сэлмэн цахир уул, түүнээс зүүн урагш орших Тарвагатын нуруунд орших 1 тоот шон, түүнээс зүүн тийш орших Их замын хөтөл, түүнээс урагш орших Дуулгын голмы эрэг дэх Цагаан хүнх, Хүнхийн голоор уруудан Шанаган гол, Хүнхийн голмы уулзвар, түүнээс зүүн урагш орших Марцын хөтөл, Согоотын нурууны овоо, Оройн цахир, Сэнжит цахир, түүнээс зүүн тийш орших Шарилмы-Овоо /2688,8/, түүнээс урагш орших Дусаал уул /3016,0/, Зост-Өндөр уул /3311,0/, түүнээс баруун урагш орших Бөхөтийн онь, түүнээс хойш орших Бөхөтийн доод гэлгөр, Елон уул, Их Булагийн орой /3280,3/, Данхатын таг уул /3147,9/.

**5. Хан Хэнтийн дархан цаазат газрын хилийн зааг:**

Гэл уул /2550,8/ түүнээс баруун урагш орших 2178,0, 2033,0, 2089,0 тоотууд, Захарын Даваа /2087,0/, 2327,0 тоот, түүнээс баруун хойш орших 2474,9, 2083,0, 2262,0 тоотууд, Хөх модны хойт сарьдаг /2464,5/, түүнээс зүүн хойш орших 1727,8, 1741,9, 1671,0, 1696,0, 1761,0 тоотууд, Хадлангийн уул /1803,7/, түүнээс зүүн хойш орших 1664,0, 1552,0 тоотууд, Өвөрматах уул /2120,5/, Арматах уул 2144,9, түүнээс хойш орших Арван толгой /2010,5/, түүнээс зүүн хойш орших 1540,2, 1842,0, 1974,1, 1746,0, 1768,0, 1847,0 тоотууд, Арцат уул /1984,6/, түүнээс зүүн хойш орших 1782,0, 1710,7, 1861,0, 2035,0, 2003,0 тоотууд, Сарьдаг /2113,3/, Хорооны даваа /1792,0/, 1893,0, 1858,0 тоотууд, Жанчвана уул /1893,5/, 1655,0, 1472,7 тоотууд, Бага хааны гол, Чихээ голмы уулзвар, Бага ханы голыг уруудаж улсын хил хүрээд зүүн тийш

хилийн дагуу Гүеэ гол хүрч, Гүеэ голын баруун эргээр уруудан Онон, Гүеэ голын уулзвар, Онон голын баруун эргээр өгсөж Онон, Зүүн тарсмын голын уулзвар, Зүүн тарсмын голын баруун эргээр өгсөж 1403,0 тоот хүрч, түүнээс урагш орших 1517,0, 1611,0, 1479,0, 1741,0 тоотууд, 1741,0 тоотоос зүүн урагш 1594,6, 1592,0 тоотууд, Хөх гозгор /1843,2/, түүнээс урагш орших 1963,0, 1908,0, 1872,0 тоотууд, 1872,0 тоотоос баруун урагш орших Баян-Өндөр /1813,1/, 1973,0, 2068,1 тоотууд, Цагаанчулуутын ян /2195,5/, Баян-Өндөрийн ян /2236,3/, түүнээс баруун тийш орших Тогоотын ян /2197,4/, түүнээс баруун хойш орших 2064,0, 1851,0 тоотууд, Хэрлэн, Илүүрийн голын уулзварт орших 1510,7 тоот, түүнээс баруун урагш Хэрлэн голын баруун талд орших 1766,2, 1651,0, 2025,0 тоотууд Эрдэнэ уул /2303,1/, 2193,2 тоот, түүнээс баруун хойш хойш орших 1938,0 тоот, Алтын судал /1991,0/, түүнээс баруун урагш орших 1903,0, 1942,0, 1843,0 тоотууд, 1843,0, тоотоос баруун урагш Далантайн голыг гаглан 1935,0 тоот, түүнээс урагш орших Салхитын-Овоо /2137,1/, түүнээс баруун урагш орших 1840,8 тоот, Тарвагатайн даваа /1919,0/, Бүрэн хаан /2323,8/, түүнээс баруун урагш орших 2132,0, 1986,1, 1931,0, 2090,2 тоотууд, Асгатын сарьдаг уул /2319,2/, түүнээс баруун хойш орших 1929,7, 1963,0 тоотууд, Мэргэн хотод даваа /1796,0/, түүнээс баруун хойш орших Гэл уул /2550,8/.

**6. Нөмрөгийн дархан цаазат газрын хилийн зааг:**

Улсын хил дээр орших Харуулын толгой /1028,0/, түүнээс зүүн урагш улсын хилийн дагуу /Соёлз уул, түүнээс баруун тийш улсын хилийн дагуу Гүн жалгын эх /1223,0/, түүнээс баруун хойш орших Унагадайн уул /1166,0/, түүнээс хойш орших Цэцэгт уул /1262,0/, Хагт уул /1154,0/, 1088,0 тоот/, түүнээс хойш Өвөрдуут голын эхээр нуруулдан 1106,0 тоот, Олон худгийн давааг дайран Түмэн уул /1066,0/, түүнээс зүүн хойш улсын хил дээр орших Харуулын толгой /1028,0/.

**7. Дорнод монголын дархан цаазат газрын хилийн зааг:**

Уртын цагаан уул /1035,0/, түүнээс хойш орших Буйласт хар толгой /920,0/, түүнээс баруун хойш орших 847,0 тоот, түүнээс зүүн хойш орших 709,0 тоот, түүнээс зүүн тийш Лагийн хар энгэр /749,0/, Оцгор /826,0/, түүнээс зүүн хойш Цагаан уулын хойт үзүүрт орших 978,0 тоот, Нохойн шовон /850,0 тоот/, Модон-Овоо /857,0/, түүнээс зүүн урагш орших 806,0 тоот, түүнээс зүүн тийш орших Яригдай /866,0/, 901,0 тоот, түүнээс зүүн

хойш орших Цагаан чулуут /979,0/, түүнээс зүүн урагш орших 1066,0 тоот Ембүү толгой /955,0/, түүнээс урагш хил дээр орших Тосонтолгой /932,0/, түүнээс баруун тийш улсын хилийн дагуу 767,0 тоот хүрч, түүнээс баруун хойш орших Норов уул /905,0/, Уртын цагаан уул /1035,0/.

**8. Монгол дагуурмын дархан цаазат газрын хилийн зааг:**

**"А" хэсэг**

Баянмөнх /857,2/, түүнээс зүүн хойш Дашбалбар, Чулуунхороот сумын хилийн заагт орших 860,5, 823,1 тоотууд, 823,1 тоотоос хойш хоёр сумын хилийн заагийн дагуу улсын хил хүрч, түүнээс зүүн тийш улсын хилээр Улз голын эрэг хүрч, түүнээс баруун урагш орших Шар бүрднуурын зүүн урд эргээр дайран Дэлгэрбулаг хүрч, түүнээс баруун хойш орших Баянхаан уул /685,6/-ын ар хормой /1 тоот шон/-гоор тойрон түүний баруун талд орших 645,2 тоот, түүнээс баруун хойш орших 646,9, 664,4 тоотууд, Дээд мукей нуурын баруун хойно орших жижиг толгой /2 тоот шон/, Давст нуурын зүүн эргээр дайран түүний баруун хойно орших жижиг /давстай/ нуурын баруун эрэг /3 тоот шон/, 699,6, 748,0 тоотоос баруун урагш орших 770,9, 800,1 тоотууд, 800,1 тоотоос урагш Үхэрт нуурын зүүн эргээр дайран 815,8 тоот, түүнээс баруун урагш орших Хайлан уул /952,7/, түүнээс баруун хойш орших 880,6, 797,3 тоотууд, Бодь нуурын баруун эрэг дэх 719,1, 798,3 тоотууд, Баянмөнх /857,2/.

**"В" хэсэг**

Ил түрүүт /767,7/, түүнээс зүүн хойш Улзын голыг гаталж 668,6, 658,1 тоотууд, 1, 2 тоот шонгуудыг дайран 687,8 тоот, түүнээс зүүн урагш орших 3 тоот шон, түүнээс зүүн хойш орших 630,3, 629,3 тоотууд, 629,3 тоотоос зүүн урагш Улз голын эрэгт орших 625,8 тоот, түүнээс урагш орших Цог-Овоо /682,3/, түүнээс баруун урагш орших 652,2, 657,7 тоотууд, 657,7 тоотоос баруун тийш Дөрөө нуурын баруун урд талд орших 657,8 тоотууд, Улз голын урд талын автомашины шороон замын хойт талд түүний дагуу орших 5-10 тоот шонгууд, Чулуунхороот, Дашбалбар, Гурванзагал сумуудын хилийн уузвар дахь 659,8 тоот, түүнээс баруун тийш орших Ил түрүүт /767,7/.

**9. Отгонтэнгэр уулын дархан цаазат газрын хилийн зааг:**

Аршааны гол, Их богд голын уулзвар дахь 2140,0 тоот, Аршааны голын зүүн эргээр өгсч Аршааны гол, Хар горхи голын уулзвар хүрч, түүнээс зүүн хойш орших Майхан толгой, түүнээс зүүн

тийш Аршаан голын урд эрэгт орших 2303,0 тоот, түүнээс түүн урагш нууруудыг хонхорыг дайрч Отгонь рашаан амралтын урдуур тойрон Жозштын амин адагт орших 1 тоот мөн, түүнээс зүүн хойш орших Аршаан гол, Ар цагаан сайрын голын уулзвар дахь 2439,0 тоот, Ар цагаан сайрын голыг өгсөн 2470,0, 2582,0 тоотуудыг дайрав Чулуутын даваа /2990,0/-, давж автомашины замаар Холбоо нуурын баруун эрэг хүрч цааш нь Чулуутын голын баруун эргээр 2439,0 тоотыг дайран уруудаж Чулуут, Мандалтын голын уулзвар дахь 2327,0 тоот, Чулуутын голын баруун эргээр Бунит, Чулуутын голын уулзвар хүрч, түүнээс баруун урагшаа Баянзүрх уулын урд үзүүр дэх 2521,0 тоот, түүнээс баруун хойш орших 2550,0 тоот, Шар даваа /2785,5/, түүнээс баруун урагш орших Мааньтын сэрвэн, түүнээс баруун хойш хойш орших Хяран нуурын урд эрэг дэх 2865,0 тоот Улаан хүрэмт /3470,0/, түүнээс баруун тийш орших Чулуутын эхний даваа /2610,0/, түүнээс баруун хойш орших Хөх нуурын дөрөлж /2525,0/, Мод толгой, түүнээс хойш орших Цагааннуурын эхний цутгалан голоор Цагааннуур хүрч, түүний зүүн эргээр нь тойрон Цагаан-нуурын босго /2236,7/, түүнээс зүүн хойш орших Самилми-Овоо /2345,0/, Аршааны гол, Их богд, голын уулзвар дахь 2140,0 тоот.

10. Увс нуурын айв савын дархан цаазат газрын хилийн зааг:  
1/Увс нуурын хэсэг

Увс нуурын баруун урд орших 773,7 тоот, түүнээс баруун хойш орших 772,5, 778,9 тоотууд Шар усны худаг, 783,5 772,6, 759,6 тоотууд, Бураат булаг /781,9/, Буцалдаг булгийн эх, Хуш духны даваа, түүнээс зүүн тийш орших 763,8 тоот, Увс нуурт цутгаж буй Жираг голын цутгалан хүрч, мөн голын баруун эргээр нь өгсөн эхийг давж Татуурын бух голтой нийлэн, түүнийг уруудаж 964,6 тоотыг дайран Торхилог гол, Татуур бухын голын уулзвар хүрч, Торхилог голын баруун эргээр өгсөн хилийн II дугаар багана, зүүн урагш улсын хилийн дагуу 1024,2 тоотод орших улсын хилийн III дүгээр багана, түүнээс урагш орших 953,1 тоот, Их бухын голын зүүн эргээр даган 895,7, 831,2, 779,6 тоот, Их бухын голын зүүн эргээр даган 895,7, 831,2, 779,6 тоотууд, 779,6 тоотоос зүүн хойш эргэн нуурын хөвөөгөөр дагаж 778,2 тоотыг дайран нуурын хойт талаар тойрон улсын хилийн 124 дүгээр багана хүрч, улсын хилээр Увс нуурт цутгаж буй Оргихын голын цутгалан дахь улсын хилийн 125 дугаар багана, Оргихын

голыг өгсөн, улсын хилийн 126, 127, 128, 129 дүгээр багана, түүнээс урагш орших 763,7 тоот, түүнээс баруун урагш Тэсийн голын хөвөөнд орших 762,9 тоот, түүнээс зүүн урагш орших 767,7 тоот, түүнээс баруун урагш орших 764,0 тоот, түүнээс зүүн урагш орших 768,7, 772,4 тоот, Багануурмын зүүн талаар гарч Нарийн голыг гатлан 769,3 тоот, түүнээс баруун урагш Хар усны голыг гатлан Гашуун нуурмын зүүн талаар тойрч 974,3 тоот хүрээд Шар нуурмын урдуур тойрон Орлогын булгийн эх, түүнээс баруун хойш орших Жаргалантын-Овоо /806,8/, түүнээс баруун урагш орших 792,3, 792,0 тоотууд, Шургуу худаг, Салхитын овоо /771,3/, Багануурмын урд хөвөөгөөр тойрон 763,2 тоот, түүнээс урагш орших 787,6 тоот, түүнээс баруун тийш орших 772,3, 766,1 тоотууд, Хэрээ хүүхэддэй /780,2/, түүнээс баруун хойш орших 773,7 тоот.

### 2/Түргэн уулын хэсэг

Ямаат уул /3354,2/, түүнээс хойш орших 2083,5, 2854,0, 3162,7, 3041,1 тоотууд, Жавартайн даваа /2763,0/, түүнээс зүүн тийш орших Халчиг уул /3009,0/, 2846,6 тоот, Бумбат уул /2623,4/, түүнээс зүүн хойш орших 2129,0 тоот, түүнээс зүүн хойш орших Атаруул /1759,0/, түүнээс зүүн хойш Хөндлөнгийн голын дэнжээр уруудан 2436,6 тоот, түүнээс зүүн тийш орших Суугийн шилийн 2543,1 тоот, түүнээс зүүн урагш Хөндлөнгийн голыг гатлан Зэстийн уул /2950,7/, 2872,2 тоот, түүнээс баруун тийш орших 2166,7 тоот, түүнээс урагш орших 2154,9 тоот, түүнээс баруун урагш орших Дэнхарваа уул /1998,8/, түүнээс зүүн урагш орших 2558,4 тоот, түүнээс урагш орших 2541,0, 2431,0 3144,0, 3120,4, 3012,2, 2984,6, 3483,5, 3126,9, 3028,0 тоотууд, 3028,0 тоотоор баруун урагш орших 3351,1, 3604,5, 2805,2 тоотууд, 2805,2 тоотоос хойш орших 3458,1, 3828,1 тоотууд, 3828,1 тоотоос зүүн тийш орших 3673,2 тоот, түүнээс хойш орших 2745,0, 2819,5, 3511,4 тоотууд, 3511,4 тоотоос баруун хойш орших Ямаатын даваа /3147,0/, 3233,3, 3195,2 тоотууд, 3195,2 тоотоос баруун тийш орших Ямаат уул /3354,2/.

### 3/Алтан-элсний хэсэг

1048,7 тоотод орших улсын хилийн 173 дугаар багана, түүнээс зүүн тийш улсын хилээр Тэсийн гол хүрч, Тэсийн голын баруун эргээр өгсөн 1195,0 тоот, түүнээс баруун урагш орших 1370,5 тоот, түүнээс урагш 2,0 км-г орших 1 тоот шон, түүнээс баруун тийш элсний урд захыг хавалан 1374,4, 1311,3, 1244,7, 1209,7, 1194,1 тоотууд, 1194,1 тоотоос хойш орших 1233,5, 1186,6, 1186,4 тоотууд

1186,4 тоотоос зүүн хойш 1048,7 тоотод орших Улсын хилийн 173 дугаар багана.

**4/Цагаан шувуутын хэсэг**

Шар хамар /3245,9/, түүнээс баруун хойш орших 2915,2, 3132,6 тоотууд, 3132,6 тоотоос баруун хойш орших Хуурай Сайгийн орой /3366,9/, улсын хилээр 3393,1 тоот хүрч, түүнээс зүүн хойш орших 3136,9 тоот, түүнээс зүүн тийш орших 3123,7, 3024,9, 2642,1 тоотууд, 2642,1 тоотоос зүүн урагш орших Ээмэг уул /3095,8/, Харгайт уул /3045,5/, түүнээс баруун урагш орших 3277,0 тоот, түүнээс зүүн урагш орших 2913,0, 2631,7, 2562,0 тоотууд, 2562,0 тоотоос урагш орших 2053,3 тоот, түүнээс баруун хойш орших 2536,7, 2491,2, 2665,0, 2576,0, 2742,0, 3106,0 тоотууд, 3106,0 тоотоос баруун урагш орших 2478,0 тоот, түүнээс баруун хойш орших 2973,3 тоот, түүнээс баруун урагш орших 2955,0 тоо 2973, тоот, түүнээс баруун урагш орших 2955,0 тоот, түүнээс баруун хойш орших Шар хамар /3245,9/

о о о

Монгол Улсын Их Хурлын  
1995 оны 26 дугаар тогтоолын  
2 дугаар хавсралт

**БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОРТ ГАЗРЫН ХИЛИЙН ЗААГ**

**1. Хорго-Тэрхийн цагаан нуурын байгалийн цогцолборт газрын хилийн зааг:**

Дархан уул /2362,5/, түүнээс баруун хойш орших Овоотын хөтөл /2147,0/, 2393,2 тоот, түүнээс хойш орших 2609,9 тоот, түүнээс зүүн хойш орших Шарилын уул /2877,1/, 2650,6, 2764,4 тоотууд, 2764,4 тоотоос зүүн тийш орших Гурван даваа /2470,7/, түүнээс зүүн урагш орших 2847,5 тоот, Хутаг уул /3130,6/, Сантын булуу /2968,0/, 2389,7, 2560,0, 2127,0 тоотууд, 2127,0 тоотоос урагш Суман голын эрэгт орших 1996,0 тоот, Суман голын хойт эргийг өгсч, Загасан тохой, түүнээс баруун урагш орших Одон уул /2703,0/, 2765,0 тоот, түүнээс баруун тийш орших Уран мандал уул /2799,6/, түүнээс баруун урагш орших Мөст уул



/2690,4/, түүнээс баруун хойш орших 2331,0, 2060,8 тоотууд, Дархан уул /2362,5/.

**2. Хөвсгөлийн байгалийн цогцолборт газрын хилийн зааг:**

Улсын хилийн 2972,4 тоот, түүнээс зүүн тийш мөн хилээр 2647,1 тоот, түүнээс урагш орших 2246,0 тоот, түүнээс баруун урагш орших Саравслаг-Овоо /2358,6/, түүнээс баруун тийш орших 2121,7; 2134,1; 2321,2 тоотууд, 2321,2 тоотоос түүнээс баруун хойш орших 2429,7 тоот, Тасмин-Өндөр /2524,4/, 2281,5; 2383,0; 2534,2 тоотууд, 2534,2 тоотоос баруун тийш орших 2327,8, 2432,9 тоотууд 2432,9 тоотууд, 2432,9 тоотоос баруун урагш Зүрхийн баруун голын баруун талд орших 2257,6 тоот, түүнээс урагш Хэвэн нуурмын зүүн талд орших 2208,0 тоот, түүнээс урагш орших 2212,1 тоот, Зуун модны нуурмын зүүн эргээр дайран Сарлагийн даваа /2072,0/, түүнээс баруун урагш орших /2052,0/ тоот, түүнээс урагш орших Хушуутын даваа /2031,0/, Далбайн эхний даваа /2025,0/, Хур модны сарьдаг нуурмын баруун талд орших 2102,0 тоот, түүнээс баруун урагш Өрхийн голын эхний хярын 2081,9, 2011,0 тоотууд, Сагтын даваа /2057,0/, Урт царамик нуурмын баруун талд орших 1918,0 тоот, Цагаан голын эхний нуурмын зүүн эргээр дайран Даваа /1858,0/, 1826,7 тоот, Нарийн даваа /1785,0/, Нарийн хилэнгийн даваа /1814,0/, түүнээс урагш нуруудан 1840,8; 1945,0; 1922,1; 1835,3 тоотууд, Хээгцэрийн голын эхний зүүн салааны хойно орших 1915,8 тоот, мөн голын эхний баруун салааны баруун урд орших 2093,0 тоот, түүнээс урагш орших Нарийн нуурмагт голын эхний даваа /1986,0/, 2141,0 тоот, Хамар даваа /2071,0/, түүнээс баруун урагш оршид Дааган давааны уул /2118,9/, түүнээс урагш орших Хурц уул /2274,0/, 2174,2 тоот, түүнээс баруун урагш орших Дааган даваа /1911,0/, Алагцармын голын эхээр Шоргоолжилтын нурууг нуруудан баруун хойш эргэж 1972,9, 2024,2, 2094,0, 2215,3, 2027,2 тоотууд, 2027,2 тоотоос баруун урагш Эгийн голын зүүн талд орших хойд хадаг хошуу, түүнээс баруун урагш Эгийн голыг гатлан Нүцгэн толгой, түүнээс баруун хойш орших 1883,0 тоот, түүнээс зүүн хойш Зүүн олхон сайрыг гаталж 1900,7 тоот, түүнээс хойш Хөвсгөл нуурмын баруун талаар нуруудан 1862,0, 1958,7, 1962,3 тоотууд, Өлөнт уул /2094,2/, Жинхайн нуруу /2291,4/, 2432,0 тоот, Хар биет уул /2515,3/, 2670,5 тоот Их уул /2960,7/, түүнээс зүүн хойш орших /2578,3/, 2569,2 тоотууд, Хөх өвс уул /2648,2/, түүнээс баруун хойш орших Баанзүрх оноо /2454,8/, түүнээс хойш орших 2686,3 тоот, Хар усны уул /2621,8/.

2534,6, 2593,4 тоотууд, Сантын уул /2379,5/, 2605,9 тоот, Жиглэг уул /2524,6/, түүнээс баруун хойш орших Жиглигийн даваа /1926,3/, Жиглигуул /2521,8/, 2275,0 тоот, Хажимын даваа /2046,4/, түүнээс баруун хойш орших Ноён уул /3020,3/, түүнээс хойш орших 2555,2 тоот, Нүцгэн-Өлийн даваа /2281,8/, Улаан тайгын нурууг нуруудан 2783,6; 2734,0; 2731,0; 2953,7; 2966,3; 2907,5; 2867,0 тоотууд, 2867,0 тоотгоос баруун хойш орших 3081,1, 3045,0, 3042,0, 3035,5 тоотууд, 3035,5 тоотгоос зүүн хойш орших 2909,0; 3026,8; 3124,3 тоотууд, 3124,3 тоотгоос баруун хойш орших Лам-бистэг уул /3130,2/, түүнээс хойш орших 3097,5; 2561,0 тоотууд, 2561,0 тоотгоос баруун хойш орших 2542,5, 2767,4 тоотууд, 2767,4 тоотгоос хойш орших Жарын даваа /2445,0/ түүнээс баруун хойш орших 2706,0; 2745,0 тоотууд Уртрагийн даваа /2344,0/, Цулын хойт уул /2872,0/, түүнээс хойш орших 3044,0; 2975,0 тоотууд, 2975,0 тоотгоос зүүн хойш орших 3107,3 тоот, удсын хилийн 2972,4 тоот.

**3.Горхи-Тэрэлжийн байгалийн нэгцлөлт газрын хилийн зааг:**

Хан Хэнтийн дархан цаазтай газрын хилийн 2474,9 тоот, түүнээс зүүн урагш орших 2327,0 тоот, түүнээс баруун хойш орших Захарын даваа /2087,0/, 2089,0 тоот, түүнээс баруун тийш орших 2033,0; 2178,0 тоотууд, 2178,0 тоотгоос баруун хойш орших Гэл уул /2550,8/, түүнээс зүүн урагш орших Мэргэн хөтөл даваа /1796,0/, 1963,0; 1929,7 тоотууд Асгатын сарьдаг уул /2319,2/, түүнээс баруун хойш орших 2090,2 тоот, түүнээс баруун тийш орших 1931,0; 1986,1 тоотууд, мөн дархан газрын хилээс салж 1986,1 тоотгоос зүүн урагш орших Юүдэгийн даваа /1985,0/, түүнээс баруун урагш Өвөр жүдэгийг нуруудан 2086,0 тоот, Эрдэнэцогт овоо /2083,0/, Галттайн даваа, 1810 тоот, Дэлгэрийн даваа /1896,0/, түүнээс урагш орших Бугатын даваа /1931,0/, Булан хаан /2259,0/, 2235,0 тоот, түүнээс баруун урагш орших 2156,9 тоот, Сант уул, Замтын даваа /1887,1/, Эрдэнэ уул /2071,5/, түүнээс баруун хойш орших Эрдэнэ уулын даваа /1875,1/, түүнээс баруун урагш орших Сэрүүн булгийн даваа /1799,0/, Хөндлөн булгийн даваа /1748,0/, 1794,0 тоот, Жимгэрийн даваа /1664,0/, 1727,3 тоот, Морин даваа /1644,0/, Хэцийн даваа, амралтын дээд талд Туул голын урд эргээр уруудаж Горхийн доод гүүр хүрч, түүнээс хойш орших, Өндөр уул /1983,7/, 2011,0 тоот, Номт уул /2096,0/, түүнээс зүүн хойш орших Дүнхэн уул /2120,2/, Оргих уул /2197,0/, түүнээс

баруун хойш орших 1962,6 тоот, түүнээс хойш орших Шилжирэнгийн даваа /1842,0/, түүнээс баруун хойш орших Бугатын даваа /1976,0/, Елтын даваа /2001,0/, Хоёр даваа /2045,0/, Даваатын даваа /1899,0/, Бэрхдаваа /2034,0/, Шаравтын даваа /2068,0/, 2082,0; 2076,0 тоотууд, 2076,0 тоотоос баруун хойш орших Улаанхаргайн даваа /1948,0/, Дарьхитын даваа /1947,0/, 2045,3 тоот, түүнээс зүүн хойш орших Адгийн даваа /1854,0/, түүнээс баруун хойш орших 1997,0 тоот, түүнээс зүүн хойш орших Хургын даваа /1842,0/, 2145,0 тоот, Алагийн эх /2412,0/, 2474,9 тоот.

4. Говь гурван сайханы байгалийн цогцолборт газрын хилийн зааг:

Ар цал уул /1825,0/, түүнээс баруун хойш орших 1890,0; 2183,0 тоотууд, Агзан уул /2596,0/, 1870,0 тоот, Улаантолгойн худаг, түүнээс баруун тийш орших Баруун ус, түүнээс урагш орших Их Цагаан дэрсний худаг, түүнээс зүүн урагш орших 1643,0 тоот, түүнээс баруун урагш орших 1887 тоот түүнээс баруун хойш орших 2102 тоот, түүнээс баруун урагш орших Үйзэн худаг, түүнээс баруун хойш орших Хөтөлбулаг, түүнээс баруун урагш орших Шанэ-Ус 1418,0 тоот, Хайрхан толгой /1559,0/, түүнээс баруун хойш орших Хоолойн худаг, 1412,9 тоот, түүнээс баруун тийш орших 1364,2 тоот, Сүүд худаг, түүнээс баруун урагш орших 1351,0; 1379,0 тоотууд, Зангат уул /1849,0/, 1980,0 тоот түүнээс баруун хойш эргэж 1836,0, 1645,0 тоотууд, Хөх уул /1894,0/, түүнээс баруун хойш орших Хавцгайн булаг, 972,0 тоот, түүнээс урагш орших 1301,0, 1482,0 тоотууд түүнээс баруун тийш орших 1089,0, 1001,0 тоотууд 1001,0 тоотоос баруун тийш Өмнөговь, Баянхонгор аймгийн хилийн зааг хүрч, хойш эргэн уг хилийг даган Өмнөговь, Баянхонгор, Өвөрхангай аймгийн хилийн уулзвар тэндээс Өвөрхангайн, Өмнөговь аймгийн хилийг дагаж Халзанхангайн уул /1482,0/ түүнээс зүүн урагш орших 1401,0; 1519,0; 1952,0; 1592,0 тоотуудыг дайран Булагтай уул /1591,0/ Улаан эргийн худаг, Цагаантолгойн худаг, түүнээс зүүн урагш орших Өлзийтолгой, Жаргалантын булаг /2018,0/ түүнээс зүүн тийш орших Сүүжийн худаг, түүнээс зүүн урагш орших Нэргүй булгийн эх, Үнэгт /1863,0/ түүнээс баруун урагш орших Ар цал уул /1826,0/.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТОГТООЛ

1995 оны 5 дугаар  
сарын 11-ний өдөр

Дугаар 27

Улаанбаатар  
хот

Н.Өлзийхутагийг үүрэгт  
ажлаас нь чөлөөлөх тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Надмидын Өлзийхутагийг Монгол Улсын Шинжлэх ухаан, боловсролын сайдын үүрэгт ажлаас чөлөөдсүгэй.
2. Энэ тогтоолыг батлагдсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдөхөөр тогтоосугай.

Дарга

Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТОГТООЛ

1995 оны 5 дугаар  
сарын 12-ны өдөр

Дугаар 28

Улаанбаатар  
хот

Санжбэгзийн Төмөр-Очирыг  
Шинжлэх Ухаан, Боловсролын  
сайдаар томилж тухай

Монгол Улсын Их Хурлаас  
ТОГТООХ нь:

1. Санжбэгзийн Төмөр-Очирыг Монгол Улсын Шинжлэх ухаан, боловсролын сайдаар томилсугай.
2. Энэ тогтоолыг батлагдсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдөхөөр тогтоосугай.

Дарга

Н.БАГАБАНДИ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН  
ЗАРЛИГ**

1995 оны 3 дугаар  
сарын 28-ны өдөр

Дугаар 59

Улаанбаатар  
хот

**Мехико Фужимотог "Найрамдал"  
медалиар шагнах тухай**

Монголын эмэгтэйчүүдийн соёл-ахуйн нөхцлийг сайжруулахад дэмжлэг тусалцаа үзүүлэх ажлыг санаачлан зохион байгуулж Монгол, Японы ард түмний найрамдалт харилцааг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Япон-Монголын эмэгтэйчүүдийн соёлын харилцааны "Солонго" нийгэмлэгийн тэргүүн Мехико Фужимотог Монгол Улсын "Найрамдал" медалиар шагна-сугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ**

**П.ОЧИРБАТ**

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН  
ЗАРЛИГ**

1995 оны 4 дүгээр  
сарын 18-ны өдөр

Дугаар 62

Улаанбаатар  
хот

**Намсрайн Төмөртогтоод Монгол Улсын  
Хөдөлмөрийн баатар цол олгох тухай**

Иргэний агаарын тээврийн салбарт үр бүтээлтэй ажиллаж манай оронд ашиглагдаж байгаа төрөл бүрийн агаарын хөлгүүдийг богино хугацаанд чадамгай эзэмшин багш-нисгэгч, багийн даргаар олон мянган цаг ямар нэгэн зөрчил дутагдалгүй нисч, ТУ-154, ВОИНГ-727 онгоцны анхны бие давсан нислэгүүдийг амжилттай хийж олон улсын агаарын шинэ зам нээж, өндөр мэргэшлийн нис-

гэгч нарыг бэлтгэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж "МИАТ" компанийн БОИНГ-727 онгоцны багш-нисгэгч, багийн дарга Намсрайн Төмөртогоод Монгол Улсын Хөдөлмөрийн баатар цол олгож, Сүхбаатарын одон, "Алтан соёмбо" тэмдэгээр шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

П.ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН  
ЗАРЛИГ

1995 оны 4 дүгээр  
сарын 18-ны өдөр

Дугаар 63

Улаанбаатар  
хот

Ринчингийн Батнасанд Монгол  
Улсын гавьяат нисгэгч цол  
олгох тухай

АН-24, ТУ-154, БОИНГ-727 онгоцны нисгэгчээр олон мянган цаг нисч, өөрийн оронд болон гадаад орнуудад зорчих тусгай үүрэгт нислэгүүдийг амжилттай гүйцэтгэн дадлага туршлагатай нисэх багийн бүрэлдүүнийг сургаж бэлтгэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж "МИАТ" компанийн БОИНГ-727 онгоцны багш-нисгэгч, багийн дарга Ринчингийн Батнасанд Монгол Улсын гавьяат нисгэгч цол олгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

П.ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН  
ЗАРЛИГ

1995 оны 4 дүгээр  
сарын 18-ны өдөр

Дугаар 64

Улаанбаатар  
хот

Иргэний агаарын тээврийн зарим  
ажилтныг одон, медалнар шагнах тухай

Иргэний агаарын тээврийн байгууллагад үр бүтээлтэй ажиллаж айгаа дөр дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

### Сүхбаатарын одонгоор

Лхагвасүрэнгийн Лхагва  
Иргэний агаарын тээврийг  
удирдах газрын ерөнхий  
захирал

Иргэний агаарын тээврийн салбарт үр бүтээлтэй ажиллаж, тус салбарын бүтэц зохион байгуулалтыг зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд нийцүүлэн боловсронгуй болгох, өндөр мэргэшлийн боловсон хүчинээр бэхжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж

### Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор

1. Сэнгэ-Очирын Лоосов  
"МИАТ" компанийн тээвэр тусгай үйлчилгээний авто баазын жолооч

Тусгай зориулалтын төхөөрөмж бүхий автомашиныг чадамгай эзэмшиж онгоцны шатахуун тээвэрлэх ажилд олон жил идэвх зүтгэл гарган ажиллаж байгааг нь үнэлж

2. Пүрэвжавын Хоролдорж  
"МИАТ" компанийн ОХУ-ын Эрхүү хот дахь төлөөлөгч

Агаарын хөлгийн засвар, техникийн үйлчилгээний ажилд дэвшилтэт арга хэлбэр нэвтрүүлэх, Буянт-ухаагийн ицсэх онгоцны буудлын шинэ барилгыг баруулж ашиглалтанд оруулах, үйлчилгээний ажлыг хэвийн явуулахад оруулсан хувь нэмрийг нь үнэлж

3. Дотейн Даштуан  
Иргэний агаарын тээврийг удирдах газрын Нислэг техникийн улсын байцаан

Иргэний агаарын тээвэрт сүүлийн 30 жилдаашигласан бүх төрлийн хөнгөн, дунд онго-цоор амжилттай нисч дадлага,

шалгах газрын ахлах  
байцаагч, багш-нисгэгч

4. Жамбалдоржийн Наран  
"МИАТ" компанийн АН-24  
онгоцны багш-нисгэгч,  
багийн дарга

5. Бэгзсүрэнгийн Бямбаахүү  
"МИАТ" компанийн АН-24  
онгоцны багш-нисгэгч,  
багийн дарга

6. Манжийн Дагва  
Иргэний агаарын тээв-  
рийг удирдах ерөнхий  
газрын тэргүүн дэд захирал

туршлагатай зохион байгуулах  
авьяастай багш-нисгэгч болж,  
залуу нисгэгчдийг бэлтгэхэд  
оруулсан хувь нэмрийг нь үнэлж

Агаарын тээврийн АН-2, АН-  
24, АН-26 онгоцуудыг чадмаг  
эээмшин багш-нисгэгч болж  
дотоодын нислэгт олон арван  
шинэ зам, аэродромыг нээж хөл-  
гөн, дунд онгоцоор тогтвортой  
амжилт гарган нисч залуу нис-  
гэгч нарыг сургаж дадлагажуу-  
лахад оруулж байгаа хувь нэм-  
рийг нь үнэлж

АН-2 онгоцоор хөдөө аж ахуйн  
хортон шавьж, мэргэгчидтэй  
тэмцэн хорцацах хүнд нислэгт 13  
жил амжилттай нисч, иргэний  
тээврийн дунд онгоцны нисэх ба-  
гийн дарга, багш-нисгэгчээр тас-  
ралтгүй 20 гаруй жил үр бүтээл-  
тэй, үйлчилгээний гологдолгүй  
ажиллаж байгааг нь үнэлж

"Агаарын зайд нислэг үйлдэх  
тухай" Монгол Улсын хуулийн  
төслийг боловсруулах, зах зээ-  
лийн нөхцөлд нийцүүлэн иргэ-  
ний агаарын тээврийн бүтэц, зо-  
хион байгуулалтыг боловсрон-  
гуй болгох, гадсад харилцаа,  
санхүү эдийн засгийн оновчтой  
бодлого боловсруулж, олон ул-  
сын зээл тусламжийг үр бүтээл-  
тэй ашиглах талаар санаачил-  
гатай ажиллаж байгааг нь үнэлж



### Алтан гадас одонгоор

1. Авирмэдийн Нацаг  
Нислэг техникийн улсын  
байцаан шалгах газрын  
байцаагч-нисгэгч

2. Чадраабалын Сайнбаяр  
"МИАТ" компанийн МИ-8  
нисдэг тэрэгний нисэх  
багийн дарга

3. Пүрэвдоржийн Бадрах  
"МИАТ" компанийн МИ-8  
нисдэг тэрэгний нисэх  
багийн механик

4. Дашбалбарын Нагмид  
Дорнодаймгийн нисэх  
онгоцны буудлын  
холбооны инженер

Агаарын хөлгийн засвар, техникийн үйлчилгээний ажлыг богино хугацаанд чанартай хийдэг дэвшилтэт арга хэлбэрийг нэвтрүүлж ТУ-154, БОИНГ-727 онгоцны нисэх багийн инженерээр үр бүтээлтэй ажиллаж байгааг нь үнэлж

АН-2, МИ-8 онгоцуудыг чадварлаг эзэмшин багийн даргаар олон жил нислэгийн зөрчилгүй ажиллан цаг үеийн шуурхай ажил болон байгалийн бэрхшээлтэй хүнд нөхцөлд тусгай үүргийн нислэгт 5000 гаруй цаг нисч үүрэг даалгаврыг амжилттай биелүүлж үр бүтээлтэй ажиллаж байгааг нь үнэлж

Онгоц, нисдэг тэрэгний бүх төрлийн үйлчилгээг бие даан чанартай хийж техникийн аюулгүй ажиллагааг ханган нисдэг тэрэгний механикч-багшаар үр бүтээлтэй ажиллаж байгааг нь үнэлж

Агаарын хөлөг буулгаж хөөргөх газрын холбоо, удирдлагын тоног тохооромжийн ажиллагааны бэлэн байдлыг нэг төвөөс хянах, гэмтлийг илрүүлэх аппарат, нислэгийн удирдагчийн аж бүрэн самбар зэрэг 10 гаруй шинэ санхүүжилт гарган үйлдвэрлэлд нэвтрүүлж онгоцны буудлын техникийн бэлэн байдлыг тогтмол найдвартай хангахад идэвх зүтгэл

5. Тожилийн Ойдов  
"МИАТ" компанийн тээвэр  
тусгай үйлчилгээний  
авто баян жолооч

6. Нямсүрэнгийн  
Должинсүрэн  
Нислэг хөдөлгөөнийг  
удирдах үндэсний төвийн  
операторчин

7. Дагдангийн Галбадрах  
Иргэний агаарын тээврийг  
удирдах газрын нисэх  
онгоцны төв буудлын  
авто баян жолооч

8. Доржийн Дугаржав  
"МИАТ" компанийн АН-24  
онгоцны багш-нисгэгч,  
багийн дарга

гарган үр бүтээлтэй ажиллаж  
байгааг нь үнэлж

Агаарын тээврийн шата-  
хууныг технологийн горимын  
дагуу орон нутагт тээвэрлэх  
ажлыг олон жил гүйцэтгэж  
сэлбэг шатахуунаас тогтмол  
хэмнэлт гарган үр бүтээлтэй  
ажиллаж байгааг нь үнэлж

Иргэний агаарын тээврийн  
байгууллагын газрын холбоонд  
олон жил үр бүтээлтэй ажиллаж  
Агаарын хөлгийн нислэгэд  
швардлагатай бүх төрлийн  
мэдээллийг цагт нь шуурхай дам-  
жуулж үйлчилгээний гологдол-  
гүй идэвх санаачлагатай  
ажиллаж байгааг нь үнэлж

Тусгай тоноглолтой авто-  
машиньг чадамгай эзэмшин  
агаарын хөлгийн бууж хоерох  
зурвасыг цэвэрлэх ажилд байнга  
бэлэн байж, ажил үйлчилгээг  
хугацаанд нь чанартай  
гүйцэтгэж, нислэгийг цагийн  
хуваарийн дагуу явуулахад  
оруулж байгаа хувь нэмрийг нь  
үнэлж

АН-2, АН-24, АН-26 маягийн  
онгоцуудаар олон жил  
үйлчилгээний гологдолгүй нисч  
нислэгийн дэвшилтэт арга  
чадварыг эзэмшин залуу ни-  
сэгчдийг сургаж дадлагажуу-  
лах, нислэгийг үр ашигтай зо-  
хион байгуулахад оруулж бай-  
гаа хувь нэмрийг үнэлж

9. Хуваахүүгийн Александр  
"МИАТ" компанийн хянан  
нисгэгч-инженер

Нисгэгч болон хянан нисгэгчдийн нислэгийн маршрутын тооцооны шалгалтыг тогтмолжуулах нисэх чиглэлийн цаг агаарт дүгнэлт хийж тооцоог үнэн зөв хийснээр дотоод, гадаадад агаарын тээврийн шинэ зам нээх олон улсын аялалын нислэг хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад идэвх зүтгэл гаргаж ажиллаж, залуу хянан нисгэгчдийг бэлтгэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж

10. Гончигийн Ганбаатар  
Нислэг хөдөлгөөн удирдах  
үндэсний төвийн нислэгийн  
ахлах удирдагч

Олон улсын болон орон нутгийн онгоцны нислэг хөдөлгөөнийг газраас удирдах ажилд олон жил үр бүтээлтэй ажиллаж, залуучуудад нислэгийн удирдагчийн мэргэжил, дадлага олгоход оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж

11. Баатарын Хүрэлсүх  
"МИАТ" компанийн Агаарын  
хөдгийн засвар үйлчилгээний  
газрын онгоцны техникч

Онгоцны техникийн үйлчилгээний бүх төрлийн ажлыг чадварлаг гүйцэтгэхийн зэрэгцээ АН-24 онгоцны дугуйны диск хэмнэх туршлага нэвтрүүлж дугуй задалж угсрах ажлыг механик аргад шилжүүлэх санаачилга гаргаж, нэвтрүүлж үр бүтээлтэй хөдөлмөрлөж байгааг нь үнэлж

#### Хөдөлмөрийн хүндэт медалиар

1. Пүрэвжавын Цэрэнпил  
Иргэний агаарын тээврийн  
удирдах газрын нислэг  
техникийн улсын шалган

Агаарын тээврийн санхүү бүртгэлийн ажлыг эмх цэгцтэй болгон өмч хөрөнгийн эзэмшилт, зарцуулалтад бүртгэ-

байцаах газрын санхүүгийн  
вхлах байцаагч

2. Ишийн Очиржав  
Сүхбаатар аймгийн нисэх  
онгоцны буудлын сумлагч  
машины жолооч

3. Дашдондогийн Дарьхүү  
Нислэг хөдөлгөөн  
удирдах үндэсний  
төвийн нислэгийн удирдагч

4. Гүржавын Эрдэнэбилэг  
"МИАТ" компанийн агаарын  
хөлгийн засвар үйлчил-  
гээний газрын онгоцны  
техникч

5. Найдангийн Гангаа  
"МИАТ" компанийн санхүү  
бүртгэлийн хэлтсийн  
эдийн засагч

лээртаних хиналтыг сайжруулах,  
тов хөдөөгийн байгуулла-  
гуудын санхүүгийн баримтын  
шалгалтыг чанартай хийж үр  
бүтээлтэй ажиллаж байгааг нь  
үнэлж

Онгоцны шатахуун сумлах  
тусгай тоноглолтой авто-  
машиныг их засваргүйгээр 10  
гаруй жил эзэмшиж, шатахуун  
хадгалах, зөөж цэнэглэх тех-  
нологийн горимыг цаг ямагт  
хэрэгжүүлж үйлчилгээний го-  
логдол зөрчилгүй олон жил үр  
бүтээлтэй ажилласныг нь үнэлж

Агаарын хөлгийн нислэгийг  
ажуул осолгүй шуурхай удирдах  
дэвшилттэй арга хэлбэрийг  
ажилдаа нэвтрүүлж 2600 гаруй  
нислэгийг хөдөлгөөний зөрчил-  
гүй удирдан идэвх зүтгэлтэй  
ажиллаж байгааг нь үнэлж

Онгоцны техникийн үйлчил-  
гээний чанарыг дээшлүүлж хө-  
дөлмөр хөнгөвчлөх дэвшилттэй  
санаачилга гарган нэвтрүүлж  
богино хугацаанд Ю-12 онгоцонд  
шилжин суралцаж мэргэжлийн  
чадвараа ахиулж үр бүтээлтэй  
ажиллаж байгааг нь үнэлж

Санхүүгийн тайлан тэнцэлд  
тогтмол дүн шинжилгээ хийн,  
хэтийн чиглэл, үр ашгийг үндэс-  
лэл сайтай тооцож ажилласнаар  
сүүлийн жилүүдэд санхүүгийн  
үр ашиг дээшлэхэд оруулж  
байгаа хувь нэмрийг нь үнэлж

6. Балдангийн Сандуйжав  
Иргэний агаарын тээврийг  
удирдах газрын санхүү  
тооцооны хэлтсийн ахлах  
мэргэжилтэн

7. Батбаярын Ядамжав  
Нислэг хөдөлгөөн удирдах  
үндэсний төвийн инженер

8. Дэмбэрэлсүрэнгийн Гантөмөр  
"МИАТ" компанийн авто  
баазын дарга

9. Лхасрангийн Цоодол  
"МИАТ" компанийн  
техникчийн захирал

Агаарын тээврийн санхүү-  
гийн албанд олон жил үр  
бүтээлтэй ажиллан төв,  
хөдөөгийн байгууллагуудад  
санхүүгийн анхан шатны  
бүртгэл бүрэн нэвтрүүлж  
санхүү бүртгэлийн хууль  
дүрмийг хэрэгжүүлэхэд идэвх  
зүтгэл гарган ажиллаж байгааг  
нь үнэлж

Газрын холбооны бүх төр-  
лийн тоног төхөөрөмжид засвар  
үйлчилгээг чанартай хийж,  
нислэгийг осол зөрчилгүй  
явуулах дэвшилтэт аргуудыг  
нэвтрүүлэн санаачлагатай  
ажиллаж байгааг нь үнэлж

Агаарын тээврийн тээвэр,  
тусгай үйлчилгээний авто баа-  
зад засварчиаас баазын дарга  
хүртэл идэвх санаачилгатай  
ажиллан хамт олныг сайн зо-  
хион байгуулж, нислэг үйлчил-  
гээний тусгай зориулалттай  
автомашин, механизмын бэлэн  
байдлыг хангахад оруулж буй  
хувь нэмрийг нь үнэлж

Агаарын хөлгийн техникийн  
үйлчилгээг графикийн дагуу  
чанартай хийж техникийн бэ-  
лэн байдлыг хангахад идэвх  
зүтгэл гарган ажиллаж, онгоц,  
техникчийг шинэчлэх, иргэний  
агаарын тээврийн үйлчилгээг  
өргөжүүлэх асуудлыг болов-  
сруулж хэрэгжүүлэхэд оруулж  
байгаа хувь нэмрийг нь үнэлж

10.Хөшөөтийн Эвсанаа  
"МИАТ" компанийн БОИНГ-727  
онгоцны нисэх багийн  
хянан нисгэгч

Орон нутгийн болон олон ул-  
сын нислэгийн агаарын замыг  
эдийн засгийн үр ашигтай хэл-  
бэрээр сонгож тогтоох, тооцоо  
судалгааг үнэн зөв шуурхай  
хийж нислэгийн аюулгүй байд-  
лыг хангахад оруулж байгаа  
хувь нэмрийг нь үнэлж

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

П.ОЧИРБАТ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН  
ЗАРЛИГ**

1995 оны 4 дүгээр  
сарын 18-ны өдөр

Дугаар 65

Улаанбаатар  
хот

Цэргийн нисэх хүчний зарим хүнийг  
одон, медалиар шагнах тухай

Цэргийн нисэх хүчинд үр бүтээлтэй ажиллаж байлдваны бэлэн  
байдал, нисэхийн техникийн аюулгүй байдлыг хангахад оруулж  
байгаа хувь нэмрийг нь үнэлж Зэвсэгт хүчний 109,137 дугаар  
ангийн дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

**Цэргийн гавьяаны улаан тугийн одонгоор**

Вандийн Санжид  
Зэвсэгт хүчний 137  
дугаар ангийн захи-  
рагчийн ар талын  
орлогч, дэд хурандаа

-Цэргийн нисэх хүчний  
албанд олон жил үр бүтээлтэй  
ажиллаж туслах аж ахуйг хөг-  
жүүлэх, талх савангийн цех  
шинээр байгуулж ажиллуулах,  
байгалийн баялагийг зүй  
зохистой ашиглах зэргээр  
ангийн бие бүрэлдэхүүний ар  
талын хангалтыг сайн зохион  
байгуулж, жил бүр олон мянган

төгрөгийн ашигтай ажилласан болон төсөв хэмнэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж

### Цэргийн гавьяаны одонгоор

Чойндонгийн Нэргүй  
Зэвсэгт хүчний 109  
дүгээр ангийн нисдэг  
тэрэгний техникч, ахмад

-Онгоц, нисдэг тэрэгний байлдааны бэлэн байдал, нислэгийн аюулгүй байдлыг хангах, хэд хэдэн оновчтой санал гарган хөдөлмөр хөнгөвчлөх, ангидаа олон мянган төгрөгийн ашиг оруулахад болон ангийн жил бүрийн өвлийн бэлтгэл хангахад мужаан, сантехникч, гагнуурчнаар ажиллаж тодорхой хувь нэмэр оруулсныг нь үнэлж

### Цэргийн хүндэт медалиар:

1. Гончигсүрэнгийн  
Сундуйсүрэн  
Зэвсэгт хүчний 137 дугаар  
ангийн авто техникийн  
албаны дарга, хошууч

-Тусгай тоноглолын авто техникийн иж бүрдэл, ашиглалт, засвар үйлчилгээнд тавих хинаалтыг тогтмолжуулан автотехникийн бэлэн байдлын коэффициентийг жил бүр ахиулан 0,98-д хүргэж нислэгийн бэлтгэл хангах, үйлчлэх үүргээ амжилттай биелүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж

2. Чойжилсүрэнгийн  
Тогоондорж  
Зэвсэгт  
хүчний 137 дугаар  
ангийн пуужин бэлтгэх  
бүлгийн дарга, ахмад

-Сургууль, байлдааны үүрэг гүйцэтгэх нөхцөлийг бүрэн хангах, онгоцыг байлдааны галт хэрэгслээр цэнэглэх, зүүх нормативт хугацааг богиносгоход болон хэд хэдэн удаагийн

хээрийн сургуулийг амжилтай явуулахад оруулсан хувь нэмрийг н үнэлж

З.Даваагийн Гансүх  
Зэвсэгт хүчний 109 дүгээр  
ангийн МИ-8 нисдэг  
тэрэгний багийн захирагч,  
хошууч

-Ангийн байлдааны бэлэн байдлыг хангахад болон гал, усны аюулав хүний амь аврах, нийгмийн өм хөрөнгийг хамгаалах, ард иргэдэд үйлчлэх, шүхэрчид десантчдыг агаараас буулгах зэргээр онцгой тусгай үүргийн нислэгийг ца хугацаанд нь чанартай гүйцэтгэхэд оруулж байгаа хувь нэмрийг н үнэлж

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

ПОЧИРБАТ

**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН  
ХУУЛИЙН ЦЭЦИЙН  
ТОГТООЛ**

Улаанбаатар  
хот

1995 оны 5 дугаар  
сарын 10-ны өдөр

Дугаар 01

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн нэг дэх хэсгийн зарим заалт Үндсэн хууль зөрчсөн тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн бүх гишүүдийн хуралдааныг Цэцийн дарга Г.Совд даргалж гишүүн Г.Нямдоо, Л.Баасан, Ц.Цолмон, С.Жанцан, Ж.Бямбаа, Ч Энхбаатар нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн даргаар Б.Цэндээхүүг оролцуулан хийн.

Цэцийн хуралдаанаар Нийслэлийн Башиг дүүргийн иргэн Д.Ламжавын гомдлоор үүссэн, Цэцийн тухай хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчиж байгаа эсэх тухай маргааныг эцэслэн хэлэлцэв.

Цэцийн хуралдаанд өргөдөл гаргагч иргэн Д.Ламжав оролцон, Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Д.Дашцэдэн гадаадад



албан томилолтоор ажиллаж байгаа бөгөөд Улсын Их Хурлаас итгэмжлэгдсэн төлөөлөгч нөхөн томилоогүй тул Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчийн оролцоогүйгээр маргааныг эцэслэн шийдвэрлэхээр Цэцийн бүх гишүүдийн хуралдаанаас аман магадлал гаргаа.

Иргэн Д.Ламжав Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцэд гаргасан өргөдөл:

1. Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх заалт, мөн хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчжээ. Цэцийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн заалтын үйлчилгээг хавсан байна гэж дурджээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн 1995 оны 1 дүгээр сарын 18-ны хуралдаанаас:

1. Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчсөн байна.

2. Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчөөгүй байна гэсэн 02 тоот дүгнэлт гаргасан байна.

Үндсэн хуулийн Цэцийн энэхүү дүгэлтийг авч хэлэлцээд Улсын Их Хурлын 1995 оны 3 дугаар сарын 13-ны өдөр гаргасан 20 дугаар тогтоолд Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчиж байна гэж үзсэн Үндсэн хуулийн Цэцийн дүгнэлтийг хууль зүйн үндэслэлгүй гэж үзэхээр шийдвэрлэжээ.

Мөн тогтоолд Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн 1995 оны 02 тоот дүгнэлтийн 2 дахь заалт буюу Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь заалт Монгол Улсын Үндсэн хууль зөрчөөгүй гэсэн хэсгийг хэрхэн шийдвэрлэсэн талаар тодорхой заалт байхгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн бүх гишүүдийн хуралдаанд оролцож иргэн Д.Ламжав тайлбарлахдаа:

Улсын Их Хурлын хуралдаанаар Цэцийн дүгнэлтийг авч хэлэлцсэн байдлаас үзэхэд Улсын Их Хурал Үндсэн хуулийн Цэцийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх заалтыг дарвах байдлаар тайлбарлаж байгаа нь нотлогдож байна:

1. 9 дүгээр зүйлийн 1 дэх заалт нь Үндсэн хууль зөрчсөн тухай маргаануудаас Цэцийн харьяалалд хамаарах хэсгийг тогтоож өгч байгаа юм.

2. Иймээс Улсын Их Хурлын шийдвэр Үндсэн хууль зөрчсөн тухай иргэнээс Цэцэд ирүүлсэн өргөдөл, мэдээллийг Цэц харьяаллын дагуу шүүх зэрэг байгууллагад шилжүүлэх ёстой.

3. Цэц бол Үндсэн хуулийн шүүх бийш зөвлөх шинжтэй байгууллага юм.

Үндсэн хуулийн Цэц нь үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 2,3,4 дэх заалтад үл хамаарах Үндсэн хууль зөрчсөн асуудлаар Улсын Их Хуралтай нэг удаа зөвшилцөх боловч эцсийн шийдвэр гаргах эрхээ хадгална гэсэн агуулгатай Үндсэн хуулийн заалтаас зөвлөлд бийш, шүүхэд илүү ойр тогтолцоо болох нь харагдаж байгаа бөгөөд Үндсэн хууль зөрчсөн тухай асуудлаар Цэцэд хандах эрх бүхий субъектуудын хувьд цорын ганц ялгааг Үндсэн хуулиар тогтоосон юм. Энэ нь Цэц иргэнээс ирүүлсэн өргөдөл, мэдээллийг өөрийн санаачилгаар, бусад субъектээс ирүүлсэн хүсэлтийг заавал хэлэлцэж шийдвэрлэх ёстой гэж Үндсэн хуульд зааснаар давхар нотлогдож байгаа билээ. Гэтэл Цэцийн тухай хуульд Үндсэн хуулийн энэ тодорхой заалтыг иргэний эрхийг хохируулах замаар шийдсэн нь Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 1 дэх заалт төдийгүй, мөн хуулийн 19 дүгээр зүйлийн 2-ыг давхар зөрчихөд хүрнэ.

Цэцийн дүгнэлтэнд Үндсэн хуулийн Цэцийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь заалт Үндсэн хуулийг зөрчөөгүй гэж үзэн миний нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон. Цэцийн бүх гишүүдийн хуралдааны тухай 1995 оны 5 дугаар сарын 2-нд "Ардын эрх" сонинд нийтлэгдсэн зарлалаас үзэхэд миний Цэцэд хандаж тавьсан гомдлыг бүхэлд нь хянах агуулга харагдаж байна. Иймд:

1. Аль ч тохиолдолд нэхэмжлэгч, хариуцагч тодорхой байх ёстой бөгөөд Цэц тэдгээрийн хооронд шүүхийн байр сууринаас хандах ёстой.

2. Цэцийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2-т заасан эдгээр заалт нь Улсын Их Хурал өөрөө нэхэмжлэгч байх зэвхэн тэр тохиолдолд тохирч байгаа юм. Өөрөөр хэлбэл нэхэмжлэгч, хариуцагч нь тодорхой болсон Үндсэн хуулийн маргааныг шийдэж өгөх хүсэлтийг зарим тохиолдолд гаргах тухай урьдчилан хуулиар тохирч болох юм.

Ялангуяа Улсын Их Хурал дахь нам бүлэг буюу тодорхой тоон гишүүдэд Улсын Их Хурлын хүсэлтээр Үндсэн хуулийн Цэцэд

хандах эрх олгох нь илүү зохимжтой байх болно гэжээ. Энэхүү тайлбарыг бичгээр үйлдэн ирүүлсэн байна.

**ХЯНАВАЛ:**

Үндсэн хуулийн Цэцийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн нэгд буй "иргэд энэ хуулийн 8 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан албан тушаалтан Үндсэн хуулийг зөрчсөн тухай асуудлаар Цэцэд өргөдөл, мэдээлэл ирүүлнэ" гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 1-д буй "Үндсэн хуулийн Цэц нь Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргааныг иргэдийн өргөдөл, мэдээллийн дагуу өөрийн санаачилгаар буюу Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Дээд шүүх, Улсын Ерөнхий прокурорын хүсэлтээр хянан шийдвэрлэнэ" гэсэн заалтыг зөрчиж Үндсэн хуулийг зөрчсөн тухай аль ч асуудлаар Үндсэн хуулийн Цэцэд хандах тухай иргэдэд Үндсэн хуулиар олгогдсон эрхийг хязгаарласан байна.

Энэ талаар гарсан Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн 1995 оны 02 тоот дүгнэлтийг хүлээн зөвшөөрөөгүй, Улсын Их Хурлын 1995 оны 3 дугаар сарын 13-ны 20 дугаар тогтоол хууль зүйн үндэслэлгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 3,4, Үндсэн хуулийн Цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг удирдлага болгон Үндсэн хуулийн Цэцийн бүх гишүүдийн хурлаас **ТОГТООХ** нь:

1. Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийг 1 дэх хэсгийн "...энэ хуулийн 8 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан албан тушаалтан" гэсэн заалтыг хүчингүй болгосугай.

2. Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн дүгнэлтийг тухайн Монгол Улсын Их Хурлын 1995 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 20 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

3. Энэ тогтоол эцсийн шийдвэр тул гармагцаа хүчин төгөлдөр болно.

Дарга  
Гишүүд:

Г.СОВД  
Г.НЯМДОО  
Л.БААСАН  
Ц.ЦОЛМОН  
Ж.ВЯМБАА  
С.ЖАНЦАН  
Ч.ЭНХБААТАЙ

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

1995 оны 2 дугаар  
сарын 22-ны өдөр

Дугаар 31

Улаанбаатар  
хот

**Журам батлах тухай**

Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. "Хөрөнгө оруулалтын өмнөх судалгаа, хөтөлбөр, төслүүдийг зөвшөөрөх, батлах, хэрэгжилтэнд хяналт тавих журам"-ыг хавсралтын ёсоор баталсугай.

2. Засгийн газраас энэ журам гарахаас өмнө баталсан буюу цашид шинээр баталж хэрэгжүүлэх хөтөлбөр, төслүүдийг дээрх журмын дагуу ангиж тэдгээрийн хоорондын уялдаа холбоо, эрэмбэ дарааллыг тогтоох, хэрэгжүүлэгч байгууллага, санхүүжүүлэх эх үүсвэрийг тухайн жилд эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган шийдвэрлэж байхыг Үндэсний хөгжлийн газар /Ч.УЛААН/, Сангийн нам /Э.БЯМБАЖАВ/-д двалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

П.ЖАСРАЙ

Монгол Улсын сайд бөгөөд

Үндэсний хөгжлийн газрын дарга

Ч.УЛААН

Засгийн газрын 1995 оны 31 дүгээр  
тогтоолын хавсралт

**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ӨМНӨХ СУДАЛГАА, ХӨТӨЛБӨР,  
ТӨСЛҮҮДИЙГ ЗӨВШӨӨРӨХ, БАТЛАХ, ХЭРЭГЖИЛТЭД  
ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ**

Нэг. Ерөнхий зүйл

1. Энэ журмыг хөрөнгө оруулалтын өмнөх судалгаа/салбарын мастер төлөвлөгөө, хөтөлбөр, техник-эдийн засгийн үндэслэл г.м./-г зөвшөөрөлдөх, батлах, хэрэгжилтэд нь хяналт тавихад

мөрдөнө. Яам, тусгай газар, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар энэ журмыг үндэс болгон тухайн салбар, бүс нутгийн онцлогийг тусгасан зааврыг боловсруулж Үндэсний хөгжлийн газартай зөвшөөрөлцөж батлан, мөрдүүлж болно.

**Хоёр. Хөрөнгө оруулалтын өмнөх судалгааны ангилал**

2. Хөрөнгө оруулах асуудлыг хамгийн үр ашигтайгаар шийдвэрлэхийн тулд тухайн салбар, орон нутгийн түвшинд хийгдэж буй бүх төрлийн урьдчилсан судалгааг "хөрөнгө оруулалтын өмнөх судалгаа" гэнэ.

3. Хөрөнгө оруулалтын өмнөх судалгааг:

- салбарын мастер төлөөлөгөө;
- хөтөлбөр, дэд хөтөлбөр;
- урьдчилсан судалгаа;
- техник-эдийн засгийн үндэслэл /ТЭЗҮ/ гэж ангилна.

4. Энэ журмын 3-т тусгагдсан ангилалд хамаарагдах бөгөөд дотоодын эрдэм шинжилгээ, зураг төслийн байгууллагын хүчээр хийх судалгааны захиалгыг тухайн яам, тусгай газар, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар батална.

5. Дотоодын эрдэм шинжилгээ, зураг төслийн байгууллагын хүчээр боловсруулж, бэлэн болсон хөрөнгө оруулалтын өмнөх судалгааг дор дурдсан байгууллагууд зөвшөөрөлцөж батална:

	Бэлэн болсон судалгааг	
	Зөвшөөрөлцөх байгууллага	Батлах байгууллага
1.Салбарын мастер төлөөлөгөө	Үндэсний хөгжлийн газар	Засгийн газар
2.Хөтөлбөр, дэд хөтөлбөр	Яам, тусгай газар, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар	Үндэсний хөгжлийн газар
3.Урьдчилсан судалгаа	Үндэсний хөгжлийн газар	Яам, тусгай газар аймаг, нийслэлийн Засаг дарга
4.Техник-эдийн засгийн үндэслэл	Энэ журмын 2i-д заасны дагуу	Энэ журмын 2i-д заасны дагуу

6. Яам, тусгай газар, аймаг, нийслэлийн Засаг дарга гадаад орон, олон улсын байгууллагын хөрөнгө, хүчээр буюу тус дэмжлэгтэйгээр хийлгэх бүх төрлийн судалгааны захиалгыг энэхүү журмын хавсралтын дагуу боловсруулж сайд /дарга/-ийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн Үндэсний хөгжлийн газарт оруулж шийдвэрлүүлнэ.

7. Энэ журмын 5-д заасан бэлэн болсон салбарын мастер төлөөлөгөө болон хөтөлбөр, дэд хөтөлбөрийг харьяалах яам, тусгай газрын сайд, /дарга/-ийн болон аймаг, нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн шийдвэрийн хамт Үндэсний хөгжлийн газарт оруулна.

8. Онцгой тохиолдолд шаардлагатай гэж үзсэн энэ журмын 5-д заасан зарим судалгаа хийлгэх захиалгыг Үндэсний хөгжлийн газраас санаачлан холбогдох яам, тусгай газар, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтарч боловсруулан шийдвэрлүүлж болно.

Гурав. Хөтөлбөр, төслийн ангилал

9. Хөрөнгө оруулалтын хөтөлбөр, төслийг стратегийн ач холбогдол, хамрах хүрээ, хэрэгжүүлэгч байгууллага, санхүүжүүлэх эх үүсвэр зэргээс хамааруулан:

- а) үндэсний хөтөлбөр;
- б) Засгийн газрын төсөл;
- в) салбар, бүс нутгийн төсөл гэж ангилна.

#### А. Үндэсний хөтөлбөр

10. Монгол Улсын хөгжил, эдийн засгийн аюулгүй байдалд стратегийн ач холбогдол бүхий тодорхой зорилт, дунд болон урт хугацаанд хөгжүүлэх бодлогыг тодорхойлсон, нэг буюу хэд хэдэн салбар, бүсийн үйл ажиллагааны хүрээг хамарсан баримт бичгийг үндэсний хөтөлбөр гэнэ.

11. Үндэсний хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээ, төслийг улсын төвлөрсөн төсөв, Засгийн газрын нэрийн өмнөөс гадаадаас авах зээл, тусламжийн хөрөнгө, банкны зээл, өөрийн хөрөнгө, бусад эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

12. Үндэсний хөтөлбөр боловсруулах шийдвэрийг Засгийн газраас гаргах бөгөөд хөтөлбөр зохиох санал, үндэслэл, захиалгыг Үндэсний хөгжлийн газраас Засгийн газарт оруулж шийдвэрлүүлнэ.

13. Үндэсний хөтөлбөрийг боловсруулах, түүнд тусгагдсан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллагуудыг Засгийн газраас тогтооно.

#### Б.Засгийн газрын төсөл

14. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон бөгөөд Засгийн газраас санхүүжилтийн эх үүсвэр, хэрэгжүүлэгч байгууллагыг нь зохицуулах төслүүдийг Засгийн газрын төсөл гэнэ.

15. Засгийн газрын төсөл нь дор дурдсан эх үүсвэрээс санхүүжигдэнэ. Үүнд:

-олон улсын байгууллага, гадаад орны зээл, тусламжийн хөрөнгө;

-улсын төвлөрсөн төсөв, Засгийн газрын тусгай зориулалтын сангийн хөрөнгө;

-банкны зээл;

-өөрийн хөрөнгө, хандив;

-бусад хөрөнгө.

16. Засгийн газрын төслийг сонгох, хэрэгжүүлэхэд өмчийн хэлбэрийг ялгаварлахгүй

17. Засгийн газрын төсөл хийлгэх захиалгыг холбогдох нам, тусгай газар, аймаг, нийслэлийн Засаг даргын шийдвэрийг үндэслэн Үндэсний хөгжлийн газраас батална.

#### В. Салбар, бүс нутгийн төсөл

18. Үндэсний хөтөлбөр, Засгийн газрын төсөлд нэр заан тусгагдаагүй бөгөөд нам, тусгай газар, аймаг, нийслэлээс санхүүжилтийн эх үүсвэр, хэрэгжүүлэгч байгууллагыг нь зохицуулах, тухайн салбарын тодорхой нэр төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл ажиллагааг хамаарах буюу тухайн бүс нутгийн зах зээл, нийгмийн зориулалттай дэд бүтцийг хөгжүүлэх хэрэгцээг хангахад шууд чөлгөгдсөн төслүүдийг салбар, бүс нутгийн төсөл гэнэ.

19. Салбар, бүс нутгийн төсөл нь дор дурдсан эх үүсвэрээс санхүүжигдэнэ. Үүнд:

-зээл;

-өөрийн хөрөнгө, хандив;

-орон нутгийн төсөв;

-бусад хөрөнгө.

20. Салбар, бүс нутгийн төслийг харьяалах салбарын хям, тусгай газар, аймаг, нийслэлийн Засаг даргын шийдвэрээр томилогдсон байгууллагууд хархуцан боловсруулж хэрэгжүүлнэ.

### Дөрөв. Хөтөлбөр, төслийг зөвшөөрөлдөх, батлах

21. Энэ журмын 9-д тусгагдсан ангилалд хамаарагдах хөтөлбөр, төслийн техник-эдийн засгийн үндэслэл, тооцоог дор дурдсан байгууллагууд боловсруулан зөвшөөрөлдөж батална:

	Хөтөлбөр, төслийг боловсруулах байгууллага	Бэлэн болсон хөтөлбөр төслийн ТЭЗҮ-ийг батлах байгууллага
1. Үндэсний хөтөлбөр	Холбогдох хям, тусгай газар	Засгийн газар/ Улсын Их Хуралд оруулах буюу өөрөө шийдвэрлэх/
2. Засгийн газрын төсөл	Яам, тусгай газар	Засгийн газар
3. Салбар, бүс нутгийн төсөл	Яам, тусгай газар, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар	Яам, тусгай газар аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар

22. Хөтөлбөр, төслийг боловсруулах захиалгад энэ журмын хансралтад заасан маягтад дурдсан үзүүлэлтүүдийг тусгасан байх шаардлагатай бөгөөд сайд, тусгай газрын даргын болон аймаг, нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн шийдвэрийн хамт батлуулахаар Үндэсний хөгжлийн газарт оруулна.

23. Батлагдсан даалгаврын дагуу боловсрогдож бэлэн болсон Засгийн газраар шийдвэрлүүлэх хөтөлбөр, төсөл, ТЭЗҮ-ийг батлуулахын өмнө эдийн засаг, нийгмийн хөгжлийн тэнцвэр, стратеги, улсын төсөв, хөрөнгө оруулалт, гадаадын зээл тусламжийг ашиглах бодлого чиглэлтэй уяадуулах зорилгоор Үндэсний хөгжлийн газраар хянуулж, албан ёсны санал, дүгнэлтийг авч Засгийн газарт оруулна.



24. Хөтөлбөр, төслийг санхүүжүүлэх эх үүсвэрийг тухайн жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, төсвийн төслийг боловсруулах явцад уялдуулан зохицуулна.

25. Гадаад орон, олон улсын байгууллагаар хийлгэж бэлэн болсон хөрөнгө оруулалтын өмнөх бүх төрлийн судалгааг хэрэгжүүлэх асуудлыг Засгийн газарт оруулж шийдвэрлүүлнэ.

26. Тухайн өнд улсын төвлөрсөн төсөв, Засгийн газрын тусгай зориулалтын сан болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, судалгаа хийх ажлын жагсаалтыг холбогдох нам, тусгай газар, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын саналыг үндэслэн Үндэсний хөгжлийн газраас нэгтгэн боловсруулж, Засгийн газарт оруулж шийдвэрлүүлнэ.

27. Яам, тусгай газар, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрууд хөрөнгө оруулалтын өмнөх судалгааны баримт бичгүүдэд орох тодотгол, өөрчлөлтийг тухай бүр хийх замаар байнга бичжүүлж, боловсронгуй болгох ажлыг хариуцан гүйцэтгэнэ.

#### Тав. Хяналт тавих, тайлагнах

28. Үндэсний хөтөлбөр, Засгийн газрын төслийн хэрэгжилтийн явцыг нам, тусгай газар, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газраас тогтоогдсон маягтын дагуу хагас жилдээ гаргаж дараа сард багтаан Үндэсний хөгжлийн газарт тайлагнана.

29. Үндэсний хөгжлийн газраас Үндэсний хөтөлбөр, Засгийн газрын төслийн хэрэгжилтийн явцад байнга хяналт тавьж, Засгийн газарт танилцуулж байна.

Хөрөнгө оруулалтын өмнөх судалгаа,  
хөтөлбөр, төслүүдийг зөвшөөрөх,  
батлах, хэрэгжилтэд хяналт тавих  
журмы хавсралт

**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ӨМНӨХ СУДАЛГАА  
/ТӨСЛИЙН ТЕХНИК-ЭДИЙН ЗАСГИЙН  
ҮНДЭСЛЭЛ,ЗУРАГ ТӨСӨЛ/ ЗОХИОХ  
ЗАХИАЛГЫН ЗАГВАР**

1995 оны... дугаар  
сарын... -ны өдөр

Дугаар

Улаанбаатар  
хот

1. Техник-эдийн засгийн үндэслэл /зураг төсөл/ зохиох  
үндэслэл;

2. Үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах үндсэн чиглэл;

3. Байршил;

4. Хүч чадал;

5. Инженерийн байгууламж, түүнийг хангах эх үүсвэр /холбоо,  
цахилгаан, уур, дулаан, ус хангамж, цэвэр, бохир усны шугамын  
техникийн нөхцөл/;

6. Үйлдвэрлэл, аж ахуйн хоршилт, төрөлжилт;

7. Хэрэгжүүлэгч байгууллага;

8. Төсөл боловсруулах байгууллага;

9. Гүйцэтгэгч байгууллага;

10. Техник-эдийн засгийн үндэслэл зохиох хугацаа;

11. Санхүүжилтийн эх үүсвэр;

12. Онцгой нөхцөл.

Зөвшөөрсөн:

Боловсруулсан:

Хэрэгжүүлэгч байгууллагын төлөөлөгч \_\_\_\_\_

Төсөл боловсруулах байгууллагын төлөөлөгч \_\_\_\_\_

Тайлбар: Байршилд газар олгосон тогтоол, шийдвэр,  
инженерийн хангамжийн техникийн нөхцөлүүд,  
байгаль орчин шаардлагыг тус тус хавсаргана.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН  
ТОГТООЛ

1995 оны 3 дугаар  
сарын 1-ний өдөр

Дугаар 33

Улаанбаатар,  
хот

Шагналын тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Олимпын наадам, тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээн, тоглолтод өндөр амжилт гаргасан тамирчдад олгох мөнгөн шагналын хэмжээг хавсралтын ёсоор тогтоосугай.

2. Улсын төсвөөс спортын арга хэмжээнд төлөвлөсөн зардлыг санхүүжүүлэхдээ шагналд зарцуулах хөрөнгийг урьдчилан олгож, үзүүлсэн амжилттай нь уялдуулан эцэслэн тооцож байх талаар болон олон улсын хийгээд улсын аварга шалгаруулах тэмцээний шагналын талаар заавар боловсруулан баталж 1995 оны 7 дугаар сарын 1-нээс эхлэн мөрдүүлэхийг Эрүүл мэндийн сайд П.Нямдаваа, Сэнгийн сайд Э.Бимбажав нарт дэалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Биеийн тамир, спортын уралдаан, тэмцээний шагналын тухай" БИМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1987 оны 4 дүгээр сарын 3-ны өдрийн 132 дугаар тогтоолыг хүчингүй болгохыг тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд  
Эрүүл мэндийн сайд

П.Жисрай  
П.Нямдаваа

Засгийн газрын 1995 оны 33  
дугаар тогтоолын хавсралт

**ОЛИМПИЙН НААДАМ, ТИВ, ДЭЛХИЙН АВАРГА  
ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН, ТОГЛОЛТОД ӨНДӨР  
АМЖИЛТ ГАРГАСАН ТАМИРЧДАД ОЛГОХ  
МӨНГӨН ШАГНАЛЫН ХЭМЖЭЭ**

(мянган төгрөгөөр)

N	Тэмцээний ангилал	Эзэлсэн байр		
		1	2	3
1.	Олимпийн наадам	10000,0	5000,0	2500,0
2.	Дэлхийн аварга	2500,0	1200,0	600,0
3.	Тивийн тоглолт	1000,0	600,0	400,0
4.	Тивийн аварга	600,0	400,0	200,0

Тайлбар: 1. Дэлхий тивийн залуучуудын аварга шалгаруулах тэмцээний шагналыг насанд хүрэгчдийн шагналын 50 хувиар, өснөр үеийн аварга шалгаруулах тэмцээний шагналыг залуучуудын шагналын 50 хувиар тус тус бодож олгоно.

2. Тамирчдын шагналаас бодож дасгалжуулагч болон бусад хамтран ажиллагчдыг урамшуулах хувийг тэдний хооронд буюу спортын холбоо, клубтэй тамирчдын байгуулсан гэрээний дагуу шийдвэрлэнэ.

3. Багийн тоглолтоор тэргүүн байр эзэлбэл дээрх хэмжээний шагналыг багт нь олгоно.

4. Олон улсын тэмцээнд спортын төрөл, оролцогч орон, тамирчдын тоог харгалзан уралдаан тэмцээний албан ёсны протоколыг үндэслэн тамирчдад олгох шагналын хэмжээг 50 хүртэл хувиар багасгаж болно.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1995 оны 3 дугаар  
сарын 1-ний өдөр

Дугаар 35

Улаанбаатар  
хот

Барилгын талаар авах зарим  
арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Дэд бүтцийн хөгжлийн яам /Р.САНДАЛХАН/, Үндэсний хөгжлийн газар /Ч.УЛААН/-г даалгах нь:

а) "Барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиг хандлага", "Барилга, авто замын техникийн шинэчлэл" төслийг хэрэгжүүлэхтэй холбогдсон тодорхой арга хэмжээ, түүнд шаардагдах хөрөнгийн асуудлыг жил бүрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн Үндсэн чиглэлийн төсөлд ээлж дараатайгаар тусган шийдвэрлэж, хэрэгжүүлсүгэй;

б) олон улсын санхүүгийн байгууллага, хандивлагч орнуудаас үзүүлэх техникийн тусламжийг ашиглах боломжийг авч үзэхийн хамт холбогдох эрдэм шинжилгээ, зураг төслийн байгууллагыг оролцуулах үндсэн дээр "Барилгын салбарыг хөгжүүлэх мастер төвлөгөөг"-г 1996 онд багтаан боловсруулах арга хэмжээ авсугай;

в) төсвийн хөрөнгө оруулалт болон банкны зээл, гадаадны зээл, тусламж өөрийн хөрөнгөөр санхүүжигдэн баригдах томоохон барилга байгууламжийн техник-эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах, барьж байгуулах гүйцэтгэгчийг тендер зарласны үндсэн дээр сонгон шалгаруулж байхын хамт энэ тухай журмыг 1995 оны 1 дүгээр улираад багтаан боловсруулж мөрдүүлсүгэй.

2. Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад барилга-угсралтын ажил эрхлэх зөвшөөрөл олгох журмыг энэ оны 4 дүгээр сард багтаан баталж мөрдүүлэхийг Дэд бүтцийн хөгжлийн сайд Р.Сандалханд даалгасугай.

3. Аж ахуйн нэгж, байгууллагуудаас хөрөнгийнхөө эх үүсвэрийг төвлөрүүлж ашиглах замаар шинээр орон сууц барих, дуусгаагүй барилгыг тодорхой хугацаанд барьж дуусгасны үндсэн дээр "түлхүүр" хүлээлгэн өгөх хэлбэрээр худалдаж байгаа ажлын арга

хэлбэрийг дэмжиж, цаашид энэ чиглэлээр ажиллахад нь өмчийн бүх төрлийн аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг тусалцаа үзүүлж байхыг Засгийн газрын Өмч хувьчлалын комисс /Л.ЭНЭБИШ/, Үндэсний хөгжлийн газар /Ч.УЛААН/, Дэд бүтцийн хөгжлийн яам /Р.САНДАЛХАН/, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

4. Барилгачдыг гэрээгээр гадаадад түр хугацаагаар ажиллуулж барилга-угсралтын хийгээд засал чимэглэлийн ажлын шинэ арга, туршлага эзэмших явдлыг дэмжиж зохион байгуулахын зэрэгцээ шинээр ажлын байр бий болгох, ялангуяа импорттыг багасгаж, экспортыг нэмэгдүүлэх боломжтой жижиг, дунд үйлдвэрийг барьж байгуулах төслийг тэргүүн ээлжинд хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээллээр хангах, санхүүжилтийн асуудлыг нь оновчтой шийдвэрлэх арга хэмжээ анч ажиллахыг Хүн амин бодлого, хөдөлмөрийн яам /Э.ГОМБОЖАВ/, Худалдаа, үйлдвэрийн яам /Ц.ЦОГТ/, Дэд бүтцийн хөгжлийн яам /Р.САНДАЛХАН/-д даалгасугай.

5. Барилгын үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиг хандлага, энэ талаар төрөөс явуулж байгаа бодлоготой уялдуулан орон нутгийн ноёд бололцоог бүрэн дүүрэн ашиглах замаар бүс нутгийн хэмжээнд барилгын үйлдвэрлэлийг сэргээн хөгжүүлэх чиглэлийг тодорхойлж, тодорхой үе шат, дэс дараатайгаар хэрэгжүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

6. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 1992 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 28 дугаар тогтоолын 4,5,7,8,9 дүгээр зүйлийг хүчингүй болсонд тооцож, 12 дугаар зүйлийн "Барилгын материал концернд" гэснийг "Дэд бүтцийн хөгжлийн яаманд" гэж өөрчилсүгэй.

Монгол Улсын Ерөнхий сайд  
Дэд бүтцийн хөгжлийн сайд

П.ЖАСРАЙ  
Р.САНДАЛХАН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН  
ТОГТООЛ

1995 оны 3 дугаар  
сарын 3-ны өдөр

Дугаар 37

Улаанбаатар  
хот

Хорих байгууллагуудын талаар  
авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Хорих байгууллагын бөлон хорих ял эдлүүдэх тухай" Монгол Улсын хуулийн 12 дугаар зүйлийн 1 дүгээр хэсэгт зэвсгийг хэрэгжүүлж, хоригдлыг ажлын байраар хангах асуудлыг боловсруулан энэ оны 5 дугаар сарын 1-ний дотор шийдвэрлүүлж, биелэлтийг хангуулах үүрэг бүхий ажлын хэсгийг дор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулж ажиллуулсугай:

Ажлын хэсгийн ахлагч

-Монгол Улсын шадар сайд  
Л.Энэбиш

Гишүүд:

-Монгол Улсын сайд бөгөөд  
Үндэсний хөгжлийн газрын  
дарга Ч.Улаан;  
-Хууль зүйн сайд  
Н.Лувсанжав;  
-Сангийн дэд сайд  
С.Очирипүрэв;  
-Худалдаа, үйлдвэрийн дэд  
сайд Ц.Бидон;  
-Байгаль орчин дэд сайд  
Ц.Шийрээдамба;  
-Хүнс, хөдөө аж ахуйн дэд  
сайд Г.Сүрэнжаргал;  
-Эрчим хүч, геологи, уул  
уурхайн дэд сайд Д.Амгалин;  
-Дэд бүтцийн хөгжлийн  
дэд сайд Ц.Дамирэн;  
-Хорих байгууллагуудыг  
удирдах газрын дарга  
Г.Дэндэв.

2. Хорих байгууллагуудын нэгдсэн эмнэлгийн байрыг Цагдаагийн ерөнхий газарт, Улиастай дахь цэргийн 228 дугаар ангийн байрыг Хорих байгууллагуудыг удирдах газарт тус тус балансаас балансад шилжүүлэхийг Батлан хамгаалахын сайд Ш.Жадамбаа, Хууль зүйн сайд Н.Лувсанжав нарт даалгасугай.

3. Хоригдлуудыг эрүүл мэндийн даатгалд хамруулах ажлыг энэ оны 2 дугаар улиралд багтаан зохион байгуулах, үүнтэй холбогдуулан шаардлагатай бол санхүүжилтэд зохицуулалт хийхийн хамт хорих ял эдэлж байгаа ялтны даатгалын хураамж төлөх журам тогтоож мөрдүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Э.Бямбажав, Хууль зүйн сайд Н.Лувсанжав, Эрүүл мэндийн сайд П.Нямдаваа нарт даалгасугай.

4. Хорих байгууллагын эмнэлгүүдийг мэргэжлийн боловсон хүчинээр хангах, эмч, мэргэжилтнүүдийнх нь мэргэшил, мэдлэгийг дээшлүүлэх, ажиллагчдын хөдөлмөр хамгаалалтыг сайжруулах, шаардлагатай багаж, төхөөрөмжөөр хангах ажлыг тодорхой төлөвлөгөөний дагуу үе шаттай зохион байгуулж хэрэгжүүлэхийг Хууль зүйн сайд Н.Лувсанжав, Эрүүл мэндийн сайд П.Нямдаваа нарт үүрэг болгосугай.

5. Дор дурдсан арга хэмжээг 1995 оны 4 дүгээр сард багтаан авахыг Сангийн сайд Э.Бямбажавт даалгасугай:

а) Хорих байгууллагуудыг удирдах газарт холбоо, дохиоллын тоног төхөөрөмж, хорих байгууллагуудын нэгдсэн эмнэлэгт эмнэлгийн зориулалттай зарим техник хэрэгсэл авах, дамжин өнгөрүүлэх ангийг хоригдол тээвэрлэн хүргэх унаатай болгох, Зүүн-хараагийн хорих ангид гахай, тахиа үржүүлэх ажлын байр бий болгох, Мааньтын хорих ангийн үйлдвэрлэлийн хүч чадлыг нэмэгдүүлэх, хорих байгууллагуудын нэгдсэн эмнэлгийн шинэ байранд цэвэр, бохир усны шугам тавих, хамгаалалтын хашаа барих зардлыг санхүүжүүлэхэд зориулан Засгийн газрын 1995 оны нөөц хөрөнгөөс 100,0 сая төгрөг гаргах;

б) үр тариа, төмс, хүнсний ногооны үр худалдаж авахад зориулан ургацаа хурааж авсных нь дараа буцааж тооцохоор Хорих байгууллагуудыг удирдах газарт хуваарилагдсан төсвөөс 30,0 сая төгрөгийг урьдчилан олгох;

в) Хорих байгууллагуудыг удирдах газрын төсвийн хөрөнгийн хуваарилалт, зарцуулалтын байдал, 1994 онд улсын төсвөөс дутуу санхүүжигдсэн зардлын тооцоог шалгаж дүгнэлт гаргах.



6. Дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Цагдаагийн ерөнхий газар (Б.ПҮРЭВ)-т даалгасугай:

а) цагдаа хорих байранд түр хоригдож буй хоригдогчдын хоолны хангамж, хооллолтын байдлаа байнгын хяналт тавих журам тогтоож мөрдүүлэх;

б) цагдаа хорих байранд хоригдогчийг хүлээн авахдаа иргэний паспорт, эрүүл мэндийн даатгалын дэвтэр зэрэг зайлшгүй шаардлагатай бичиг баримтыг нь бүрдүүлж, хоригдогч бүрт эрүүл мэндийн дэвтэр нээж зохих журмаар хөтлөн хувийн хэрэгт нь хансаргаж байх журам тогтоож мөрдүүлэх.

7. Тусгай график, хуваарийн дугуу хорих байгууллагуудын нэгдсэн эмнэлэг, аймгийн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нараар хоригдлуудад хагас жил тутамд эрүүл мэндийн үзлэг хийлгэж, эмчлэн эрүүлжүүлэх ажлыг тодорхой төлөвлөгөөний үндсэн дээр гүйцэтгэж байхыг холбогдох аймгийн Засаг дарга, Хорих байгууллагуудыг удирдах газрын дарга Г.Дэндэв нарт даалгасугай.

8. Хууль зүйн сайд Н.Лувсанжав, Хорих байгууллагуудыг удирдах газрын дарга Г.Дэндэв нарт даалгах нь:

а) хоригдол турах, өвчлөхөд хүргэж байгаа шалтгааныг судлан тогтоож, хоригдлын ахуйн нөхцөл, эмчилгээ, үйлчилгээний чанарыг сайжруулах, оношилгооны түвшинг дээшлүүлэх чиглэлээр цогцолбор арга хэмжээ авч хэрэгжүүлэхийн хамт ажилтнуудын ажлын хариуцлага, сахилгыг эрс дээшлүүлж, аливаа зөрчил, дутагдал гаргагчидтай цаг тухайд нь хариуцлага тооцож ажилласугай;

б) Дархан-уул аймгийн жирийн дэглэмтэй хорих ангид Сэлэнгэ аймгийн харьяат хоригдлуудыг ил эдлүүлэхтэй холбогдсон зардлыг санхүүжүүлэх асуудлыг дээрх аймгийн Засаг дарга нартай хамтран судалж шийдвэрлэсүгэй;

в) Дархан-уул аймгийн хорих ангийн авсан 3,0 сая төгрөгийн зээлийн өрийг энэ оны 3 дугаар сард багтаан төлж барагдуулах арга хэмжээ авсугай;

г) энэ тогтоолыг хэрэгжүүлэх талаар зохиож байгаа ажлынхаа үр дүнг хагас жил тутамд Засгийн газарт танилцуулж байсугай

Монгол Улсын Ерөнхий сайд  
Сянгийн сайд  
Хууль зүйн сайд

П.ЖАСРАЙ  
Э.БЯМБАЖАВ  
Н.ЛУВСАНЖАВ

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1995 оны 3 дугаар  
сарын 13-ны өдөр

Дугаар 38

Улаанбаатар  
хот

Төсөл шалгаруулах журам  
батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Төсөл уралдуулан шалгаруулах (тендер зохион байгуулах)  
журмыг"-ыг хавсралтын ёсоор баталсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд  
Худалдаа, үйлдвэрийн сайд

П.ЖАСРАЙ  
Ц.ЦОГТ

Засгийн газрын 1995 оны 38 дугаар  
тогтоолын хавсралт

### ТӨСӨЛ УРАЛДУУЛАН ШАЛГАРУУЛАХ (ТЕНДЕР ЗОХИОН БАЙГУУЛАХ) ЖУРАМ

#### Нэг. Нийтлэг үндэслэл

1. Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор оновчтой төслийг шударга өрсөлдөөний үндсэн дээр уралдуулан сонгон шалгаруулах үйл ажиллагааг зохион байгуулахад энэхүү журмыг мөрдлөг болгоно.

2. Энэ журамд хамаарах "төслийн тендер" гэж хүнд, хөнгөн болон хүнсний үйлдвэр, хөдөө аж ахуй, зам, тээвэр, хөлбоо, түлш, эрчим хүч, гадаад, дотоод худалдаа, нийтийн үйлчилгээ зэрэг үйлдвэрлэл, үйлчилгээний бүх салбарын чиглэлээр хэрэгжүүлэх төслүүд дотроос улс орны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх бодлогын хүрээнд тодорхой чиглэл, зорилгыг хэрэгжүүлэхийн тулд хөнгөлөлттэй зээл олгох, баталгаагаар хангах, үйлдвэрлэлийн явцад татварын хөнгөлөлт үзүүлэх, тухайлсан объект дээр төсөл

хэрэгжүүлэх эрх олгох зэрэг арга замаар Засгийн газраас дэмжих төслүүд, эсвэл тодорхой төслийг хэрэгжүүлэх аж ахуйн нэгж, байгууллагыг уралдуулан сонгох үйл ажиллагааг хэлнэ.

3. Төслийн тендерийн зарлагч нь тухайн асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага байна. Тендер зарлагч нь тендерийг зарлах, дүгнэх ажлын хэсгийг тухайн тендерийн төрөл, салбар, үйлдвэрлэлийн онцлогийг харгалзан холбогдох нам, байгууллагатай зөвшилцож мэргэжлийн хүмүүсийг нь оролцуулан тухайн асуудлыг эрхэлсэн сайдын тушаалаар байгуулж ажиллуулна.

4. Төслийн тендерт оролцогч гэж тендер зарлагдсан тухайн төслийг хэрэгжүүлэх саналаа дангаар буюу хамтран дэншүүлж байгаа Монгол Улсын болон гадаадын хуулийн этгээдийн эрх бүхий өмчийн бүх төрлийн аж ахуйн нэгж, байгууллагыг хэлнэ.

5. Хөрөнгө оруулалтын санхүүжилтэд нь хөрөнгийн аливаа эх үүсвэр ашиглуулах, хөнгөлөлт үзүүлэх, баталгаа олгох замаар Засгийн газраас дэмжлэг үзүүлэх төслийн тендерт гадаадын хуулийн этгээд, гадаадын хөрөнгө оруулалттай байгууллагуудыг оролцуулах асуудлыг тухайн асуудал эрхэлсэн сайдын саналыг үндэслэн Засгийн газар шийдвэрлэнэ.

### Хоёр. Тендерийн хэлбэрүүд

6. Төслийн тендерийг нээлттэй болон хязгаарлагдмал хэлбэрээр зарлан явуулна.

7. Тендерт оролцогчдын хувьд аливаа хязгаарлалт тавихгүйгээр зарлаж байгаа тендерийг нээлттэй тендер гэнэ.

8. Тендерт оролцогчдыг тодорхой нөхцөлөөр сонгож буюу нэр заан хаяглаж зарласан тендерийг хязгаарлагдмал тендер гэнэ.

9. Хязгаарлагдмал тендерийг улс үндэстний нийтлэг ашиг сонирхолд харшлах үр дагавартай байж болзошгүй хийгээд тухайн төслийг хэрэгжүүлэх тодорхой чадвар бүхий оролцогчдыг хамруулах шаардлагатай тохиолдолд явуулна.

10. Тухайн тендерийн шаардлага, онцлогийг харгалзан тендерийг нээлттэй буюу хязгаарлагдмал хэлбэрийн аливаа нь зарлаж явуулахыг тендерийн ажлын хэсэг хэлэлцэж тогтооно.

### Гурав. Тендерт бэлтгэх

11. Тендерийг зарлагч нь тухайн тендерийн ажлын хэсгийг энэ журмын нэгдлийн 3-т заасан дагуу байгуулна.

12. Тендерийн ажлын хэсэг нь тухайн тендерийн баримт бичиг, зарлалыг бэлтгэж тухайн асуудал эрхэлсэн сайдын зөвлөлд танилцуулж шийдвэрлүүлдэг.

13. Тендерт чанартай сайн боловсрогдсон төслийг оруулахаар санал дэвшүүдэх шаардлагыг бодолцон тендерийн баримт бичгийн агуулгыг тодорхойлохдоо тендерт оролцогчдод адил тэнцүү нөхцөл бүрдүүлэх зарчмыг баримтална. Тендерийн баримт бичигт тендерт оролцох төслийн төрөл, чиглэл, шалгаруулах болзол, үзүүлэлт болон шалгарсан төслийг дэмжих арга хэмжээ, түүний нөхцөл, хөрөнгийн эх үүсвэр, тендер явуулах хэлбэр, үе шат, нээх хаах, шалгаруулах хугацаа, баталгаажилт зэрэг тендерт оролцогчдод хүргэвэл зохих дэлгэрэнгүй мэдээллийг бүрэн тусгасан байна.

14. Тендерийн баримт бичигт бүтээгдэхүүний зах зээлийн эрэлт хэрэгцээ, чанарын шаардлага, түүхий эд, материалын хэрэгцээ, хангах боломжийн тооцоо, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах байр, талбай, инженерийн хангамж, төслийн хэрэгжилтийн үе шат, хугацаа, хөрөнгө оруулалтын хэрэгцээ, үүний дотор өөрийн хөрөнгийн эх үүсвэрийн боломж, төслийн эдийн засаг, санхүүгийн үнэлгээ, мэргэжлийн ажиллах хүчний хангамж болон тендерт оролцогчийн хөрөнгө, төлбөрийн чадвар, ажлын давлага, туршлагын түвшин зэрэг асуудлаар тавигдах шаардлагыг заавал тусгана.

15. Тендерийн зарлалд тендерт оролцох төслийн чиглэл, хүрээ, тендерийг нээх, хаах хугацаа, байр, тендерийн баримт бичгийг худалдаж авч болох байр, харилцах хаяг зэрэг мэдээллийг тусгана.

16. Тендерийн зарлалыг нийтэлснээс хойш төслийн саналыг хүлээн авч дуусах хүртэлх хугацааг 1,5 сараас доошгүй байхаар тогтооно. Томоохон хэмжээний санхүүжилт шаардагдах буюу гадаадын оролцогчдод зарлаж буй төслийн хувьд тендерийн хугацааг 2,5 сараас доошгүй байхаар тогтооно.

### Дөрөв. Тендер зарлах

17. Нээлттэй тендерийг улсын хэмжээнд гардаг хэвлэл, радио, телевизээр зарлахаас гадна гадаадын хэвлэл, гадаад орноос Монгол Улсад суугаа болон Монгол Улсаас гадаад оронд суугаа Элчин сайдын яам, байнгин төлөөлөгчийн газар, худалдаа, эдийн засгийн төлөөлөгчийн албадаар дамжуулан зарлаж болно.

18. Хязгаарлагдмал тендерийг тендер зарлагч болон ажлын хэсгийн сонгосон аж ахуйн нэгж, байгууллагад нэгэн зэрэг мэдэгдэж зарлана.

19. Тендерийг хоёр үе шаттайгаар зарлаж болно. Эхний шатанд шалгарсан оролцогч нь анхны шатанд хүлээн зөвшөөрөгдсөн нөхцөлүүдийг суурь бөлгөн дараагийн шатны шалгаруулалтад оролцоно.

20. Тендерийн зарлагч нь эхний шатны шалгаруулалтад оролцогчдоос гүйцэтгэх чадварыг нь мэдэж тогтоохын тулд оролцогчдын үйл ажиллагаа, мэргэжлийн чадавхи, дадлага, туршлага, найдвартай ажиллагааны байдал, санхүүгийн боломжийн талаар шаардлагатай гэж үзсэн тодорхой мэдээ, үзүүлэлтийг шаардаж болно.

### Тав. Тендерийн баталгаажуулалт

21. Тендерт оролцогчид нь тодорхой хураамж төлөх хэлбэрээр баталгаажуулалтын хураамжийг төслийн саналын хамт тендер зарлагчид хүргүүлнэ. Баталгаажуулалтын хураамжийн төлбөрийг аккредитив болон бэлэн бус тооцооны хэлбэрээр гүйцэтгэнэ.

22. Тухайн тендерийн баталгаажуулалтын хураамжийн хэмжээг тендер зарлагч тогтоож тендерийн баримт бичигт тусгана.

23. Гадаадын оролцогчийн хувьд баталгаажуулалтыг төслийн санал хүлээж авах эцсийн хугацаанд багтаан тендер зарлагчийн дансанд шилжүүлсэн байна.

24. Тендерт оролцогч нь төслийн саналыг шүүн шалгаруулах хугацаанд өөрийн саналаа эргүүлж авах эрхтэй боловч энэ тохиолдолд баталгаажуулалтын төлбөрөө эргүүлж авах эрхгүй болж хураамж нь зарлагчийн мэдэлд үлдэнэ. Гэхдээ тендерийн зарлаамыг зогсоосон болон дэвшүүлсэн санал хүчингүй болсныг тогтоосон буюу шалгарч чадаагүй тохиолдолд баталгаажуулалтын төлбөрийг зарлагч нь оролцогчид буцааж олгоно.

25. Тендер зарлагч нь тухайн тендерийн хүрээнд шаардагдах хөрөнгийн эх үүсвэр, үзүүлэх хөнгөлөлт, нөхцөлүүд болон төсөл хэрэгжүүлэхээр эрх олгох тухайлсан объектын холбогдолтой асуудлыг тендерийг зарлахын өмнө зохио журмын дагуу заавал шийдвэрлэсэн байна.

### Зургаа. Тендерийг зогсоох

26. Зарлагч нь тендерийг төслийн саналуудыг хүлээж авах хугацааны дотор зогсоож болно. Энэ ажиллагааг тендер зарласны нэг адил гүйцэтгэнэ.

27. Тендерийг зогсооход хүрвэл тендэрт оролцогчдод тендерийн баримт бичгийн төлбөрийг эргүүлж төлнө. Энэ тохиолдолд өмнө худалдаж авсан тендерийн баримт бичгийг зарлагчид буцааж өгөх ёстой.

### Долоо. Тендэрт ирүүлэх санал

28. Тендэрт ирүүлэх төслийн саналд дараахь асуудлуудыг тодорхой боловсруулж тусгасан байвэл зохино:

а) тендерийн зарлалд эвсэн нөхцөлүүдийг хангасан байдлыг нотолсон тооцоо, үндэслэл;

б) төслийг хэрэгжүүлэхтэй холбогдсон ажлын зохион байгуулалт;

в) шаардагдах хөрөнгийн хэмжээ.

29. Тендэрт оролцогч дэвшүүлсэн төслийнхөө зарим үзүүлэлтийг олон нийтэд мэдэгдэхгүй байхыг шаардах эрхтэй. Гэхдээ санал дэвшүүлэгчийн нэр, хаяг, түүний хүсэж байгаа хөрөнгийн хэмжээ, төслийг хэрэгжүүлэх хугацааг нийтэд мэдээлэхийг хориглож болохгүй.

30. Дэвшүүлж байгаа төслийн саналыг битүүмжилж гардуулна. Тухайн тендэрт зориулсан гэдгийг гадна талд нь тодорхой бичсэн байх шаардлагатай.

31. Тендэрт шалгарсан оролцогч төслийг хэрэгжүүлэхээс үндэслэлтэйгээр татгалзвал дараачийн байр эзэлсэн оролцогчийг тендэрт шалгарснаар тооцох асуудлыг тендер зарлагч хянан үзэж шийдвэрлэнэ.

### Найм. Тендерт ирүүлсэн төслийн саналыг танилцуулах

32. Тендерт ирүүлсэн төслийн саналыг задалж нэр, хаяг, дэвшүүлж байгаа саналын гол үзүүлэлтийг тендерийн ажлын хэсэг хүлээн авч нийтэд зарлана. Нийтэд зарлахгүй үзүүлэлтийг нууцалж үлдээнэ.

33. Дэвшүүлсэн төслийн саналыг эвдлэхэд тухайн төслийг дэвшүүлэгч болон бусад оролцогчид байлцана. Битүүмжилсэн саналуудыг задлахад тендер зарласан чиглэлийн дагуу зах зээлд хяналт тавих үүрэг бүхий холбогдох байгууллагыг оролцуулна.

34. Битүүмжилсэн саналуудыг нээж танилцуулсны эцэст хүчинтэй саналуудыг тогтооно.

35. Төслийн саналыг дараахь тохиолдолд хүчингүй болсонд тооцно:

а) тендерт оролцох эрхгүй ( хязгаарлагдмал тендерт оролцох урилга, зарлал аваагүй болон тендерийн баримт бичиг худалдаж аваагүй) байгууллагаас ирүүлсэн төсөл;

б) зарласан хугацаанаас хоцорч ирүүлсэн төсөл;

в) тендер зарласан нөхцөлүүдийг хангаагүй.

36. Төслийн санал нь хүчингүйд тооцогдсон оролцогчид тендерийн цаашдын үйл ажиллагаанд оролцох эрхгүй.

37. Зарлагч нь тендертэй холбогдсон нууцыг хууль бусаар задруулж тендерт оролцогчдын аль нэгэнд нь давуу байдал олгосон тохиолдол гарвал бусад оролцогчид уг тендерийг хүчингүй болгохыг шаардах эрхтэй.

### Ес. Тендерт оруулсан төслийн саналыг шүүн хэлэлцэх

38. Тендерийн ажлын комисс тендерийн шалгуур үзүүлэлт, болзлыг хангасан төслүүдийг шалгаруулж тендерийн зарлагчид танилцуулж эцэслэн шийдвэрлүүнэ.

39. Тендерт оруулсан төслийн хүчинтэй саналыг шүүн хэлэлцэх явцад тодорхой зарим асуудлыг тодруулан магадлах шаардлагатай бол зарлагч нь тендерт оролцогчоос нэмэлт тайлбар, тодорхойлолт шаардах эрхтэй байна.

40. Тендерт оруулсан төслийн саналыг зарлагчийн төлөмж, тусалцаатайгаар өөрчилж болохгүй.

41. Зарлагч нь дэвшүүлсэн саналуудыг шүүн хэлэлцээд гаргасан шийдвэрээ тендерт оролцогчдыг урьж байлцуулан мэдэгдэх

бөгөөд хэрэв оролцогчид тухайн цагт ирээгүй бол шийдвэрийг бичгээр шууд мэдэгдэх үүрэгтэй.

42. Зарлагч тендерт оролцож буй саналыг зөвхөн тухайн тендерийн шийдвэр гаргахаас өөр зорилгоор ашиглах бол тухайн төслийн санал дээшүүдэгчтэй заавал тохиролцсон байна.

43. Тендерт оролцсон санал дээшүүдэгч нь төсөл боловсруулж бэлтгэсэн ажиллагааны зардлыг нөхөж гаргуулах шаардлага тавих эрхгүй.

## МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

1995 оны 3 дугаар  
сарын 17-ны өдөр

Дугаар 80

Улаанбаатар  
хот

### ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХИНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛСАН ЗАРИМ ЗҮЙЛ, ХЭСГИЙГ ТАЙЛВАРЛАХ ТУХАЙ

Иргэний хэрэг шүүхэд хианан шийдвэрлэх тухай Монгол улсын хуулийг шүүн таслах ажилд нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

Иргэний хэрэг шүүхэд хианан шийдвэрлэх тухай Монгол улсын хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг дор дурдсанаар тайлбарласугай.

1. Иргэний хэрэг шүүхэд хианан шийдвэрлэх тухай хууль /цаашид "хууль" гэх /-ийн 4 дүгээр зүйлийн 3-д заасан "... хуульд заасан асуудлаар сонирхогч этгээдээс гаргасан хүсэлт"-д мөн хуулийн 11 дүгээр бүлэгт болон хууль тогтоомжийн бусад актад заасан асуудлаар гаргасан хүсэлтүүдийг, мөн зүйлийн 4-т заасан "...хуульд заасан журмин дагуу гаргасан гомдол"-д мөн хуулийн 161 дүгээр зүйлийн 1-д заасан болон шүүхэд гомдол гаргахаар бусад хуульд заасан асуудлаар гаргасан гомдлыг хамваруулан ойлгоно.

2. Хуулийн 8 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "хэргийн нотлох баримт нь төр, байгууллага, хувь хүний нууцтай холбоотой бол



шүүх хуралдааныг бүрэн хаалттай буюу түүний зарим ажиллагааг хаалттай явуулж болно" гэсэн заалтыг тухайн хэргийн олонхи нотлох баримт, гэр, байгууллага, хувь хүний нууцтай холбоотой бол шүүх хуралдааныг бүхэлд нь хаалттай, хэрэв зарим нотлох баримт тэдний нууцтай холбоотой бол зөвхөн тэдгээр нотлох баримтыг шинжлэн судлах ажиллагааг хаалттай явуулахыг ойлгоно. Шүүх хуралдааныг бүхэлд нь буюу түүний зарим ажиллагааг хаалттай явуулах асуудлыг хэргийг шүүхэд шилжүүлэх тухай шүүгчийн захирамжаар шийдвэрлэнэ.

3. Хуулийн мөн зүйл хэсгийн гэр, байгууллага, хувь хүний нууц гэдгийг гэр, байгууллага, хувь хүний нууцны тухай Монгол улсын хуулиудад зааснаар ойлгоно.

4. Хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "шүүх хэрэг хянан шийдвэрлэхдээ гагцхүү Үндсэн хууль түүнд нийцүүдэж гаргасан албан ёсоор нийтлэгдсэн, хүчин төгөлдөр, бусад хуулийг хэрэглэнэ" гэдэг нь Монгол улсын Үндсэн хуулиар шууд зохицуулагдасан нийгмийн харилцаанаас үүссэн маргааныг шүүх шийдвэрлэхдээ Үндсэн хуулийг, Үндсэн хуулиар шууд зохицуулагдаагүй харилцаанаас үүссэн маргааныг шийдвэрлэхдээ Үндсэн хуульд нийцсэн, тэгэхдээ албан ёсоор нийтлэгдсэн, хүчин төгөлдөр болсон, өөрөөр хэлбэл Монгол улсын Их Хурлын тухай хуулийн 52, 53 дугаар зүйлд заасны дагуу уул хууль хүчин төгөлдөр болох тухай уг хуульд заасан өдрөөс, уг хуульд тусгайлан заагаагүй бол зөвхөн төрийн төв хэллэд нийтлэгдсэнээс хойш 10 хоног өнгөрснөөр хүчин төгөлдөр болсон хуулийг хэрэглэхийг ойлгоно. Тэгэхдээ хууль хүчин төгөлдөр болох өдрийг тухайн хуульд заасан боловч уул хууль төрийн төв хэллэд албан ёсоор нийтлэгдээгүй бол шүүх түүнийг хэрэглэх эрхгүй.

5. Хуулийн 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн гөдөрхой хэрэг шийдвэрлэх явцад шүүхээс хэрэглэх хууль нь Үндсэн хуульд нийцэхгүй байна гэж шүүх үзвэл тухайн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлж, Улсын дээд шүүхэд энэ талаар санал оруулна" гэсэн заалтыг шүүх хэрэглэхдээ тухайн хэргийг хянан шийдвэрлэхэд хэрэглэх хууль, эсхүд түүний зүйл, хэсэг, заалт нь Үндсэн хуульд нийцэхгүй байна гэж шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч үзвэл хэр үндэслэлээ гөдөрхой зааж, уул хууль, зүйл, хэсэг, заалтыг Үндсэн хуульд нийцүүлэх саналыг тусгасан хэрэг шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлсэн тогтоол, захирамж гаргаж Дээд шүүхэд ирүүлэхийг ойлгоно. Улсын Дээд

шүүх саналыг хуралдаанаараа хэлэлцэж шүүхийн санал үндэслэлгүй гэж үзвэл тогтоол, захирамжийг хүчингүй болгож, саналыг хэрэгсэхгүй болгох ба саналыг үндэслэлтэй гэж үзвэл хуулийг Үндсэн хуульд нийцүүлэх тухай саналыг Үндсэн хуулийн цэцэд оруулна.

6. Хуулийг Үндсэн хуульд нийцүүлэх талаар эрх бүхий байгууллагын шийдвэр гарч хүчин төгөлдөр болсон буюу уг хуулийг Үндсэн хуульд нийцээгүй тухай шүүхийн саналыг Улсын дээд шүүхээс үндэслэлгүй гэж үзсэн бол шүүх байцаан шийтгэх ажиллагааг шүүгчийн захирамжаар сэргээж хэрэг хэлэлцэх ажиллагааг ердийн журмаар үргэлжлүүлэн явуулна.

7. Хуулийн 22 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "14-өөс 18 хүртэлх насны хүмүүс өөрийн эрх, эрх чөлөө, ашиг сонирхлоо шүүхэд биечлэн хамгаалах эрхтэй" гэсэн заалтыг энэ насны хүмүүс нь Иргэний хуулийн 11-р зүйлийн 2 дахь хэсэгт заасан өөрөө бие даан хэрэгжүүлэх эрх болон өөрийн хөдөлмөрийн харилцаатай холбогдон үүссэн маргааныг шүүхээс хянан шийдвэрлэхэд эрх зүйн бүрэн чадамжтай нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдийн нэгэн адил оролцож, хуульд заасан эрх эдэлж, үүрэг хүлээхийг ойлговол зохино.

8. Мөн зүйлийн 3 дахь хэсгийн "шүүх энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан хүмүүст хамарагдах хэрэгт тэдний эцэг, эх харгалзан дэмжигчийг татан оролцуулах үүрэгтэй. Харин тэдгээрийн хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн хөлсийг зарцуулах явдалтай холбогдсон хэргийг шийдвэрлэхдээ тэдний эцэг, эх, харгалзан дэмжигчийг оролцуулах эсэхийг шүүх шийдвэрлэнэ" гэдгийг зөвхөн энэ тохиолдолд шүүх насанд хүрээгүй хүмүүсийн эцэг, эх, харгалзан дэмжигчийг шүүх хуралдаанд оруулах эсэхийг шийдвэрлэх, харин бусад бүх тохиолдолд тэдний эцэг, эх, харгалзан дэмжигчийг шүүх заавал татан оролцуулна гэж ойлгоно. Харин насанд хүрээгүй хүн нь хариуцагчлар оролцож байгаа бол тэрээр Иргэний хуулийн 383 дугаар зүйлд зааснаар ажил эрхэлж олсон цалин хөлс, орлого, түүнчлэн хууль ёсны төлөөлөгчөөс үзэмжээрээ захиран зарцуулахад нь шилжүүдсэн тодорхой эд хөрөнгийн хэмжээгээр хариуцаага хүлээх бөгөөд үлдэж байгаа хэсгийг нь хууль ёсны төлөөлөгч нь нөхөн хариуцана.

9. Хуулийн 30 дугаар зүйлийн "Хууль ёсны төлөөлөгч"-ийн төлөөлөх эрх нь иргэний паспорт, гэрээлтийн баталгаа, төрсний гэрчлэлээ, асран хамгаалах харгалзан дэмжих байгууллагын

шийдвэрээр, сайн дурын төлөөлөгчийн төлөөлөх эрх нь төлөөлөгчийн олгосон итгэмжлэлээр, гэрээгээр төлөөлөгчийн төлөөлөх эрх нь төлөөлүүлэгч төлөөлөгчийн хооронд хийгдсэн бичгийн гэрээгээр тодорхойлогдоно. Хууль ёсын төлөөлөгч төлөөлүүлэгчийн хуульд заасан бүх эрх, үүргийг итгэмжлэлээр болон гэрээгээр төлөөлөгч итгэмжлэл ба гэрээнд заагдсан эрх, үүргийг хүлээнэ.

10. Хуулийн 37 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "зохигч болон түүний төлөөлөгч буюу өмгөөлөгч, гуравдагч этгээд нь өөрийн шаардлага ба татгалзлын үндэс болж байгаа нотлох баримтаа өөрөө гаргаж өгөх, цуглуулах үүрэгтэй" гэдгийг нэхэмжлэгч түүний төлөөлөгч буюу өмгөөлөгч нэхэмжлэлийн шаардлага, хариуцагч түүний төлөөлөгч буюу өмгөөлөгч, гуравдагч этгээд нь нэхэмжлэгчийн шаардлагыг хүлээн авахаас татгалзаж байгаа үндэслэлээ нотолсон тайлбар гаргах, бичмэл ба эд мөрийн баримт, кино ба гэрэл зураг, зураглал, дүрс, дууны бичлэг, ул мөрнөөс буулгаж авсан хэв, хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрээр нэгэнт тогтоогдсон буюу нийтэд илэрхий гэж үзэгдсэн үйл баримтын тухай шүүхийн шийдвэр, мэдээ зэргийг эрж олж, шүүхэд гаргаж өгөх, тэдгээрийг өөрөө олж авах боломжгүй бол шүүхэд хандах, түүнчлэн гэрчийг байцаалгах, шинжээч томилуулан дүгнэлт гаргуулах, үзлэг, туршилт, таныж олгуулах ажиллагааг хийлгэх хүсэлт шүүхэд гаргахыг ойлгоно. Харин шаардлагатай гэж үзвэл гэрч байцаах, дүгнэлт гаргуулах, нэг төрлийн нотлох баримт зорьгоотой байгаа тохиолдолд аль нь үнэн болохыг тогтоох зэрэг ажиллагааг зохигчдоос хүсэлт гаргасан эсэхийг харгалзахгүйгээр шүүх өөрийн санаачилгаар хийх үүрэгтэй.

11. Хуулийн 37 дугаар зүйлийн 5-д заасан "нотлох баримтыг гаргах, цуглуулах талаарх хуульд заасан журмыг зөрчсөн" гэдэгт гэрчийг байцаахдаа хууль сацуулаагүй, гарын үсгийг зуруулаагүй болон гэрчийг байцаах эрхгүй этгээд байцаасан, гэрчээр өөрөөр нь тодорхойлолт бичүүж авсан, үзлэг, туршилт, таныж олгуулах ажиллагаанд явуулахдаа хондлонгийн 2 гэрч, хэргийн оролцогчдыг оролцуулаагүй, тэмдэглэл хөтлөөгүй, тэд нарнаар гарын үсэг зуруулаагүй, бичмэл нотлох баримтын хуулбарыг нотриатаар батлуулаагүй, дүгнэлт гаргах эрхгүй шүүхээс томилдоогүй эсвэл тухайн төрлийн мэдлэггүй этгээдээр дүгнэлт гаргуулсан, тэмдэглэл сэрвээг зэрэг хуульд заагаагүй хэлбэрийн баримт бичиг бүрдүүлсэн зэргийг хамааруулан ойлгоно.

12. Хуулийн 47 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "...зайлшгүй шаардлагатай нотлох баримт" гэдэгт шүүх хэргийг хянан хэлэлцэж бодит үнэнийг тогтоон шийдвэр гаргахад нөлөөлөх бүх төрлийн нотлох баримтууд хамаарна. Мөн зүйл хэсгийн "гаргах боломжгүй буюу бэрхшээл төнөгтэй болох" гэдгийг гэрч удаан хугацаагаар гадаад, дотоодод явах, хүмүүсийн үйлдэл байгалийн үйл явдлын улмаас бичмэл ба эд мөрийн баримт устаж үгүй болох, цаг хугацааны хүчин зүйлээс шалтгаалан ул мөр арилах зэргийг ойлгох бөгөөд "нотлох баримтыг хангах" гэдэгт гэрчийг байцаах, үзлэг, туршилт, таньж олуулах ажиллагаа хийх, бичмэл баримтыг олж авах, хуулбарлах, эд мөрийн баримтад үзлэг хийх, гэрэл зураг, дуу авианы бичлэг хийх, ул мөрийн хэв авах зэрэг ажиллагааг яаралтай гүйцэтгэх, хэргийн оролцогчид бусад иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас тодорхой үйлдэл хийхийг хориглох, бичмэл бэлэн эд мөрийн баримтыг хураан авах, хадгалуулах зэрэг ажиллагааг хийхийг ойлгоно.

13. Энэ хуулийн 55 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "...улсын тэмдэгтийн хураамж төлөх, хөнгөлөх журам" гэдэгт шүүхийн хувьд мөн хуулийн 56-58 дугаар зүйл, тэмдэгтийн хураамжийн хуулийн 18 дугаар зүйлд заасан журмыг ойлгоно. Гэхдээ шүүх улсын тэмдэгтийн хураамжийн тухайн хуулийн 18 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт хураамж төлөх хугацааг нэхэмжлэл хүлээн авахаас шүүх хуралдаан болтол тодорхой хугацаагаар хойшлуулах, хураамжийн хэмжээг тодорхой хувиар буюу хэмжээгээр багасгах, бүрэн чөлөөлж болно.

14. Мөн зүйл, хэсгийн "хүсэлт, гомдол, нэхэмжлэл гаргагчдын эд хөрөнгийн байдлыг харгалзан" гэдгийг тухайн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь өргөдөл, гомдол, нэхэмжлэл шийдвэрлүүлэх үйлчилгээ үзүүлсний төлөө хуульд заасан хэмжээний хураамжийг бүрэн буюу заримыг төлөх хөрөнгийн чадвартай эсэхийг харгалзан үзэхийг ойлгоно. Тэгэхдээ тухайн этгээдийн хөрөнгийн байдлыг иргэдийн хувьд Хүн амын орлогын албан татварын хуулийн 4 дүгээр зүйл, хууль тогтоомжийн бусдаахтад заасан орлоготой эсэх талаарх татварын албаны зохих байгууллага, банк, аж ахуйн нэгж, байгууллагын тодорхойлолт, бусад эд хөрөнгийн талаарх орон нутгийн засаг захиргааны байгууллагын тодорхойлолтоор, аж ахуйн нэгж, байгууллагын хувьд аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хуулийн 4 дүгээр зүйлд заасан орлоготой эсэх талаар Улсын татварын албаны зохих байгууллагын, дүрмийн

сан, үндсэн болон эргэлтийн хөрөнгийн талаар бүртгэлийн зохих байгууллагын тодорхойлолт, аж ахуйн нэгж, байгууллагын өөрсдийн тодорхойлолт, гэрээ, дүрэм, санхүү, нягтлан бодох бүртгэлийн баримт бичгээр, мөнгөн хөрөнгөний талаар харилцагч бүх банкны тодорхойлолтоор тус тус тогтоосон байвал зохино.

15. Улсын тэмдэгтийн хураамж төлөх хугацааг хойшлуулах, төлөх хэмжээг багасгах, чөлөөлөх асуудлыг шүүгчийн захирамжаар шийдвэрлэх бөгөөд нэхэмжлэл, хүсэлт, гомдол гаргагчийн төлбөл зохих байсан улсын тэмдэгтийн хураамжийг хариуцагчаас гаргуулан улсын орлогод оруулна.

16. Нэхэмжлэл, хүсэлтийг шийдвэрлэхтэй холбогдсон үйлчилгээ үзүүлсний төлөө хураах хураамжийг Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан хэмжээгээр авах бөгөөд харин гомдлоор авч хэлэлцэх хэргийг улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлнө.

17. Хуулийн 67 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "хэрэг үүсгэсний дараа нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсан, хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг зөвшөөрөн хүлээсэн" гэдгийг нэхэмжлэгч нэхэмжлэлийн бүх шаардлагаасаа бүрэн татгалзсан, хариуцагч нэхэмжлэлийн бүх шаардлагыг бүрэн зөвшөөрөн хүлээснийг, мөн зүйл, хэсгийн" зохигчид эвлэрэн хэлэлцээл" гэдгийг нэхэмжлэгч, хариуцагч нэхэмжлэлийн шаардлагын талаар харилцан тохиролцож нэхэмжлэгч нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгээс татгалзаж, түүнийг нь хариуцагч зөвшөөрөн хүлээснийг тус тус ойлгоно.

18. Хуулийн мөн зүйл, хэсгийн дагуу шүүгч нэхэмжлэгчийн татгалзал, хариуцагчийн зөвшөөрөл, зохигчдын эвлэрлийг баталж хэргийг хэрэгсэхгүй болгосон захирамж гаргахдаа нэхэмжлэлийн бүх шаардлагыг бүрэн дурдаж, нэхэмжлэгч өөрөө татгалзсан буюу хариуцагч нэхэмжлэлийн бүх шаардлагыг зөвшөөрөн хүлээсэн болохыг, харин эвлэрэн хэлэлцсэн тохиолдолд нэхэмжлэлийн шаардлагаас чухам алианаас нь буюу ямар хэмжээгээр нэхэмжлэгч татгалзаж, хариуцагч зөвшөөрөн хүлээсэн болохыг тодорхой шаардлага, нэхэмжлэлийн үнийн дүнг бичин нарийвчлан зааж байвал зохино.

19. Хуулийн 69 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "...шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах" гэдгийг шүүхээс гарах шийдвэрийг бодитойгоор гүйцэтгэх боломжийг хангахын тулд шүүхийн шийдвэр гаргах аас өмнө нэхэмжлэлийг хангах хэмжээгээр

хариуцагчийн өөрт нь болон бусдад байгаа эд хөрөнгийг бүгдийг буюу зарим хэсгийг битүүмжлэх, банкн дахь дансим зарлагын хөдөлгөөнийг зогсоох, хариуцагчаас буюу хариуцагчийн эд хөрөнгө, түүний дотор мөнгөн хөрөнгө байгаа иргэн, хуулийн этгээдээс тодорхой үйл ажиллагаа явуулах, тухайлбал эд хөрөнгийг худалдах, бусдад шилжүүлэх, эд хөрөнгийн бусад үүрэг биелүүлэхийг хориглох зэрэг хуульд заасан арга хэмжээ авахыг ойлгоно.

20. Хуулийн 75 дугаар зүйлийн 1 дүгээр заалтын "хэргийг хянан шийдвэрлэхэд хангалттай нотлох баримт цугларсан гэж талууд үзсэн" гэдгийг зохигчид хэргийн бодит байдлыг тогтооход зохих хэлбэрт орсон, ач холбогдол бүхий хангалттай нотлох баримт цугларсан гэж үзэж хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх хүсэлт гаргасныг, энэ хуулийн 71 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацаа дууссан" гэдгийг зохигчид өөрсдөө нотлох баримтаа гаргаж өгөх, цуглуулах үүргээ биелүүлсэн эсэх буюу шүүхэд нотлох баримт хангуулах хүсэлт гаргасан эсэхээс үл хамааран 60 хоногийн хугацаа өнгөрснийг, "шаардлагатай гэж үзсэн тохиолдолд" гэдгийг зохигчид хүсэлт гаргаагүй, хэрэг үүсгэснээс хойш 60 хоногийн хугацаа өнгөрөөгүй ч шүүх тухайн хэргийг хэлэлцэн шийдвэрлэхэд зохих хэлбэрт орсон, ач холбогдол бүхий хангалттай нотлох баримтуудыг цугларсан гэж шүүх үзсэнийг тус тус ойлгоно.

21. Хуулийн 82 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасны дагуу шүүгч дангаар хянан шийдвэрлэх хэрэгт Иргэний хуулийн 3 дугаар зүйлийн 1-д заасан хуульд заасан, хуульд заагаагүй боловч агуулгын хувьд хуульд үл харшлах иргэний эрх зүйн харилцаа бий болгох, сөрчлөх, шилжүүлэх, дуусганаар болгоход чиглэсэн бүх төрлийн гэрээнээс үүссэн маргаан, түүнчлэн Иргэний хуулийн 3 дугаар зүйлийн 6-д заасан иргэний эрх зүйн харилцаа үүсгэхэд чиглэгдсэн захиргааны шийдвэр, оюуны үнэт зүйл бүтээх, гэм хор учруулах, үндэслэлгүйгээр эд юмс олж авах эзэмшихээс бусад иргэний эрх зүйн харилцаа үүсгэхээр хуульд тусгайлан заасан бусад үндэслэлээр үүссэн маргаан тус тус хамаарна.

22. Хуулийн 92 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2-т заасан "шүүгч хэргийн болон шүүх хуралданид оролцогчдын төрөл садан" гэдэгт, шүүгч нь зохигчид, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч, түүнчлэн бусдын эрх, эрх чөлөө, ашиг сонирхлыг хянгалж шүүхэд мэдүүлсэн эрх бүхий иргэн, хуулийн этгээдийн

телеологчийн аль нэгний эхнэр, нөхөр, төрсөн болон үрчилж авсан эцэг, эх, хүүхэд, ах, эгч, дүү, өвөг, эцэг, эмэг эх, хадам эцэг, эх, ач, ээж байхыг "шүүх бүрэлдэхүүнд хоорондоо төрөл садангийн холбоотой хүмүүс орсон... гэдэгт тухайн хэргийг хинан шийдвэрлэх 3 шүүгчийн хоёр нь хоорондоо дээр дурдсан төрөл садангийн холбоотой байхыг тус тус ойлгоно.

23. Хуулийн 122 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2-ын "шүүхийн шийдвэр илт буруу зүйл бичигдсэн" гэдэгт шүүхийн шийдвэрт шүүгчийн болгоомжгүй ажиллагааны улмаас шүүхийн шийдвэрт хэргийн байдал, шүүхийн шийдвэрийг шүүх хуралдаан дээр нотлох баримтуудаар нотлогдсон бодит байдлаас нь илтэд зөрүүлж буруу бичсэнийг, "тооно алдаа" гэдэгт шүүхийн шийдвэрт цифрээр /тоо/ илэрхийлэгдэн бичигдэх зүйлийг цифрээр буюу бичгээр илэрхийлж бичихдээ дээрх шалтгаанаар шүүх хуралдаан дээр хэлцэгдсэн буюу нотлогдсон бодит байдлаас нь өөрөөр бичсэнийг тус тус ойлгох бөгөөд эдгээр алдааг шүүхийн шийдвэрийг дахин бичих буюу түүнийг засварлах замаар залруулж болно. Ийнхүү шүүхийн шийдвэрт засвар оруулсан тохиолдолд ямар засвар оруулсныг шүүхийн шийдвэрийн эцэст тодорхой бичин шүүх бүрэлдэхүүн гарын үсэг зурж, тамга даран баталгаажуулна.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ  
ШҮҮГЧ

Д.ДЭМБЭРЭЛЦЭРЭН  
Ж.ДАШДОРЖ